

# МОНГОЛ УЛС: ЦАГ ХУГАЦААНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН - 2019 ОН



## Дэмжигч байгууллагууд:



Улаанбаатар хот

2020 оны 10 дугаар сар

# ТОВЪЁОГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	iii
ТАЛАРХАЛ .....	v
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	vi
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	vii
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ .....	1
ЦАГ ХУГАЦААНЫ СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ .....	7
Судалгааны зорилго, ач холбогдол .....	7
Судалгааны хамрах хүрээ .....	8
СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, ҮЕ ШАТ .....	11
Үе шат 1: ЦХС-ны бэлтгэл ажил .....	11
Үе шат 2: ЦХС-ны мэдээллийг цуглуулах, нэгтгэх, өгөгдлийг ДГБ-ын мэдээллийн баазад оруулах .....	16
Үе шат 3: Судалгааны өгөгдлийн боловсруулалт, дүн шинжилгээ, тайлан, зөвлөмж боловсруулах .....	17
ЦАГ ХУГАЦААНЫ СУДАЛГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	18
1. АГААРЫН ТЭЭВЭРЛЭЛТ .....	23
1.1. АГААРЫН ТЭЭВРЭЭР ГАРГАХ ЭКСПОРТ .....	24
1.1.1. Барааг нисэх буудлын карго терминалаас экспортлох үйл ажиллагаа .....	24
1.1.2. Агаарын тээврээр гаргах “захиалга дуудлага”-ын экспортын үйл ажиллагаа .....	28
1.2. АГААРЫН ТЭЭВРЭЭР ОРУУЛАХ ИМПОРТ .....	29
2. АВТО ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ .....	36
2.1. АВТО ТЭЭВРЭЭР ГАРГАХ ЭКСПОРТ .....	37
2.1.1. Хилийн боомтоос авто замаар бараа экспортлох үйл ажиллагаа .....	38
2.1.2. Гүний терминалаас ирсэн экспортын барааг хилийн боомтоор гаргах үйл ажиллагаа .....	42
2.1.3. Авто тээврээр гаргах “захиалга дуудлага”-ын экспорт: Гүний терминал дах бүрдүүлэлтийн үйл ажиллагаа .....	43
2.2. АВТО ТЭЭВРЭЭР ОРУУЛАХ ИМПОРТ .....	48
2.2.1. Авто тээврээр оруулсан импортын бараа хилийн боомт дээр олгогдох үйл ажиллагаа .....	48
2.2.2. Авто тээврээр оруулсан ачаа барааг гүний терминал руу шилжүүлэх хилийн боомтын үйл ажиллагаа .....	67
2.2.3. Гүний терминал дээр барааг эзэнд нь олгох үйл ажиллагаа .....	69
2.2.4. Хилийн боомтоос гүний терминалд авто тээврээр ирсэн ачаа барааг эзэнд нь олгох үйл ажиллагаа .....	74

3.	ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ .....	81
3.1.	ТӨМӨР ЗАМААР ОРУУЛСАН ИМПОРТЫН БАРАА ГҮНИЙ АБТЭМА ТЕРМИНАЛ РУУ АЧИГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	82
3.2.	ТӨМӨР ЗАМААР ОРЖ ИРСЭН ИМПОРТЫН БАРАА АБТЭМА ГҮНИЙ ТЕРМИНАЛ ДЭЭР ОЛГОГДОХ .....	86
3.3.	АВТО ЗАМААР ОРЖ ИРСЭН ЧИНГЭЛЭГ ТӨМӨР ЗАМААР ШИЛЖҮҮЛЭГДЭН АЧИГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	94
4.	ИМПОРТ, ЭКСПОРТЫН ГЭРЧИЛГЭЭ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОДОГ БАЙГУУЛЛАГУУД: ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	102
5.	ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	107
5.1.	ДҮГНЭЛТ .....	107
5.2.	ЗӨВЛӨМЖ .....	112
	Хавсралт 1. Хилийн хяналтын байгууллагууд, үүрэг оролцоо, хамтын ажиллагаа .....	118
	Хавсралт 2. Хилийн боомтуудын талаарх товч танилцуулга .....	124
	Хавсралт 3. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны технологийн дэс дарааллын зураглал .....	127
	Хавсралт 4. Цаг хугацааны судалгааны асуулга хуудас .....	169
1.	Авто замаарх импорт- Ачаа бараа хил дээр олгогдох .....	170
2.	Авто замаарх импорт- Ачаа бараа Монгол Транс гүний терминал дээр олгогдох ...	177
3.	Авто замаар орж ирсэн чингэлэг төмөр замаар шилжүүлэгдэн ачигдах –Хилийн боомт дээрх хяналтын ажиллагаа .....	182
4.	Төмөр замаар орж ирсэн импортын ачаа бараа АБТЭМА гүний терминал руу ачигдах .....	187
5.	Төмөр замаар орж ирсэн импортын ачаа бараа АБТЭМА гүний терминал дээр олгогдох .....	191
6.	Авто замаарх экспорт - Ачаа барааг хилийн боомтоос экспортлох .....	197
7.	Авто замаар гарах экспортын ачаа барааны бүрдүүлэлт- Монгол Транс .....	203
8.	Захиалга дуудлага – Авто зам, агаараар гаргах экспорт .....	208
9.	Агаараар оруулах импорт .....	214
10.	Агаараар гаргах экспорт .....	220
11.	Экспорт, импорттой холбоотой гэрчилгээ, зөвшөөрөлд зарцуулагдаж буй хугацааг тодорхойлох нь .....	224

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>АБТЭМА</b>	Ачиж буулгах тээвэр экспедицийн механикжсан анги гүний терминал
<b>АВХ</b>	Ачаа вагон хүлээлцэгч
<b>АЗШНЦ</b>	Авто замын шалган нэвтрүүлэх цогцолбор
<b>АНУ ОУХА</b>	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
<b>ББ</b>	Бичиг баримт
<b>ББГУБ</b>	Бичиг баримтын гаалийн улсын байцаагч
<b>ГБМ</b>	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн
<b>ГБӨ</b>	Гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа
<b>ГЕГ</b>	Гаалийн ерөнхий газар
<b>ГУАБ</b>	Гаалийн улсын ахлах байцаагч
<b>ГУБ</b>	Гаалийн улсын байцаагч
<b>ГТЛ</b>	Гаалийн төв лаборатори
<b>ГХБ</b>	Гаалийн хяналтын бүс
<b>ДБГ</b>	Дэлхийн Банк Групп
<b>ДГБ</b>	Дэлхийн Гаалийн Байгууллага
<b>ДХБ</b>	Дэлхийн Худалдааны Байгууллага
<b>ЗҮ</b>	Замын-Үүд
<b>МИАТ</b>	Монголын иргэний агаарын тээвэр
<b>МТ</b>	Монгол Транс гүний терминал
<b>МХЕГ</b>	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
<b>МХУБ</b>	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
<b>МҮХАҮТ</b>	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
<b>МЭЕГ</b>	Мал эмнэлгийн ерөнхий газар
<b>НМХГ</b>	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
<b>НЦШАА</b>	Нарийн царигийн шилжүүлэн ачих анги
<b>ОУМЭГ</b>	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ
<b>ОУСК</b>	Олон Улсын Санхүүгийн Корпораци
<b>ОУНБ</b>	Олон улсын нисэх буудал

<b>УБГГ</b>	Улаанбаатар хотын гаалийн газар
<b>СХЗГ</b>	Стандарт, хэмжил зүйн газар
<b>ХМХ</b>	Хилийн мэргэжлийн хяналт
<b>ХМХУБ</b>	Хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч
<b>ХХЕГ</b>	Хил хамгаалах ерөнхий газар
<b>ХХҮХ</b>	Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо
<b>ХХХ</b>	Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр
<b>ХШГУАБ</b>	Хяналт шалгалтын гаалийн улсын ахлах байцаагч
<b>ХШГУБ</b>	Хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч
<b>ЦХС</b>	Цаг хугацааны судалгаа
<b>ЧШРТТ</b>	Чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмж
<b>ШАА</b>	Шилжүүлэн ачих анги
<b>ШНКК</b>	Шинэчлэн найруулсан Киотогийн конвенци
<b>CAIS</b>	Customs Automated Information System (Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем)
<b>CEPS</b>	Customs External Portal System (Гаалийн гадаад холболтын систем)
<b>CSV</b>	Comma Separated Values (файлын өргөтгөл)

## ТАЛАРХАЛ

Цаг хугацааны судалгаа-2019 тайланг Дэлхийн Банк Группын гишүүн Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ийн “Худалдааг хөнгөвчлөх, хөдөө аж ахуйн экспортын өрсөлдөх чадвар” төслийн хүрээнд Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран хийж гүйцэтгэсэн болно.

ОУСК-ийн Хувийн хэвшлийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, төслийн удирдагч Д.Жигжидмаагаар ахлуулсан Цаг хугацааны судалгааг хэрэгжүүлэх багт ОУСК-ийн Европ, Төв Азийн Худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийн менежер Вайолин Конар-Лииси, ОУСК-ийн зөвлөх Робэрт Эндрю Стрүтэрс, зөвлөх Бранкица Обучина, зөвлөх С.Норжинсүрэн, бодлогын шинжээч Г.Мэндсайхан, ГЕГ-ын Гаалийн хяналт шалгалтын газрын гаалийн улсын байцаагч Г.Оюунчимэг, О.Мөнхзул, тус газрын гаалийн улсын ахлах байцаагч С.Отгонпүрэв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Д.Түмэндэмбэрэл, Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газрын ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын ахлах байцаагч Э.Уламбаатар нар орж ажилласан болно.

Цаг хугацааны судалгааны мэдээлэл, өгөгдлийг Дэлхийн Гаалийн Байгууллагын мэдээллийн баазад хөрвүүлэн оруулахад мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлсэн Дэлхийн Гаалийн Байгууллагын Төслийн менежер, бизнес аналитист Энди Кларкт ОУСК-ийн Төслийн зүгээс талархсанаа илэрхийлж байна.

Судалгааг амжилттай зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар ханган дэмжлэг үзүүлж ажилласан Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдлагууд, судалгаанд гар бие оролцож туслалцаа үзүүлсэн Буянт-Ухаа, Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур, Сүхбаатар хилийн боомт, төмөр замын өртөөд, Улаанбаатар хотын гаалийн газар, гүний гаалийн АБТЭМА, Монгол Транс терминалууд дахь гаалийн болон хилийн мэргэжлийн хяналтын газар, салбар, албадын удирдлага, улсын байцаагчид, түүнчлэн Хил хамгаалах ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Улаанбаатар төмөр зам, Монголын иргэний агаарын тээвэр, тэдгээрийн харьяа байгууллагуудын удирдлага, мэргэжилтэн, албан хаагчдад судалгааны баг хамт олны зүгээс гүн талархал илэрхийлье.

Түүнчлэн судалгаа авахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан авто тээвэрлэгчид, тээврийн болон гаалийн зуучлагчид, терминалын ажилтнууд, худалдаа эрхлэгч нарт баярлаж талархсанаа илэрхийлье.

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаа хийхээр сонгогдсон хилийн боомт, гүний терминал, тээвэрлэлтийн хэлбэр, худалдааны горимоор.....	8
Хүснэгт 2. Цуглуулсан судалгааны тоо: Худалдааны горим, байршил, тээвэрлэлтийн төрөл, хилийн болон гүний терминалаар .....	10
Хүснэгт 3. ЦХС-ны асуулга хуудас: Тээвэрлэлтийн төрөл, худалдааны горимд хамаарах гаалийн хяналтын процедурын төрлөөр .....	13
Хүснэгт 4. Барааг хилээр оруулах, гаргахад зарцуулагдаж буй нийт дундаж хугацаа...	18
Хүснэгт 5. Хилийн хяналтын процедур, тэдгээрт хамаарах үйл явцын ангилал, худалдааны горимоор .....	19
Хүснэгт 6. Экспорт, импортын барааны гаалийн хяналт, бүрдүүлэлтийн дүн: Илэрсэн зөрчил, лабораторийн шинжилгээ, мэдүүлэг болон манифестийн алдаа.....	22
Хүснэгт 7. Экспорт, импортын барааны хилийн мэргэжлийн хяналтын дүн: Хяналтанд хамрагдсан байдал, лабораторийн шинжилгээ, илэрсэн зөрчил .....	22
Хүснэгт 8. Агаарын тээвэрлэлт: Барааг импортлох, экспортлох үйл ажиллагаанд тавих хяналтын нийт дундаж хугацаа .....	23
Хүснэгт 9. Буянт-Ухаа хилийн боомт: Барааг карго терминалаас экспортлоход зарцуулагдаж буй дундаж хугацааг .....	24
Хүснэгт 10. Агаараар орж ирж буй импорт: Гаалийн алдаатай мэдүүлгийг засварлах дундаж хугацаа.....	34
Хүснэгт 11. Авто замаар гарах экспорт: Экспортын дундаж хугацаа, хилийн боомтоор .....	37
Хүснэгт 12. Авто тээврээр орж ирсэн импортын бараа хил дээр олгогдох үйл ажиллагааны дундаж хугацааны задаргаа, хилийн боомт, терминалаар .....	49
Хүснэгт 13. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	51
Хүснэгт 14. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Алдаатай гаалийн мэдүүлгийн тоо, мэдүүлгийг засварласан дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	60
Хүснэгт 15. Авто замаарх импорт-Хил дээр олгогдох: Татвар төлөлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, хилийн боомт, терминалаар.....	65
Хүснэгт 16. Судалгаанд хамрагдсан байгууллагаас олгож буй гэрчилгээ, судалгааны хугацаанд олгогдсон гэрчилгээний тоо .....	102

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ЦХС-ны цикл- ДГБ-ын аргазүй.....	11
Зураг 2. Агаарын тээвэрлэлтийн асуулга судалгааны тоо .....	23
Зураг 3. Агаараар гарах экспортын үйл ажиллагааны нийт дундаж хугацаа, үйл явц тус бүрээр .....	24
Зураг 4. Агаараар гарах экспортын үйл ажиллагаа, үйл явцын эзлэх хувиар.....	25
Зураг 5. Агаараар гарах экспорт: Хилийн мэргэжлийн хяналтын биет үзлэгийн дундаж хугацаа, хяналтын төрлөөр .....	25
Зураг 6. Агаараар гарах экспорт: ХМХ-ын бичиг баримтын шалгалт болон биет үзлэгийн нийт дундаж хугацаа .....	26
Зураг 7. Агаараар гарах экспорт: ХМХ-ын үйл явц хоорондын хүлээлгийн дундаж хугацаа .....	26
Зураг 8. Агаарын тээврээр гарах экспорт: Гаалийн үйл ажиллагааны нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлвөөр .....	27
Зураг 9. Агаарын тээврээр гарах экспорт: Гаалийн үйл явц тус бүрийн дундаж хугацаа .....	27
Зураг 10. Агаараар гарах экспорт: Гаалийн үйл явц хоорондын хүлээлгийн дундаж болон хамгийн их хугацаа.....	28
Зураг 11. Агаараар гарах экспорт: Ачааг тээвэрлэлтэд бэлтгэх үйл ажиллагааны нийт дундаж болон хамгийн их хугацаа, үйл явц тус бүрээр .....	28
Зураг 12. Агаараар гарах “захиалга дуудлага”-ын экспортын үйл ажиллагааны нийт хугацаа, хяналтын үйл ажиллагаагаар .....	29
Зураг 13. Агаараар гарах “захиалга дуудлага”-ын экспорт: Экспортын хяналтын үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн дундаж хугацаа.....	29
Зураг 14. Агаараар орж ирж буй импорт: Ачаа бараа хилийн боомт дээр эзэндээ олгогдох нийт дундаж хугацаа, үйл ажиллагаагаар .....	30
Зураг 15. Агаараар орж ирж буй импорт: Нийт хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, хувиар.....	30
Зураг 16. Агаараар орж ирж буй импорт: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа.....	31
Зураг 17. Агаараар орж ирэх импорт: Манифестийн мэдээллийг шалгахад зарцуулагдаж буй дундаж хугацаа .....	31
Зураг 18. Агаараар орж ирж буй импорт: ХМХ-ын нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр.....	32
Зураг 19. Агаараар орж ирж буй импорт: ХМХ-ын нийт дундаж хугацаа, үйл ажиллагаа тус бүрээр.....	32
Зураг 20. Агаараар орж ирж буй импорт: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, хяналтын төрлөөр .....	33
Зураг 21. Агаараар орж ирж буй импорт- Ачаа бараа хил дээр олгогдох: Бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, бараа бүтээгдэхүүний төрлөөр.....	34
Зураг 22. Агаараар орж ирж буй импорт-ачаа бараа хил дээр олгогдох: Гаалийн хяналт, шалгалтын нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр .....	35
Зураг 23. Авто тээврийн импорт, экспортын асуулга судалгааны тоо .....	36



Зураг 24. Авто замын экспорт: Хилийн боомт дах нийт дундаж хугацаа, хилийн боомтоор .....	38
Зураг 25. Авто замын экспорт-Замын-Үүд: ХМХ-нд хамрагдсан ачаа барааны эзлэх хувь.....	38
Зураг 26. Авто замын экспорт: Хилийн мэргэжлийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, үйл ажиллагаа, хилийн боомтоор.....	39
Зураг 27. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, хилийн боомтоор.....	39
Зураг 28. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн дундаж хугацаа, үйл ажиллагаа бүрээр, хилийн боомтоор .....	40
Зураг 29. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналт шалгалтын дундаж хугацаа, хилийн боомт, бүтээгдэхүүний төрлөөр.....	40
Зураг 30. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилт, хилийн боомтоор.....	41
Зураг 31. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл явц хоорондын хүлээлгийн дундаж хугацаа, хилийн боомтоор .....	41
Зураг 32. Авто замын экспорт-Гүний терминалаас ирсэн ачаа бараа: Замын-Үүд хилийн боомт дах дундаж хугацаа.....	42
Зураг 33. Авто замын экспорт-Гүний терминалаас Замын-Үүд хилийн боомт дээр ирж экспортлох дундаж хугацаа, үйл ажиллагаа тус бүрээр.....	42
Зураг 34. Захиалга дуудлага-Авто замаар гарах экспорт: Нийт хяналт шалгалтын дундаж хугацаа.....	43
Зураг 35. Захиалга дуудлага-Авто замын экспорт: Мэргэжлийн хяналтын биет болон бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа.....	44
Зураг 36. Захиалга дуудлага- Авто замын экспорт: Хамтарсан болон дангаар хийсэн биет үзлэгийн дундаж хугацаа.....	44
Зураг 37. Захиалга дуудлага-Авто замын экспорт: МХ-ын үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн дундаж хугацаа .....	45
Зураг 38. Захиалга дуудлага- Авто замын экспорт: Гаалийн шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр .....	45
Зураг 39. Захиалга дуудлага – Авто замын экспорт: Гаалийн бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр.....	46
Зураг 40. Захиалга дуудлага- Авто замын экспорт: Гаалийн лабораторит дээж өгч хариу авахад зарцуулагдсан дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр.....	46
Зураг 41. Захиалга дуудлага-Авто замын экспорт: Барааг гүнд ГХБ-ээс гаргасан дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр .....	47
Зураг 42. Захиалга дуудлага-Авто замын экспорт: Гаалийн биет шалгалт, ачилтанд хяналт тавьсан дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрөл, эрсдэлийн төлөвөөр .....	47
Зураг 43. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Хилийн боомт дээрх хяналтын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	49
Зураг 44. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Тээврийн хэрэгслийг хяналтанд авах, халдваргүйтэл хийх дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	50
Зураг 45. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХШГУБ бичиг баримтыг гаалийн хяналтанд авч баталгаажуулсан дундаж хугацаа.....	50
Зураг 46. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдахгүй бараа, нийт импортын ачаа бараанд эзлэх хувиар.....	51

Зураг 47. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	51
Зураг 48. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Их, дунд эрсдэлтэй ачаа барааг биет үзлэгт бэлтгэх дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар.....	52
Зураг 49. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор .....	52
Зураг 50. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр .....	53
Зураг 51. Авто замын импорт-Алтанбулаг, Цагааннуур боомт дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр.....	53
Зураг 52. Авто замаарх импорт- ЗҮ ЧШРТГТ дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр.....	54
Зураг 53. Авто замаарх импорт- Замын-Үүдийн ГХБ дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр, ГХБ-ээр .....	54
Зураг 54. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын Гаальтай хамтран хийсэн биет шалгалтын нийт дундаж цаг .....	55
Зураг 55. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, хилийн боомт, терминалаар, .....	55
Зураг 56. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-нд зарцуулсан нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалуудаар.....	56
Зураг 57. Авто замын импорт -Хил дээр олгогдох: Дунд эрсдэлтэй ачаа барааны ХМХ-ын дундаж хугацаа, хяналтын төрлөөр.....	56
Зураг 58. Авто замын импорт - Хил дээр олгогдох: Их эрсдэлтэй ачаа барааны ХМХ-ын дундаж хугацаа, хяналтын төрлөөр.....	56
Зураг 59. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын лабораторийн шинжилгээний дундаж хугацаа, барааны төрлөөр, хилийн боомтоор .....	57
Зураг 60. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын байцаагч бүтээгдэхүүнээс дээж авч лабораторийн шинжилгээнд явуулсан дундаж хугацаа, хяналтын төрлөөр ....	58
Зураг 61. Авто замын импорт: Хил дээр олгогдох ачаа барааны гаалийн хяналтын нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	58
Зураг 62. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Импортын бүтээгдэхүүний төрөл, хувиар.....	59
Зураг 63. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Гаалийн хяналтын нийт дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр.....	59
Зураг 64. Авто замын импорт- Хил дээр олгогдох: ГБМ мэдүүлэг бэлтгэх, алдаатай мэдүүлгийг хянан засварлуулах дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	60
Зураг 65. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор, бүх хилийн боомт .....	61
Зураг 66. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын дундаж хугацаа, барааны төрлөөр, бүх хилийн боомт .....	61
Зураг 67. Авто замын импорт-Алтанбулаг, Цагааннуур боомт дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын нийт дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор.....	62
Зураг 68. Авто замын импорт- Алтанбулаг, Цагааннуур боомт дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын нийт дундаж хугацаа, барааны төрлөөр .....	63

Зураг 69. Авто замын импорт-Замын-Үүдийн ЧШРТТ, АЗШНЦ-103 дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын нийт дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор.....	63
Зураг 70. Авто замын импорт- ЗҮ-ЧШРТТ дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын нийт дундаж хугацаа, барааны төрлөөр.....	64
Зураг 71. Авто замын импорт- ЗҮ Дардан, Э-Транс, АЗШНЦ103 дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын нийт дундаж хугацаа, барааны төрлөөр.....	64
Зураг 72. Авто замаарх импорт-ЗҮ Дардан, Э-Транс дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын нийт дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор.....	65
Зураг 73. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Гаалийн бичиг баримт болон биет шалгалтын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	66
Зураг 74. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Гаалийн лабораторийн шинжилгээний дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	66
Зураг 75. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХШГУБ дээж авч лабораторийн дүгнэлт авсан дундаж хугацаа, барааны төрлөөр, хилийн боомтоор .....	67
Зураг 76. Авто замын импорт- Хил дээр олгогдох: ГХБ-ээс гарах зөвшөөрлийн хуудас олгосон нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	67
Зураг 77. Авто замын импорт- Гүн рүү шилжүүлэгдэх: Гүний гааль дээр олгогдох ачаа барааны хилийн боомт дах нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	68
Зураг 78. Авто замын импорт - Гүн рүү шилжүүлэгдэх: Гүний гааль дээр олгогдох ачаа барааны хилийн боомт дээрх ХМХ-ын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар ..	68
Зураг 79. Авто замын импорт - Гүн рүү шилжүүлэгдэх: Гүний гааль дээр олгогдох ачаа барааны хилийн боомт дах гаалийн хяналтын дундаж хугацаа.....	69
Зураг 80. Авто замын импорт-Монгол Транс: Гүний терминалын нийт дундаж хугацаа, хяналтын процедураар.....	69
Зураг 81. Авто замын импорт-Гүний терминал: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа, үйл явц тус бүрээр.....	70
Зураг 82. Авто замын импорт-Гүний терминал: МХ-ын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, хяналтын процедур тус бүрээр .....	70
Зураг 83. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр .....	71
Зураг 84. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, үйл ажиллагаагаар .....	71
Зураг 85. Авто замын импорт-Гүний терминал: ГБМ мэдүүлгийн мэдээллийг системд оруулсан болон хүлээлгийн дундаж хугацаа .....	72
Зураг 86. Авто замын импорт-Гүний терминал: Гааль бичиг баримтыг хүлээж авснаас хойш хянаж эхлэх хүртэлх хүлээлгийн нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр .....	72
Зураг 87. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, бараа бүтээгдэхүүний төрлөөр .....	73
Зураг 88. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн биет шалгалтын дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр.....	73
Зураг 89. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн биет шалгалтын дундаж хугацаа, барааны нэр төрлийн тоогоор.....	74

Зураг 90. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Хилийн боомтоос илгээгдэн гүний терминал дээр ачаа олгогдсон нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар .....	75
Зураг 91. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Гүний терминалын дундаж хугацаа, хилийн боомт, Замын-Үүдийн терминалаар .....	75
Зураг 92. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар.....	76
Зураг 93. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: МХ-ын дундаж хугацаа, үйл ажиллагаагаар.....	76
Зураг 94. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Нийт хяналтын дундаж хугацаа, үйл ажиллагаагаар, хилийн боомтоор.....	77
Зураг 95. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр .....	77
Зураг 96. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, бүх ачаа бараа.....	78
Зураг 97. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр.....	79
Зураг 98. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Биет шалгалтын дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр.....	79
Зураг 99. Төмөр зам болон шилжүүлэн ачилтын импортын асуулга судалгааны тоо ....	81
Зураг 100. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Хилийн боомтын үйл ажиллагааны дундаж хугацаа .....	82
Зураг 101. Төмөр замын импорт -Хилийн боомт, өртөө: Хилийн боомт дах үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн хяналтын байгууллага тус бүрээр.....	83
Зураг 102. Төмөр замын импорт -Хилийн боомт, өртөө: Хилийн мэргэжлийн хяналтын бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, хилийн өртөөгөөр.....	83
Зураг 103. Төмөр замын импорт -Хилийн боомт, өртөө: Гааль бичиг баримтыг хяналтанд авсан, төмөр замын мэдүүлэгч манифест бичсэн дундаж хугацаа, хилийн боомтоор .....	84
Зураг 104. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Манифест бичих, шалгах дундаж хугацаа, хилийн боомтоор.....	85
Зураг 105. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Вагон шилжүүлэн ачих, ГУБ манифестийг зөвшөөрөх үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомтоор .....	85
Зураг 106. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Галт тэрэг хөдлөх хүртэлх төмөр замын үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомтоор .....	86
Зураг 107. Төмөр замын импорт-АБТЭМА: Ачаа бараа гүний терминал дээр олгогдох дундаж хугацаа, хилийн хяналтын байгууллагуудаар .....	87
Зураг 108. Төмөр замын импорт-АБТЭМА: Гүний терминал дээр эзэндээ олгогдсон бараа бүтээгдэхүүн, хувиар.....	87
Зураг 109. Төмөр замын импорт-АБТЭМА: МХ-ын дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр, хилийн өртөөгөөр .....	88
Зураг 110. Төмөр замын импорт-АБТЭМА: МХ-ын нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр.....	89
Зураг 111. Төмөр замын импорт-АБТЭМА: МХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, бүтээгдэхүүнээр .....	89

Зураг 112. Төмөр замын импорт-АБТЭМА: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн дундаж хугацаа, үйл ажиллагаагаар (Замын-Үүд, Сүхбаатар хилийн өртөө) .....	90
Зураг 113. Төмөр замын импорт-АБТЭМА: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр (Замын-Үүд, Сүхбаатар) .....	90
Зураг 114. Төмөр замын импорт-АБТЭМА: Гаалийн эрсдэлийн хувиарлалт ба гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр .....	91
Зураг 115. Төмөр замын импорт-АБТЭМА: Бичиг баримтын бүрдүүлэлтийн дундаж хугацаа, АБТЭМА терминал болон УБГГ-ын бичиг баримт бүрдүүлэлтийн алба .....	92
Зураг 116. Төмөр замын импорт-АБТЭМА: Биет шалгалтын дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр (ЗҮ, Сүхбаатар) .....	93
Зураг 117. Төмөр замын импорт-АБТЭМА: ГХБ-ээс гарах зөвшөөрөл авсан ачаа барааны терминалын хашаан дах дундаж хугацаа .....	93
Зураг 118. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт- Хилийн боомт: Хилээр орж ирсэн барааг гүнийн терминал дээр олгох нийт дундаж хугацаа .....	94
Зураг 119. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: ГХБ дэх хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, хяналтын байгууллага тус бүрээр .....	95
Зураг 120. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа, үйл явц тус бүрээр .....	95
Зураг 121. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: ХМХяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр .....	96
Зураг 122. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: Гаалийн хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр .....	96
Зураг 123. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-НЦШАА: Гаалийн хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр .....	97
Зураг 124. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-НЦШАА: Гаалийн хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр .....	97
Зураг 125. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-НЦШАА: Төмөр замын хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр .....	98
Зураг 126. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Гүний ГХБ дэх хяналтын нийт дундаж хугацаа, хяналтын байгууллага тус бүрээр .....	98
Зураг 127. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Мэргэжлийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, хяналтын төрлөөр, ажиллагаа тус бүрээр .....	99
Зураг 128. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Гаалийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр .....	100
Зураг 129. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Гаалийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр .....	100
Зураг 130. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Ачаа барааг тээврийн хэрэгсэлд ачин ГХБ-ээс гаргасан дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр .....	101
Зураг 131. Гэрчилгээ, зөвшөөрөл авахад шаардагдах дундаж хугацаа, судалгаанд хамрагдсан байгууллага тус бүрээр .....	102
Зураг 132. МЭЕГ: ОУМЭГ-ээг олгох дундаж хугацаа, үйл ажиллагаагаар .....	104
Зураг 133. МХЕГ: Экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох дундаж хугацаа, үйл ажиллагаагаар .....	104
Зураг 134. СХЗГ: Тохирлын гэрчилгээ, экспортын гэрчилгээ олгох дундаж хугацаа, үйл ажиллагаагаар .....	105

Зураг 135. МҮХАҮТ: Гарал үүслийн гэрчилгээ олгох дундаж хугацаа, үйл  
ажиллагаагаар..... 106

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааг барааг импортлох, экспортлоход зарцуулагдаж байгаа бодит цаг хугацааг хэмжих, гадаад худалдаанд оролцогч талууд (төрийн хяналтын болон хувийн хэвшлийн байгууллагууд)-ын үйл ажиллагааны уялдаа холбоо, гүйцэтгэлийг сайжруулах, түүнчлэн Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангах, улмаар худалдааг хөнгөвчлөх үйл явцыг гүнзгийрүүлэх зорилгоор хийж гүйцэтгэсэн болно.

Олон улсын худалдааны барааг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд учирч буй аливаа саад тотгорыг бууруулж, энэхүү үйл ажиллагааг хялбарчлан уялдуулснаар дотоодын эдийн засаг, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмждэг болохыг олон тооны судалгаа болон олон улсын туршлагаас харж болно. Цаг хугацааны судалгаа (ЦХС) нь экспорт, импортын барааг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой үйл явцыг нарийвчлан хэмжихэд чиглэсэн өвөрмөц арга хэрэгсэл болохын хувьд барааг улсын хилээр оруулах, гаргахад худалдаа, бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудыг олж тогтоох, улмаар шийдвэрлэх арга замыг санал болгохоос гадна хилийн хяналтын байгууллагуудын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ, бодлого, шийдвэрийг гаргах, тэдгээрийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах, сурталчлах боломжийг олгодог.

Цаг хугацааны судалгааг Гаалийн ерөнхий газар 2010 оноос хойш 2 жил тутамд бие даан хийж ирсэн бөгөөд 2012 онд уг судалгааг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн туслалцаатайгаар хийж гүйцэтгэсэн байна. Гэсэн хэдий ч гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг уялдуулах, худалдааг хөнгөвчлөх чиглэлд бодитой өөрчлөлт дэвшил гараагүй байна.

Энэхүү цаг хугацааны судалгааг Дэлхийн Банк Групп (ДБГ)-ын гишүүн Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ийн “Худалдааг хөнгөвчлөх, хөдөө аж ахуйн экспортын өрсөлдөх чадвар” Төслийн туслалцаатайгаар Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ)-ын аргагүй, зааварчилгаа болон мэдээлэл боловсруулалтын цахим программ хангамжинд тулгуурлан хийж гүйцэтгэсэн. ЦХС-ны мэдээлэл цуглуулах асуулга судалгааг 2019 оны 10 дугаар сарын 8-16-ны өдрүүдэд Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур, Сүхбаатар өртөө, Буянт-Ухаа хилийн боомтууд, АБТЭМА, Монгол Транс гүний терминал болон Улаанбаатар хотын гаалийн газарт хийж гүйцэтгэсэн ба дээрх хугацаанд авто зам, төмөр зам<sup>1</sup>, агаарын тээврээр оруулсан болон гаргасан бүх импорт, экспортын үйл ажиллагааг хамруулсан болно. Түүнчлэн худалдаа эрхлэгч барааг импортлох болон экспортлоход холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас олгодог гэрчилгээ, зөвшөөрлийг авахад зарцуулагддаг дундаж цаг хугацааг тус судалгаагаар тогтоосон болно.

Судалгааны асуулга хуудсыг тээврийн хэрэгсэл гаалийн хяналтын бүсэд орох үеэс барааг эзэнд нь олгох, эсхүл улсын хилээр гаргах хүртэлх хугацаанд тээврийн эсхүл илгээлтийг дагалдах худалдааны бичиг баримтад дагалдуулсан. Дээрх үйл ажиллагаанд

---

<sup>1</sup> Судалгааны хугацаанд төмөр замаар гарах экспортыг авч үзээгүй болно.

оролцогч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын холбогдох улсын байцаагч, ажиллагсад судалгааны асуулгын өөрт хамараах үйл явц тус бүрээр цаг хугацааг бөглөж бичсэн. Судалгааны асуулга хуудсыг тараах, бөглөх явцад хяналт тавих, бөглөгдсөн судалгааны хуудсыг хураан авах, цугларсан мэдээлэл, өгөгдлийг ДГБ-ын цахим мэдээллийн баазад оруулах зэрэг ажлыг судалгааны гэрээт гүйцэтгэгч “МЭЖ” ХХК-ны судлаач, тоологч нар ЦХС-ны багийн удирдлага, хяналтан дор хийж гүйцэтгэсэн болно.

ЦХС-ааг хийх байршил буюу хилийн боомт, гүний терминалыг гаалийн мэдүүлгийн статистик мэдээлэлд үндэслэн ЦХС-ны ажлын хэсэгтэй зөвшилцсөний үндсэн дээр сонгосон. Гадаад худалдааны бараа эргэлт хэвийн үргэлжилдэг боломжит хугацааг сонгож мэдээлэл цуглуулсан болно.

Асуулга судалгааны явцад буюу ажлын 7 өдөрт нийт 2142 асуулга хуудас тараагдсанаас 1993 асуулга цуглуулсан бөгөөд бүрэн гүйцэт бөглөгдсөн буюу хүчинтэй гэж тооцогдсон 1725 асуулга судалгааг нэгтгэн ДГБ-ын цахим мэдээллийн баазад оруулж дүн шинжилгээ, боловсруулалт хийгдсэн болно.

### **Судалгааны дүн шинжилгээний үр дүн**

ЦХС-аар барааг улсын хилээр оруулах эсхүл гаргах үйл ажиллагаанд оролцдог, түүнчлэн төрийн хяналтыг хэрэгжүүлдэг байгууллагууд, тухайлбал Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улаанбаатар төмөр зам, Монголын иргэний агаарын тээвэр, тэдгээрийн харьяа байгууллагууд, Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, экспортлогч, импортлогч, тээвэрлэгчид, тээвэр зууч, гаалийн зуучлагчид зэрэг худалдаанд оролцогч бүх талыг хамруулан тэдгээрийн үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хугацааг тээврийн хэрэгслийн бүх төрлөөр, экспорт болон импортоор, үйл явц тус бүрээр шинжлэн тогтоосон бөгөөд экспорт, импортын үйл ажиллагааны бүрэн зураглалын нэгтгэсэн дундаж цаг хугацаа дараах байдлаар гарав. Үүнд:

- Хилийн боомтоор **авто тээврээр орж ирсэн импортын** ачаа бараа гүний терминал дээр тээвэрлэгдэн ирж эзэндээ олгогдох нийт дундаж хугацаа: **3 өдөр 12 цаг 7 минут**
- Хилийн боомтоор **авто тээврээр орж ирсэн импортын чингэлэг төмөр замаар шилжүүлэн ачигдаж** гүний терминал руу тээвэрлэгдэн эзэндээ олгогдох нийт дундаж хугацаа: **3 өдөр 40 минут**
- **Төмөр замаар хилээр орж ирсэн импортын** ачаа бараа гүний терминал дээр тээвэрлэгдэн ирж эзэндээ олгогдох нийт дундаж хугацаа: **4 өдөр 20 цаг 10 минут**
- **Агаарын тээврээр орж ирсэн импортын** ачаа бараа Буянт-Ухаа хилийн боомт дээр эзэндээ олгогдох дундаж хугацаа: **2 өдөр 12 цаг 32 минут**
- **Буянт-Ухаа хилийн боомтоос агаарын тээврээр гарах экспортын ачаа барааны нийт дундаж хугацаа: 18 цаг 25 минут**
- Гүний терминалаас ачигдан ирж Буянт-Ухаа хилийн боомтоос **агаарын тээврээр гарах захиалга дуудлагын экспортын**<sup>2</sup> нийт дундаж хугацаа: **4 өдөр 20 цаг 35 минут**

---

<sup>2</sup> Захиалга дуудлагын экспорт гэдэгт Гааль, МХЕГ-ын улсын байцаагчид экспортлогч ААН-ийн хүсэлтийн дагуу тэдгээрийн байр, үйлдвэр, агуулах (гаалийн түр хяналтын бүс) дээр очин ачаа барааг тээврийн хэрэгсэлд ачиж эхлэх



- Гүний терминалаас авто тээврээр ачигдан ирж хилийн боомтоор гарах **захиалга дуудлагын экспортын** нийт дундаж хугацаа<sup>3</sup>: **2 өдөр 18 цаг 51 минут**
- **Импорт, экспорттой холбоотой зөвшөөрөл, гэрчилгээ** авахад зарцуулагддаг нийт дундаж хугацаа: **11 цаг 56 минут**

Тус ЦХС-аар экспорт, импортын барааг улсын хилээр оруулах, эсхүл гаргах үйл ажиллагааны цаг хугацаанд хамгийн их нөлөөлдөг нийтлэг саад бэрхшээл, хүндрэлтэй асуудлыг тодорхойлсон. Тухайлбал:

- Хил дээр ажилладаг хяналтын байгууллагуудын ажлын уялдаа сул, мэдээллийн нэгдсэн системгүй, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо хангалтгүй байдаг нь нэг талаас байгууллага тус бүр хяналт, шаардлагыг давхардуулах, нөгөө талаас экспорт, импортын бараа хилийн мэргэжлийн хяналтанд бүрэн хамрагдахгүй байх нөхцөлийг бий болгодог;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Гаалийн ерөнхий газрын эрсдэлийн удирдлагын үнэлгээгээр их эрсдэлтэй эсхүл улаан төлөвт сонгогдсон барааны биет шалгалтын дундаж хугацаа нь ногоон, улбар шар/бага, дунд эрсдэлтэй бараанаас богино байх тохиолдол цөөнгүй байна;
- Лабораторийн шинжилгээ болон импорт, экспорттой холбоотой гэрчилгээ, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь хүндрэлтэй, зарим тохиолдолд давхардсан, хүнд сурталтай байдлаар хэрэгжиж буй нь худалдаа эрхлэгчдийн хувьд зардал, чирэгдэл бий болгосон хэвээр байна;
- Терминалын дэд бүтэц нь стандарт шаардлагад нийцэхгүй, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл хангалтгүй, гацдаг, зогсдог, тог цахилгаан тасардаг зэргээс хүлээлгийн хугацаа сунжирдаг;
- Төмөр замын царигийн ялгаатай байдал, дэд бүтэц, ачааны вагоны хүрэлцээ хангалтгүй, түүнчлэн тухайн байгууллагын нэгж газруудын зохион байгуулалт төвөгтэй байгаа нь ачаа тээвэрлэлтийг сунжруулдаг;
- Экспортлогч, импортлогч нарын гадаад худалдааны барааг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн мэдлэг хангалтгүй;
- Худалдаанд оролцогч талуудын харилцан ойлголцол, итгэлцэл, ил тод, нээлттэй байдал, хамтын ажиллагаа хангалтгүй зэрэг болно.

ЦХС-аар цугларсан мэдээлэл, гарсан үр дүнг оролцогч байгууллага тус бүр дотооддоо бенчмаркинг хийх байдлаар ашиглах, дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх, худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлэх, түүний үр нөлөө, өгөөжийг үнэлэх, хяналт шинжилгээ-үнэлгээ хийх, Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо (ХХҮХ)-оос

---

үеэс дуусах хүртэлх хугацаанд хяналт тавих үйл явцыг ойлгодог. Энэхүү төлбөрт үйлчилгээг дээрх хоёр байгууллага экспортлогчийн хүсэлтээр үзүүлдэг болно.

<sup>3</sup> Авто замаарх экспортын нийт дундаж хугацаанд гүний терминалаас хилийн боомт хүртэлх аялалын хугацаа ороогүй болно.

хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд худалдааг хөнгөвчлөх хэрэгсэл болгон ашиглах зэрэг ач холбогдолтой болно.

## **Зөвлөмжийн хураангуй**

ЦХС-аар цуглуулсан өгөгдөлд ДГБ-ын цахим программ хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийсэн бөгөөд үүнд үндэслэн нарийвчилсан дүн шинжилгээ, холбогдох зөвлөмжийг боловсруулан гаргасан. Дэлгэрэнгүй дүгнэлт, зөвлөмжтэй тус судалгааны тайлангийн “Дүгнэлт, Зөвлөмж”-өөс танилцах боломжтой. Зөвлөмжийг дараах байдлаар нэгтгэв. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газар нь нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор<sup>4</sup> хүлээсэн үүргээ биелүүлж, үндэсний хууль тогтоомжуудыг тэдгээрт нийцүүлэх;
2. Хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа<sup>5</sup>, үйл ажиллагааг уялдуулах, давхардсан шалгалтуудаас зайлсхийх, хилийн нэгдсэн удирдлагыг тогтолцоог бий болгох;
3. Эдийн засгийн итгэмжлэгдсэн операторын тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх үүднээс шинэчлэн найруулж байгаа Гаалийн хуульд холбогдох заалтыг тусган оруулах;
4. ГЕГ, МХЕГ, МЭЕГ, СХЗГ нь тохирлын баталгаажуулалт, магадлан итгэмжлэгдсэн лабораториудын дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх, лабораторийн магадлан шинжилгээ зайлшгүй хийлгэх экспорт, импортын барааны нэр төрөл, шинжилгээ хийлгэх давтамжийг тогтвортой бууруулах<sup>6</sup>;
5. Бараа бүтээгдэхүүн бүрээс тогтмол дээж авдаг, шалгадаг өнөөгийн буруу практикийг халж эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гааль, мэргэжлийн хяналтын байгууллагууд цогц байдлаар хэрэгжүүлэх. Чингэхдээ эрсдэлийг

---

<sup>4</sup> Монгол улсын 1989 онд нэгдэж, УИХ-аас 2007 онд соёрхон баталсан НҮБ-ын 1982 оны “Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц”-ийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын хяналтын бүх албад мөрдөх үүрэгтэй байдаг тул улсын хилээр нэвтрүүлэх үед бараанд хийдэг гаалийн хяналт болон бусад хяналтыг уялдуулах асуудлыг шийдвэрлэх хамгийн чухал асуудлын нэг болж байна. “Бүх улсын хил дээр гааль ажилладаг, түүний үүрэг нь нийтлэг шинжтэй байдгийг харгалзан бусад төрлийн хяналтыг гаалийн хяналттай боломжийн хэрээр уялдуулах ажлыг зохион байгуулна” гэж тус конвенцод заасны дагуу Гаалийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Химийн хортой болон аюултай бодисын тухай зэрэг олон хуулиудад өөрчлөлт оруулж, худалдааг хөнгөвчлөх бодит нөхцөлийг бүрдүүлэх; Энэ ажлыг ХХҮХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3-д заасан байдаг.

<sup>5</sup> ХХХ-н зүйл 8. 8.1.Гишүүн бүр худалдааг хөнгөвчлөх зорилгоор импорт, экспорт, дамжуулан өнгөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьдаг хилийн хяналтын эрх бүхий байгууллага, агентлагийн хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана. /Манай улс “С” ангиллаар нэгдсэн. Хэрэгжих хугацаа: 2023.12.31/

<sup>6</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуульд төрийн байгууллагуудаас хяналтын үйл ажиллагааг (магадлан итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх, давхардсан хяналтаас зайлсхийх) нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхээр заасан байдаг. Түүнчлэн байхаар тогтоосон хэдий ч салбарын хуулиудад тус тусдаа хяналт шалгалтыг хийхээр хуульчилсан байгаа нь асуудал дагуулж байна. Түүнчлэн ДХБ-ын Техникийн хориг саадын тухай хэлэлцээр болон олон улсын бусад байгууллагуудын гэрээ хэлэлцээрийн дагуу олон улс, бүс нутгийн итгэмжлэл, стандарт, удирдамж, зөвлөмжийн нөхцөлийг мөрдөхөөр манай улс хүлээн зөвшөөрсөн тул дагаж мөрдөх шаардлагатай байдаг.

хамтарсан байдлаар зөв зохистой үнэлэх, тодорхойлох, зөвхөн өндөр эрсдэлтэй барааг онилж шалгах замаар нөөцийг үр ашигтай хуваарилах нь зүйтэй;

6. Эрсдэлийн удирдлагыг бүрэн нэвтрүүлэх, олон улсын сайн туршлагад үндэслэн улаан болон өндөр эрсдэлтэй барааны нийт бүрдүүлэлтэнд эзлэх хувь хэмжээг шат дараатайгаар бууруулах, гаалийн харилцаанд оролцогчдыг дэмжих, гаалийн хяналтын үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх;
7. Ижил горимд, эрсдэлийн төлөв нь адил нэг нэр төрлийн барааны хяналт, шалгалт, бүрдүүлэлтийн хугацаа нь хилийн боомт, терминал тус бүр дээр харилцан адилгүй байгаад ГЕГ, МХЕГ, МЭЕГ анхаарч үйл ажиллагааг ижилсгэх, бенчмаркинг хийх;
8. Илгээлтэй холбоотой хэлцлийн мэдээлэл, бичиг баримтыг гаальд урьдчилан өгөх чиглэлд тодорхой, дэс дараалсан үйл ажиллагаануудыг гадаад худалдаанд оролцогч талуудтай хамтран хийх, шаардлагатай бол мэдээллийг урьдчилан авах нэгдсэн системтэй болоход олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудаас туслалцаа, дэмжлэг авах;
9. Гаалийн хяналтын зорилгоор илгээлтийг дагалдах худалдааны бичиг баримтыг бүртгэх, шалгах, баталгаажуулах үйл ажиллагааг цахимжуулах, төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцооны нэгдсэн цахим сантай<sup>7</sup> болох;
10. МХЕГ-ын тодорхой процессууд, түүний дотор хилээр нэвтрүүлэх бараатай холбоотой үйл ажиллагаа, мэдээллийн санг цахимжуулах, үйл ажиллагааг бусад төрийн албадтай ижилсгэх, уялдуулах<sup>8</sup>;
11. Худалдааны нэгдсэн мэдээллийн порталыг<sup>9</sup> бий болгох, барааг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотойгоор мөрддөг хууль, тогтоол, дүрэм, журам, шийдвэр, заавар, зөвлөмж түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр сонирхсон бүх этгээд авах аливаа боломжийг олдоцтой<sup>10</sup> байдлаар бүрдүүлж, бараа экспортлох эсхүл импортлоход шаардлагатай практик алхмууд, тэдгээрт шаардагдах маягт, бичиг баримтууд, лавлах цэг, холбоо барих хаяг зэргийг байршуулж, тогтмол шинэчлэх;
12. Худалдаа эрхлэгч талуудад өөрөө мэдүүлэх нөхцөл, боломж, орчинг бүрдүүлэх;
13. Худалдаа, тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, бизнесийг дэмжих зорилгоор байгууллагуудын ажиллах цагийг уялдуулах;
14. Тээврийн хэрэгсэл, дэд бүтцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх, хил дээрх саатлыг бууруулах үүднээс гаалийн байгууллагаас тээвэрлэгчид олгож байгаа итгэмжлэлийн<sup>11</sup> хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна. Одоогийн байдлаар уул

<sup>7</sup> ХХҮХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.23-д заагдсан байгаа болно.

<sup>8</sup> Одоогийн байдлаар МХЕГ нь экспорт, импорттой холбоотой бичиг баримт, мэдээллийг цаасаар хүлээн авдаг бөгөөд холбогдох цахим системийн хөгжүүлэлтийг АХБ-ын туслалцаатайгаар хийж эхлүүлээд байна.

<sup>9</sup> ОУСК нь ГЕГ болон ХХҮХ-той хамтран Худалдааны нэгдсэн мэдээллийн порталыг бий болгох чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд тус портал нь 2021 оны эхний улиралд ашиглалтанд орох юм.

<sup>10</sup> Шинэчлэн найруулсан Киотогийн конвенц (ШНКК)-ийн Ерөнхий хавсралт бүлэг 9 гаалийн асуудлаар авах мэдээлэл олдоцтой байх нь худалдааг хөнгөвчлөх гол үзүүлэлт гэж үздэг

<sup>11</sup> Улс хооронд болон дотоодод дамжуулан өнгөрүүлэх чадамжийг дээшлүүлэх зорилгоор гаалийн байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан тээвэрлэгчдэд ГЕГ- аас итгэмжлэл олгож байгаа болно. Тайланг боловсруулж байх үед итгэмжлэл олгосон нийт тээвэрлэгчдийн 60% нь нүүрсний экспортын салбарт ногдож байв.

уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийг эрхэлж байгаа тээвэрлэгчдэд итгэмжлэлийг түлхүү олгож байна. Тээвэрлэгчдийн хууль сахин мөрдөлт, ойлголт мэдлэгийг дээшлүүлэх явдал нь энэхүү үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байна;

15. “Эдийн засгийн итгэмжлэгдсэн оператор”-ын хөтөлбөрийн нөхцөл шалгуурыг хангах бэлтгэл ажлын хүрээнд ГЕГ-аас аж ахуйн нэгжид итгэмжлэл<sup>12</sup> олгохоор эхлүүлсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, талууд харилцан үүрэг хариуцлага, зорилго зорилтдоо нийцсэн эрчимтэй хамтын ажиллагааг өрнүүлэхэд төрийн бусад байгууллага болон хувийн хэвшил, салбарын холбоод, ТББ-тай хамтран ажиллах<sup>13</sup>;
16. Худалдаа эрхлэгчдийн зүгээс шаардлагатай бичиг баримтыг дутуу өгөх, барааг буруу ангилах зэрэг алдаатай практикийг халах үүднээс мэргэжлийн холбоодтой хамтарсан сургалтуудыг тогтмол зохион байгуулж хууль сахилтын төвшинг дээшлүүлэх;
17. Дэлхийн Гаалийн Байгууллагын Цаг хугацааны судалгааны мэдээллийн бааз, энэхүү тайлан, асуулгуудад үндэслэн гааль болон мэргэжлийн хяналтын байгууллагууд үйл явц бүрээр нарийвчилсан судалгаа хийх, цаашид ЦХС-ааг хэрэгжүүлдэг мэргэшсэн баг бүрдүүлж тогтмол хугацаанд уг судалгааг зохион байгуулж, зөвлөмжийн хэрэгжилтэнд мониторинг хийж үр дүн, өгөөжийг тооцдог байх, судалгааны үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, холбогдох арга хэмжээг тусгах.

---

<sup>12</sup> Уг хөтөлбөр нь гадаад худалдааг хөнгөвчлөх, худалдааны аюулгүй байдлыг хангах, гааль-бизнесийн түншлэлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн. Тус хөтөлбөрт тодорхой шалгуур (хууль сахилт, дотоод хяналтын төвшин сайн байх, санхүүгийн чадавхитай байх, гадаад худалдааны аюулгүй байдлын стандартыг чанд сахих зэрэг) хангасан гадаад худалдаанд оролцогч аливаа аж ахуйн нэгж (худалдаа эрхлэгч ААН, тээвэрлэгч, тээвэр зууч, гаалийн зууч, гаалийн баталгаат бүс эрхлэгч гэх мэт) сайн дураараа хамрагдах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тодорхой хөнгөлөлт үзүүлэхээр журамд заасан байдаг.

<sup>13</sup> ХХҮХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.9-д орсон

## ЦАГ ХУГАЦААНЫ СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

### Судалгааны зорилго, ач холбогдол

Цаг хугацааны судалгаа нь барааг улсын хилээр оруулсан үеэс эхлээд эзэнд нь олгох эсхүл гаалийн хяналтын бүс (ГХБ)-т оруулсан үеэс улсын хилээр гаргах хүртэлх хугацаанд гааль болон хилийн хяналтын бусад байгууллагуудаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд зарцуулагдаж буй бодит хугацааг хэмжих, тэдгээрийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд тулгарч буй саад тотгорыг тодорхойлоход чиглэсэн баримт нотолгоонд суурилсан стратегийн арга хэрэгсэл хэмээн олон улсын төвшинд тодорхойлогд<sup>14</sup>. ЦХС-ааг дараах зорилгоор хэрэгжүүлэхийг улс орнуудад санал болгодог. Тухайлбал, барааг улсын хилээр оруулсан үеэс эзэнд нь олгох хүртэл шаардагдаж буй хугацааг хэмжих; энэхүү үйл ажиллагаанд оролцогч тус бүрийн ажлын үр ашигтай байдлыг үнэлэх; барааг эзэнд нь олгохтой холбоотой үйл явцад учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох; хяналтын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй үйл явцыг үр дүнтэйгээр зохион байгуулахад шаардлагатай баримт мэдээллийг цуглуулах; хилийн хяналтын удирдлагыг сайжруулах боломж нөхцөлийг тогтоох; хилийн хяналтын удирдлагын гүйцэтгэлийн суурь хэмжигдэхүүнийг тодорхойлох замаар үйл ажиллагааны үр ашигтай байдлыг тогтмол нэмэгдүүлэх зэрэг болно<sup>15</sup>.

Монгол Улсын хувьд тус судалгааг дараах зорилтуудын хүрээнд хийсэн болно. Үүнд:

- Барааг улсын хилээр оруулсан үеэс эзэнд нь олгох болон барааг мэдүүлсэн үеэс улсын хилээр гаргах хүртэлх үйл ажиллагаанд зарцуулагдаж буй дундаж хугацааг хэмжих;
- Барааг экспортлох болон импортлоход гааль болон худалдаанд оролцогч бусад талуудад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох;
- Гааль болон бусад хяналтын байгууллагууд, худалдаанд оролцогч талуудтай зөвлөлдөх замаар дээрх бэрхшээлийг даван туулахад чиглэсэн зөвлөмж боловсруулах;
- Худалдааг хөнгөвчлөх боломжийг тодорхойлох;
- Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын орчин үеийн стандарт, арга хэрэгслийг гааль болон хилийн хяналт шалгалтын үйл явцад хэрэгжүүлэх боломжийг судлах;
- ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7.6-д заасны дагуу Бараа олгох дундаж хугацааг тогтоож, хэвлэн нийтлэх, олон нийтийн хүртээл болгох зэрэг болно.

Цаг хугацааны судалгаа нь нэг талаас хилийн хяналтын байгууллагуудын гүйцэтгэл, тэдгээрийн үр ашигт ажиллагааг цаг хугацааны хэмжигдэхүүнээр харуулахаас гадна судалгааны явцад тодорхойлсон анхаарах асуудалд суурилан цаашид худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг богино, дунд, урт хугацаанд төлөвлөх боломжийг олгодгоороо

<sup>14</sup> Барааг эзэнд нь олгох цаг хугацааг хэмжихэд баримтлах гарын авлага, хувилбар 3, ДГБ, 2018 он, хуудас 9

<sup>15</sup> ДГБ-ын гарын авлага, мөн эх сурвалж

ихээхэн ач холбогдолтой юм. Иймд тус судалгааны хүрээнд ДГБ-ын ЦХС-ны цахим мэдээллийн баазад цугларсан өгөгдөлд суурилан гаалийн байгууллага бусад сонирхогч талуудтай хамтран хяналтын үйл явц тус бүрээр нарийвчлан дүн шинжилгээ хийх, өөрсдийн байгууллагын дотоод хяналт-үнэлгээнд тусган хэрэглэх, мөн дараа дараагийн судалгаанд суурь үзүүлэлт болгон ашиглах боломж бүрдэж байгаа юм.

Түүнчлэн тус судалгаагаар санал болгож буй зөвлөмж хэрэгжсэнээр импорт, экспортын үйл ажиллагаанд зарцуулагддаг хугацаа буурч, хяналтын байгууллагуудын ил тод, урьдчилан таамаглаж болохуйц байдал сайжирч, улмаар худалдаа, бизнес эрхлэгчдийн цаг хугацаа, хөрөнгө, зардал хэмнэгдэхээс гадна хэрэглэгчдэд очих бараа бүтээгдэхүүний өртөг буурах, нэр төрөл нэмэгдэх ач холбогдолтой юм.

## Судалгааны хамрах хүрээ

ЦХС-ны Ажлын хэсэгтэй<sup>16</sup> зөвшилцсөний үндсэн дээр хэмжилт хийх байршлыг хилийн боомт, терминалын бараа, бүтээгдэхүүн нэвтрүүлэлтийн хэмжээнд<sup>17</sup> үндэслэн сонгосон ба нийт 6 хилийн боомт, өртөө, 2 гүний терминалд дараах тээвэрлэлтийн төрөл, худалдааны горимыг хамруулан цаг хугацааны хэмжилт хийхээр тохиролцсон. Үүнд:

- Тээврийн төрөл: агаар, төмөр зам, авто зам;
- Худалдааны горим, бараа бүтээгдэхүүн: Уул уурхайн бүтээгдэхүүнээс бусад экспортын бараа; бүх төрлийн импортын бүтээгдэхүүн, үүнд олон улсын дамжуулан худалдаалах бараа ороогүй болно.

Хүснэгт 1. Судалгаа хийхээр сонгогдсон хилийн боомт, гүний терминал, тээвэрлэлтийн хэлбэр, худалдааны горимоор

	Хилийн боомт, гүний терминал	Тээвэрлэлт	Худалдааны горим
1.	Замын-Үүд хилийн боомт <sup>18</sup>	Авто зам	<p><i>1. Импорт:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>-Авто тээврээр орж ирсэн импортын бараа хилийн боомт дээр олгодох;</li> <li>-Авто тээврээр орж ирсэн ачаа бараа Монгол Транс гүний терминал дээр эзэндээ олгогдох.</li> </ul> <p><i>2. Экспорт:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Транс гүний терминалаас авто тээврээр ачигдсан бараа хилийн боомтоор гарах;</li> <li>- Хилийн боомтоос авто тээврээр бараа экспортлох;</li> <li>- Захиалга дуудлагын экспортын ачаа бараа гүнд бүрдүүлэлт хийн авто тээврээр хилийн боомтоор гарах.</li> </ul>
2.	Алтанбулаг хилийн боомт		
3.	Цагааннуур хилийн боомт		
4.	Монгол Транс гүний терминал		

<sup>16</sup> ХХҮХ-ны 4-р хуралдааны шийдвэр (2019/04/10)-ийн дагуу ГЕГ, МХЕГ-ын төлөөллөөс бүрдсэн ЦХС-ны хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг байгуулан, түүний ажлын төлөвлөгөөг мөн оны 5-р сарын 17-ны өдөр батласан болно.

<sup>17</sup> Импорт, экспортын гаалийн мэдүүлгийн статистик үзүүлэлт дээр суурилан тооцсон ба гаалийн мэдүүлэг харьцангуй их бүртгэгдсэн буюу ачаалал ихтэй хилийн боомт, терминалыг сонгон авч үзсэн.

<sup>18</sup> Замын-Үүд хилийн боомт дах ЧШРТТ, ЧШРТТ-109, Дардан, Э-Транс, АЗШНЦ-103, НЦШАА зэрэг 6 гаалийн хяналтын бүс, терминал хамрагдсан.

5.	Замын-Үүд хилийн боомтын Нарийн царигийн шилжүүлэн ачих анги (НЦШАА) өртөө	Төмөр зам	<i>Импорт:</i> - Төмөр замаар орж ирсэн ачаа бараа гүний терминал руу ачигдан АБТЭМА гүний терминал дээр эзэндээ олгогдох; - Чингэлгээр орж ирсэн ачаа барааг төмөр замаар гүний терминал руу шилжүүлэн ачиж ачаа бараа АБТЭМА гүний терминал дээр эзэндээ олгогдох
6.	Сүхбаатар өртөө, Сэлэнгэ аймаг		
7.	АБТЭМА гүний терминал		
8.	Буянт-Ухаа хилийн боомт	Агаар	1. <i>Импорт:</i> - Агаарын тээврээр орж ирсэн ачаа бараа Буянт-Ухаа хилийн боомт дээр эзэндээ олгогдох; 2. <i>Экспорт:</i> - Ачаа барааг Буянт-Ухаа хилийн боомтоор экспортод гаргах; - Захиалга дуудлагын экспортын ачаа бараа гүнд бүрдүүлэлт хийн Буянт-Ухаа хилийн боомтоор экспортод гаргах
9.	Улаанбаатар хотын гаалийн газар (УБГГ)	Гүний гаалийн Монгол Транс, АБТЭМА терминалын хяналт, бүрдүүлэлтээр орж буй зарим бараа, бүтээгдэхүүний бичиг баримтын бүрдүүлэлт Улаанбаатар хотын гаалийн газар (УБГГ) дээр хийгддэг тул эдгээр бараа, бүтээгдэхүүний бичиг баримт бүрдүүлэлтийн хугацааны хэмжилтийг УБГГ дээр хийсэн.	

Энэхүү судалгаанд барааг улсын хилээр оруулах, гаргах үйл ажиллагаанд гааль болон мэргэжлийн хяналтын газраас гадна экспорт, импортын үйл ажиллагаанд оролцдог бусад хамаарах байгууллага, хуулийн этгээдүүд болох экспортлогч, импортлогч, тээвэрлэгчид, тээврийн болон гаалийн зуучлагчид, терминалын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшил, Хил хамгаалах ерөнхий газар, Улаанбаатар төмөр зам, Монголын иргэний агаарын тээвэр, тэдгээрийн харьяа байгууллагууд зэрэг худалдаанд оролцогч талуудыг хамруулан авч үзсэн. Түүнчлэн бараа бүтээгдэхүүн экспортлох, импортлоход хууль тогтоомжийн хүрээнд холбогдох гэрчилгээ, зөвшөөрөл олгодог байгууллагууд болох Мал эмнэлгийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагууд тус судалгаанд мөн хамрагдсан болно.

ЦХС-ны хэмжилтийн мэдээллийг цуглуулахдаа худалдааны эргэлт ердийн, хэвийн хэмжээнд явагддаг үеийг<sup>19</sup> сонгон авч асуулга судалгааг 2019 оны 10 дугаар сарын 8-16-ны өдрүүдэд сонгогдсон байршлуудад нэгэн зэрэг хийж гүйцэтгэсэн.

Цаг хугацааны хэмжилт хийх үйл ажиллагаанд импортын барааны хувьд тээврийн хэрэгсэл улсын хилээр эсхүл гаалийн хяналтын бүсэд орж ирсэн үеэс эзэндээ олгогдох хүртэл, экспортын барааны хувьд гаалийн хяналтын бүсэд<sup>20</sup> орж ирсэн эсхүл гаалийн мэдүүлэг өгсөн үеэс улсын хилээр гарах хүртэлх бүхий л үйл явцыг авч үзсэн болно.

<sup>19</sup>ДГБ-ын зааварчилгаагаар худалдааны эргэлт, боомт терминалын ачаалал хэвийн цаг үед ЦХС-ны асуулга судалгааг зохион байгуулж, бодит мэдээлэл цуглуулахыг санал болгодог.

<sup>20</sup> Гаалийн түр хяналтын бүс буюу аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл эрхэлдэг байр, агуулах байрших газрыг хамруулан ойлгоно.

Асуулга судалгааны явцад буюу ажлын 7 өдөрт нийт 2142 асуулга тараагдсанаас 1993 асуулга судалгаа цуглуулсан ба бүрэн гүйцэт бөглөгдсөн<sup>21</sup> буюу хүчинтэй гэж тооцогдсон 1725 асуулга судалгааны мэдээлэл, өгөгдлийг ДГБ-ын цахим мэдээллийн санд оруулсан болно. Импортын нийт 1582, экспортын нийт 143 асуулгын өгөгдөлд дүн шинжилгээ хийгдсэн болно (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Цуглуулсан судалгааны тоо: Худалдааны горим, байршил, тээвэрлэлтийн төрөл, хилийн болон гүний терминалаар

Экспорт/ Импорт	Хилийн боомт/ Гүний терминал	Тараасан судалгааны тоо	Цуглуулсан судалгааны тоо	Хүчингүй судалгааны тоо <sup>22</sup>	Хүчинтэй судалгааны тоо/ДГБ <sup>23</sup>	Хилийн боомт эсвэл гүний терминалыг хамарсан	Хилийн боомт болон гүний терминалыг бүрэн хамарсан
Авто замын импорт	Алтанбулаг ХБ	88	87	7	80	79	1 <sup>24</sup>
	Цагааннуур ХБ	52	51	1	50	50	0
	Замын-Үүд ХБ	889	888	79	809	798	11 <sup>25</sup>
	Монгол Транс ГТ	86	79	6	73	10	63
Төмөр замын импорт	Замын-Үүд ХБ	127	119	19	100	58	42
	Сүхбаатар ХБ	92	92	2	90	50	40
	АБТЭМА ГТ	341	227	89	138	138	0
Шилжүүлэн ачилтын импорт	Замын-Үүд ХБ	39	39	3	36	30	6
Агаарын импорт	Буянт-Ухаа ХБ	249	240	34	206	206	0
Агаарын экспорт		65	65	3	62	62	0
Авто замын экспорт	Замын-Үүд ХБ	73	73	20	53	53	0
	Цагааннуур ХБ	5	5	0	5	5	0
	Алтанбулаг ХБ	4	4	4	0	0	0
Захиалга дуудлагын экспорт	УБХГ, түр ГХБ	32	24	1	23	22	1
<b>НИЙТ</b>		<b>2142</b>	<b>1993</b>	<b>268</b>	<b>1725</b>	<b>1561</b>	<b>164</b>

Тайлбар: ХБ-Хилийн боомт; ГТ-Гүний терминал; ДГБ- Дэлхийн Гаалийн Байгууллага

<sup>21</sup> Бүрэн бөглөгдсөн судалгааны логик алдаа, хугацааны хэт хэлбэлзэлтэй утгыг тогтоон шаардлага хангахгүй асуулга судалгааг түүврээс хассан.

<sup>22</sup> Хүчингүй судалгааны тоо - асуулга дутуу, алдаатай бөглөгдсөн, мөн бөглөгдсөн цаг хугацааны мэдээлэл нь дундаж утгаас хэт хэлбэлзсэн (outlier) тохиолдолд нийт түүврээс хассан болно.

<sup>23</sup> Хүчинтэй судалгааны тоо – Нийт цуглуулсан асуулга судалгаанаас хүчингүй судалгааг хасч цэвэрлэсэн судалгааны тоо бөгөөд эдгээр судалгаа нь Дэлхийн Гаалийн Байгууллагын Цаг хугацааны судалгааны мэдээллийн баазад орсон болно.

<sup>24</sup> Алтанбулаг хилийн боомтоос Монгол Транс гүний терминал дээр ирсэн 1 түүвэр ачаа нь 8 хүлээн авагчтай ачаа болж задарсан.

<sup>25</sup> Замын-Үүд хилийн боомтоос Монгол Транс гүний терминал дээр ирсэн 11 түүвэр ачаа нь 55 хүлээн авагчтай ачаа болж задарсан.



## СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, ҮЕ ШАТ

Цаг хугацааны судалгааг хэрэгжүүлэхдээ Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ)-ын 2018 оны “Барааг эзэнд нь олгох цаг хугацааг хэмжихэд баримтлах гарын авлага-Хувилбар 3” баримт бичигт дурьдагдсан аргазүйг ашигласан. Түүнчлэн ДГБ-ын Цаг хугацааны судалгааны цахим программ хангамжийг ашиглан өгөгдөлд боловсруулалт хийн, экспорт, импортын аливаа үйл явц хоорондын интервал хэмжигдэхүүн бүхий товч тайланг гарган авсан болно.

ЦХС-ааг дараах үндсэн 3 үе шатаар хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Үе шат 1: Судалгааны бэлтгэл ажил
- Үе шат 2: Судалгааны мэдээллийг цуглуулах, өгөгдлийг ДГБ-ын цахим мэдээллийн баазад оруулах
- Үе шат 3: Өгөгдлийн боловсруулалт, дүн шинжилгээ, тайлан зөвлөмжийг боловсруулах зэрэг болно.

ДГБ-ын зүгээс улс орнуудад дээр дурьдсан 3 үе шатаас гадна ЦХС-ны зөвлөмжийн хэрэгжилтэнд мониторинг үнэлгээ хийхийг зөвлөдөг (Зураг 1). Олон улсын туршлагаас харахад судалгааны зөвлөмжийн хэрэгжилт, тэдгээрийн биелэлтэнд үнэлгээ өгөх ажлыг тухайн улсын ХХҮХ хариуцдаг байна.

Зураг 1. ЦХС-ны цикл- ДГБ-ын аргазүй



### Үе шат 1: ЦХС-ны бэлтгэл ажил

Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо (ХХҮХ)-оос 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батласан “ЦХС-ааг хийх ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө” -ний дагуу ГЕГ-ын Гаалийн хяналт шалгалтын газар, МХЕГ-ын Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар болон хилийн мэргэжлийн хяналтын газрын холбогдох төлөөллөөс

бүрдсэн ажлын хэсгийг байгуулсан ба ГЕГ ахлан ажилласан болно. ЦХС-ны ажлын төлөвлөгөөний хүрээнд Ажлын хэсэг нь үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж дараах ажлуудыг 2019 оны 6-9 саруудад хийж гүйцэтгэсэн болно:

- **Судалгаа хийх хилийн боомт, гүний терминал, тээвэрлэлтийн төрөл, худалдааны горимыг сонгох:** Гаалийн мэдүүлгийн 2018 оны статистик мэдээлэлд үндэслэн нийт 6 хилийн боомт, өртөө, 2 гүний терминалд<sup>26</sup> цаг хугацааны хэмжилт хийхээр ЦХС-ны ажлын хэсэгтэй зөвшилцөж тохирсон;
- Цаг хугацааг бодитой хэмжих үүднээс судалгааны хугацаанд сонгогдсон хилийн боомт, гүний терминалд барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горимоор бүрдүүлэлт хийгдсэн импорт, уул уурхайн бүтээгдэхүүнээс бусад экспортын бараа, бүтээгдэхүүнийг хамруулахаар шийдвэрлэсэн ба судалгааны асуулгыг импорт, экспортын илгээлтийг дагалдах худалдааны бичиг баримтыг дагалдуулж бөглүүлэхээр зохион байгуулсан. Монгол Улсын хувьд уул уурхай, түүхий эд нь нийт экспортын зонхилох хувийг эзэлдэг тул судалгааны түүврийн тэнцвэртэй байдлыг хадгалах үүднээс олборлох салбарын экспортыг хамруулаагүй болно;
- **Дээрх хилийн боомт, гүний терминал тус бүрийн гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны технологийн дэс дарааллын зураглалыг боловсруулах:** Ажлын хэсгийн төлөөлөл болон ОУСК-ийн худалдааг хөнгөвчлөх асуудлыг хариуцсан зөвлөх Робэрт Эндрю Стрүтэрстэй хамтран барааг улсын хилээр оруулах болон улсын хилээр гаргах үйл ажиллагааны үе шат, явц тус бүрийг тусгасан 12 төрлийн нарийвчилсан зураглалыг боловсруулсан болно. Эдгээр зураглалыг боловсруулахад ГЕГ болон МХЕГ-т мөрдөгдөж буй нийтлэг журам<sup>27</sup>, гаалийн бүрдүүлэлт, хяналтын үйл ажиллагааны технологит үндэслэснээс гадна дээр дурьдсан хилийн боомт, гүний терминалд хамаарах төмөр зам, нисэх, хилийн цэрэг, гаалийн болон тээвэр зуучлагч, терминалын үйл ажиллагаанд мөрдөгддөг бусад онцлог талыг тусгахыг зорьсон болно (“Хавсралт 3: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны технологийн дэс дарааллын зураглал” харна уу);
- **Судалгааны асуулга хуудас боловсруулах, нэгдсэн форматад оруулах:** Өмнөх хэсэгт дурьдсан үйл ажиллагааны дэс дарааллын зураглалд суурилан нийт 11 төрлийн асуулгыг (Хүснэгт 3) ОУСК-ийн зөвлөх Робэрт Эндрю Стрүтэрстэй хамтран



<sup>26</sup> Улаанбаатар хотын гаалийн газрын бичиг баримт бүрдүүлэлтийн нэгжийг мөн хамруулсан.

<sup>27</sup> Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам, хилийн мэргэжлийн хяналтын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрддөг журмууд.

боловсруулсан бөгөөд ГЕГ, МХЕГ, НМХГ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, Чингис хаан ОУНБ, Гаалийн зөвлөх зуучлагчдын холбооны төлөөллүүдтэй хийсэн хэд хэдэн удаагийн уулзалт-хэлэлцүүлэг, сургалтаар хэлэлцүүлэн хилийн боомт, гүний терминалуудын хяналтын үйл ажиллагааны онцлог, тэдгээрийн бодит нөхцөл байдлыг тусган сайжруулсан. 2019 оны 9-р сарын 23-24 өдрүүдэд зохион байгуулсан туршилтын судалгааны үеэр асуулга хуудсын нийцтэй байдлыг баталгаажуулсан ба эцэслэгдсэн асуулгыг ДГБ-ын цахим программ хангамжид оруулсан болно. (“Хавсралт 4: ЦХС-ны асуулга хуудас” харна уу).

Хүснэгт 3. ЦХС-ны асуулга хуудас: Тээвэрлэлтийн төрөл, худалдааны горимд хамаарах гаалийн хяналтын процедурын төрлөөр

Судалгааны асуулгын төрөл		Хилийн боомт, гүний терминал	Тайлбар <sup>28</sup>
<b>Импортын процедур</b>			
1.	Авто замаарх импорт – хилийн боомт: Бараа хил дээр олгогдох; Барааг гүний терминал руу шилжүүлэх	Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур	Замын-Үүд хилийн боомтын 5 терминал, Алтанбулаг, Цагааннуур хилийн боомт тус бүрээр авто тээврээр орж ирсэн импортын барааг тухайн хилийн боомт дээр олгох; мөн барааг гүний терминал руу шилжүүлэхтэй холбоотой хилийн боомт дахь гаалийн хяналтын процедур: Нийт 5 бүлэг, 114 асуулт
2.	Авто замаарх импорт- хилийн боомт: Авто замаар орж ирсэн чингэлгийг төмөр замаар шилжүүлэн ачих	Замын-Үүдийн ЧШРТТ-109; НЦШАА	Замын-Үүд хилийн боомтоор чингэлгээр орж ирсэн импортын барааг төмөр замаар (НЦШАА) гүний терминал руу шилжүүлэн ачихтай холбоотой хилийн боомт дахь гаалийн хяналтын процедур: Нийт 5 бүлэг, 71 асуулт
3.	Авто замаарх импорт: Бараа гүний терминал дээр олгогдох	Монгол Транс гүний терминал	Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур болон бусад хилийн боомтоор авто тээврээр орж ирсэн импортын барааг Монгол Транс гүний терминал дээр олгохтой холбоотой гаалийн хяналтын процедур: Нийт 4 бүлэг, 79 асуулт
4.	Агаараар оруулах импорт: Бараа хилийн боомт дээр олгогдох	Буянт-Ухаа	Агаарын тээврээр орж ирж буй импортын барааг Буянт-Ухаа хилийн боомт дээр олгохтой холбоотой гаалийн хяналтын процедур: Нийт 5 бүлэг, 85 асуулт
5.	Төмөр замаарх импорт- хилийн боомт дээрх хяналт	Замын-Үүдийн НЦШАА; Сүхбаатар өртөө	Замын-Үүдийн НЦШАА өртөө болон Сэлэнгэ аймгийн Сүхбаатар өртөөгөөр төмөр замын тээврээр орж ирсэн импортын барааг АБТЭМА гүний

<sup>28</sup> 2019 оны 10-р сарын 8-16-ны өдрүүдэд 10 асуулга хуудас (Экспор, импорттой холбоотой гэрчилгээ, зөвшөөрлийн асуулга хуудсыг оролцуулахгүйгээр)-аар холбогдох мэдээллийг цуглуулсны дараа цугларсан мэдээллийг харгалзах хилийн боомт, гүний терминалыг холбосон байдлаар ДГБ-ын цахим мэдээллийн баазад оруулах шаардлагатай болсон бөгөөд үүнд нийцүүлж эдгээр 10 асуулга хуудсыг холбон нийт 8 асуулга хуудаст нэгтгэсэн болно.

			терминал руу шилжүүлэхтэй холбоотой хилийн боомт дахь хяналтын процедур: Нийт 5 бүлэг, 52 асуулт
6.	Төмөр замаарх импорт- бараа гүний гааль дээр олгогдох	АБТЭМА гүний терминал	Төмөр зам болон шилжүүлэн ачилтаар орж ирсэн импортын барааг АБТЭМА гүний терминал дээр олгохтой холбоотой гаалийн хяналтын процедур: Нийт 4 бүлэг, 80 асуулт
<b>Экспортын процедур</b>			
7.	Авто замаарх экспорт: Бараа гүний терминалаас ачигдах	Монгол Транс гүний терминал	Авто замаар гарах экспортын бараа Монгол Транс гүний терминалаас хилийн боомт руу ачигдах гаалийн хяналтын процедур: Нийт 4 бүлэг, 81 асуулт
8.	Авто болон агаараар гарах захиалга дуудлагын экспорт- гүний терминал: Бараа ГХБ болон гаалийн түр хяналтын бүсээс ачигдах	УБГГ, Гаалийн түр хяналтын бүс, Буянт-Ухаа	Авто болон агаарын тээврээр хийгдэх захиалга дуудлагын экспортын барааны гаалийн түр хяналтын бүс/ГХБ дэх хяналтын процедур; агаараар гарах захиалга дуудлагын Буянт-Ухаа хилийн боомт дахь гаалийн хяналтын процедур: Нийт 3 бүлэг, 93 асуулт
9.	Авто замаар гарах экспорт: Бараа хилийн боомт дээр ирж бүрдүүлэлт хийх; Гүний терминалаас ирж буй экспортын процедур	Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур	Авто замаар гарах экспортын бараа хилийн боомт дээр ирж гаалийн хяналтаар орж хилээр гарах; мөн гүний терминалаас ачигдаж ирсэн экспортын барааны хилийн боомтын гаалийн хяналтаар орж хилээр гарах процедур: Нийт 5 бүлэг, 109 асуулт
10.	Агаараарх экспорт – Хилийн боомт	Буянт-Ухаа	Агаараар гарах экспортын барааны Буянт-Ухаа хилийн боомт дахь гаалийн хяналтын процедур: Нийт 4 бүлэг, 89 асуулт
<b>Импорт, экспорттой холбоотой зөвшөөрөл, гэрчилгээ</b>			
11.	Импорт, экспорттой холбоотой гэрчилгээ, зөвшөөрөл	МХЕГ, СХЗГ, МЭЕГ, МҮХАҮТ	Төрийн болон ТББ-ын зүгээс импорт, экспортын гэрчилгээ, зөвшөөрөл олгох процедур: Нийт 17 асуулт



Асуулгын хуудас нь импортын барааг улсын хилээр оруулсан үеэс эзэндээ олгогдох хүртэл, экспортын бараа мэдүүлсэн үеэс эсхүл гаалийн хяналтын бүсэд оруулсан үеэс улсын хилээр гаргах хүртэлх гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүхий л шатанд илгээлтийг дагалдах худалдааны бичиг баримтын салшгүй нэг хэсэг болж гаалийн болон мэргэжлийн хяналтын улсын байцаагч, гаалийн зуучлагч, мэдүүлэгч, түүнчлэн харгалзах хилийн цэрэг, нисэх болон төмөр замын агент, тээвэрлэгч, экспортлогч, импортлогч тус бүрээр бүрэн гүйцэд бөглүүлэхээр зохицуулагдсан болно. Асуулга судалгаа дутуу

бөглөгдөх, хаягдаж гээгдэхээс сэргийлэх үүднээс илгээлтийг дагалдах худалдааны бичиг баримтыг хүлээн авсан этгээдэд зориулсан сануулах мэдээллийг асуулга хуудасны эхний нүүр хуудсанд монгол, англи, хятад болон орос хэлээр оруулснаас гадна тараагдсан асуулга хуудсыг тусгайлсан кодоор дугаарласан. Түүнчлэн асуулга хуудсыг бөглөх явцыг хялбарчлах үүднээс бөглөх этгээд тус бүрт хамаарах асуултуудыг ялгамжтай өнгөөр тодруулсан ба судалгааны хуудсыг тараах, хураан авах, хянах тоологч нарт зориулсан товч зааварчилгааг мөн оруулж өгсөн;



- **Судалгааны асуулгыг бөглөх, хяналт тавих сургалт, дадлага:** Судалгааны мэдээллийг цуглуулах, өгөгдлийг нэгтгэн ДГБ-ын цахим мэдээллийн баазад оруулах гэрээт гүйцэтгэгчийг ДБГ-ын худалдан авах журмын дагуу сонгон шалгаруулсан ба тус шалгаруулалтаар сонгогдсон “МЭК” ХХК-ийн нийт 75 судлаач-тоологч нарт асуулгыг бөглөх, судалгааны явцад хяналт тавих талаар үе шаттай сургалтуудыг зохион байгуулснаас гадна туршилтын судалгааны үеэр тоологч нарын байрлах цэгийг тодорхойлж, аль цэг дээр асуулгыг тараах, хураан авах, бөглөгдсөн судалгааг шалгах, хянах, бүрэн бөглөгдөөгүй судалгааны дутуу мэдээллийг нөхөж бөглүүлэх зэрэг талаар практик дадлага хийж ажилласан.




Туршилтын судалгааг 2019 оны 9 сарын 23-24 өдрүүдэд Замын-Үүд болон Буянт-Ухаа хилийн боомт, АБТЭМА гүний терминал, УБГГ-ын бичиг баримтын бүрдүүлэлтийн албад нэгдсэн зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэсэн нь асуулгыг сайжруулж эцэслэхэд ач холбогдолтой байсан юм;

- **ЦХС-ын талаар мэдээллэх, оролцоог хангах:** Худалдаа эрхлэгч, тээвэр зуучлагч, мэдүүлэгч болон бусад оролцогч талуудад ЦХС болон мэдээлэл цуглуулах асуулга судалгааны талаар урьдчилж мэдээлэл өгөх, тэдний оролцоо, хамтын ажиллагааг хангах үүднээс холбогдох газруудад албан захидал хүргэх, зурагт постер болон мэдээллийн хуудсыг судалгаа авах хилийн боомт, гүний терминал, гаалийн бүрдүүлэлт хийгдэж буй үйлчилгээний цэгүүдийн цонх, самбаруудад байршуулах, түүнчлэн эцэслэгдсэн асуулгыг судалгаа авах хилийн боомт, гүний терминалын холбогдох байцаагч нарт урьдчилан хүргүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулсан.



## **Үе шат 2: ЦХС-ны мэдээллийг цуглуулах, нэгтгэх, өгөгдлийг ДГБ-ын мэдээллийн баазад оруулах**

- **Судалгааг бөглөх буюу мэдээлэл цуглуулах:** ЦХС-аг 2019 оны 10 дугаар сарын 8-16-ны өдрүүдэд сонгогдсон 5 хилийн боомт болон 2 гүний терминалд нэгэн зэрэг хугацаанд зохион байгуулсан. Импортын барааны хувьд тээврийн хэрэгсэл хилээр орж ирэхэд судалгааны асуулга тараагдаж хяналтын бүсээс гарахад бөглөгдсөн асуулгыг хураан авсан. Экспортын барааны хувьд<sup>29</sup> гаальд мэдүүлэх эсхүл тээврийн хэрэгсэл гаалийн хяналтын бүсэд орж ирэх үед асуулгыг илгээлтийг дагалдах худалдааны бичиг баримттай хавсарган бөглүүлж барааг улсын хилээр гаргахад бөглөгдсөн асуулгыг хураан авсан болно. Түүвэр ачааны хувьд илгээлтийг дагалдах бичиг баримтыг товарын конторт худалдааны бичиг баримтын хүлээн авагчид олгох үед бараа хүлээн авагч тус бүрт асуулгыг олшруулан цааш бөглүүлэхээр тараагдсан болно. 10 дугаар сарын 16-ны өдрөөр судалгааны асуулгыг тараах ажлыг зогсоож үүнээс хойш ажлын 3-7 хоногийн турш бүрдүүлэлтийн шатанд байгаа бөглөгдөж дуусаагүй судалгааг хураан авч цуглуулах ажил үргэлжилсэн;



<sup>29</sup> Захилга дуудлагын экспортын хувьд УБГГ болон НМХГ-т захиалга ирж, холбогдох хяналтын байцаагч ААН-ийн байр руу явах үед асуулга судалгааг тараасан.

- **Цуглуулсан мэдээллийг нэгтгэх, баталгаажуулах, шивэлтэнд бэлтгэх, өгөгдлийг оруулах:** ДБГ-ын худалдааг хөнгөвчлөх асуудал хариуцсан Робэрт Эндрю Стрүтэрс зөвлөхийн өгсөн зааварчилгааны дагуу цуглуулсан асуулга судалгааг манифестийн дугаар, тээврийн хэрэгслийн дугаар, гаалийн мэдүүлгийн дугаар зэргээр шүүн



хилийн боомтоос гүний терминал, гүний терминалаас хилийн боомт руу ирсэн ачаа барааны асуулгыг холбон нэгтгэх ажил хийгдсэнээс гадна бүрэн бөглөгдсөн буюу хүчинтэй асуулгын шигшилтийг хийсэн. Шигшигдсэн асуулгын дутуу болон логик алдаатай мэдээллийг Ажлын хэсэгт орсон ГЕГ-ын төлөөллүүдийн туслалцаатайгаар CAIS системийн мэдээлэлтэй тулгах замаар баталгаажуулсанаас гадна буруу буюу дэс дарааллын хувьд авцалдахгүй мэдээллийг цэвэрлэх ажил хийгдсэн. Эдгээр хүчинтэй баталгаажсан асуулгын мэдээллийг эксел дээр шивж оруулан нийт дундаж үзүүлэлтээс хэт хэлбэлзэлтэй (outlier<sup>30</sup>) утга бүхий асуулгыг тодорхойлж тэдгээрийг дүн шинжилгээ хийх

судалгааны түүврээс хасах ажил хийгдсэний дараа эксел дээр шивэгдсэн өгөгдлийг CSV өргөтгөлтэй файл болгон хөрвүүлж ДГБ-ын Төслийн удирдагч, бизнес аналитст Энди Кларкын зааварчилгаан дор ДГБ-ын ЦХС-ны мэдээллийн баазад хөрвүүлэн оруулах ажил хийгдсэн болно.

### **Үе шат 3: Судалгааны өгөгдлийн боловсруулалт, дүн шинжилгээ, тайлан, зөвлөмж боловсруулах**

ДГБ-ын ЦХС-ны цахим программ хангамж нь жигнэсэн дундажийн статистик аргаар аливаа үйл ажиллагаанд зарцуулагдсан дундаж хугацааг “цаг, минут”-ын хэмжигдэхүүнээр тооцоолон гаргахын зэрэгцээ үүнтэй холбоотой анхан шатны статистик дүн шинжилгээ, боловсруулалт хийх бололцоогоор хангагдсан байдаг. ДБГ-ын худалдааг хөнгөвчлөх асуудал хариуцсан зөвлөх Робэрт Стрүтэрс ДГБ-ын ЦХС-ны мэдээллийн баазад орсон өгөгдөлд боловсруулалт хийсэн ба дүн шинжилгээний үр дүнг ГЕГ болон МХЕГ-ын холбогдох төлөөллүүдэд урьдчилан танилцуулж, зөвлөмжийг боловсруулсан болно. Судалгааны үр дүн, зөвлөмжийг дараах бүлгүүдэд дэлгэрүүлэн авч үзсэн болно.

<sup>30</sup> Хэт хэлбэлзэлтэй утга (outlier)-д дундаж утгаас 1.5 дахин их эсвэл бага байх утгыг авч үзсэн ба үүнийг статистик аргачлалын дагуу тооцож гаргасан болно.

## ЦАГ ХУГАЦААНЫ СУДАЛГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

ДГБ-ын ЦХС-ны мэдээллийн баазад цугларсан өгөгдлийн дүн шинжилгээ, түүний үр дүнд үндэслэн судалгаанд авч үзэж буй 6 хилийн боомт, өртөө, 2 гүний терминалд авто зам, агаар, төмөр замын тээврээр барааг импортоор оруулах эсхүл экспортоор гаргахад зарцуулагдаж буй нийт дундаж цаг хугацаа, түүнчлэн бараа импортлох, экспортлохтой холбоотой зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авахад шаардагдаж буй дундаж хугацааг Хүснэгт 4 -т нэгтгэн харууллаа.

Хүснэгт 4. Барааг хилээр оруулах, гаргахад зарцуулагдаж буй нийт дундаж хугацаа

Тээврийн хэрэгслийн төрөл, хилийн боомт, терминал	Дундаж хугацаа (өдөр, цаг, минут)
<b>1. Авто тээврээр орж ирж буй импорт</b>	
1.1. Хилийн боомт болон гүний терминалын нийт дундаж хугацаа-бараа гүний терминал дээр олгогдох	3 өдөр 12 цаг 7 минут
1.1.1. Алтанбулаг хилийн боомт -Монгол Транс гүний терминал	6 өдөр 15 цаг 7 минут
1.1.2. Замын-Үүд хилийн боомт - Монгол Транс гүний терминал	3 өдөр 1 цаг 12 минут
1.2. Хилийн боомтын дундаж хугацаа – бараа хилийн боомт дээр олгогдох	16 цаг 52 минут
1.2.1. Замын-Үүд хилийн боомт	18 цаг 25 минут
1.2.2. Алтанбулаг хилийн боомт	7 цаг 50 минут
1.2.3. Цагааннуур хилийн боомт	6 цаг 23 минут
1.3. Гүний терминалын дундаж хугацаа – бараа Монгол Транс гүний терминал дээр олгогдох	1 өдөр 18 цаг 58 минут
<b>2. Шилжүүлэн ачилтын импорт: Авто замаар орж ирсэн чингэлэг төмөр замаар гүний терминал руу шилжүүлэгдэн ачигдах</b>	
2.1. Хилийн боомт болон гүний терминалын нийт дундаж хугацаа – бараа АБТЭМА гүний терминал дээр олгогдох	3 өдөр 40 минут
2.2. Хилийн боомтын дундаж хугацаа	1 өдөр 16 цаг 40 минут
2.3. АБТЭМА гүний терминалын дундаж хугацаа	19 цаг 52 минут
<b>3. Төмөр замаар орж ирж буй импорт</b>	
3.1. Хилийн боомт ба гүний терминалын нийт дундаж хугацаа – бараа АБТЭМА гүний терминал дээр олгогдох	4 өдөр 20 цаг 10 минут
3.1.1. Замын-Үүдийн НЦШАА өртөө-АБТЭМА гүний терминал	4 өдөр 16 цаг 18 минут
3.1.2. Сүхбаатар өртөө – АБТЭМА гүний терминал	5 өдөр 19 минут
3.2. Хилийн боомтын дундаж хугацаа	1 өдөр 2 цаг 57 минут
3.2.1. Замын -Үүдийн НЦШАА өртөө	1 өдөр 13 цаг 26 минут
3.2.2. Сүхбаатар өртөө	14 цаг 28 минут
3.3. АБТЭМА гүний терминалын дундаж хугацаа	2 өдөр 9 цаг 40 минут
3.3.1. Замын-Үүдийн НЦШАА өртөөнөөс ирсэн бараа	1 өдөр 20 цаг 40 минут
3.3.2. Сүхбаатар өртөөнөөс ирсэн бараа	2 өдөр 23 цаг 50 минут
<b>4. Агаарын тээврээр орж ирж буй импорт</b>	
4.1. Хилийн боомтын дундаж хугацаа – бараа Буянт-Ухаа хилийн боомт дээр олгогдох	2 өдөр 12 цаг 32 минут
<b>5. Агаарын тээврээр гарах экспорт</b>	



5.1. Хилийн боомтын дундаж хугацаа – бараа Буянт-Ухаа хилийн боомтоос экспортлогдох	18 цаг 25 минут
5.2. Гүний терминал болон хилийн боомтын нийт дундаж хугацаа-бараа гүний терминалаас ирж Буянт-Ухаа хилийн боомтоор гарах (захиалга дуудлага)	4 өдөр 20 цаг 35 минут
<b>6. Авто тээврээр гарах экспорт</b>	
6.1. Хилийн боомтоос гарах экспортын дундаж хугацаа	5 цаг 20 минут
6.1.1. Цагааннуур хилийн боомтоос гаргах экспорт	2 цаг 32 минут
6.1.2. Замын-Үүд хилийн боомтоос гаргах экспорт	5 цаг 28 минут
6.2. Гүний терминалаас ачигдсан экспортын барааны хилийн боомт дээрх дундаж хугацаа	6 цаг 4 минут
6.3. “Захиалга дуудлага”-ын экспортын гүний терминалын дундаж хугацаа	2 өдөр 12 цаг 37 минут
6.4. “Захиалга дуудлага”-ын экспорт: Гүний терминал болон хилийн боомтын нийт дундаж хугацаа <sup>31</sup>	2 өдөр 18 цаг 51 минут
<b>7. Төрийн болон ТББ-аас экспорт, импортын зөвшөөрлийг олгогдохтой холбоотой дундаж хугацаа</b>	
7.1. Зөвшөөрөл авахад шаардагдах нийт дундаж хугацаа	11 цаг 56 минут
7.1.1. Мал эмнэлгийн ерөнхий газар	2 өдөр 2 цаг 16 минут
7.1.2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	14 цаг 54 минут
7.1.3. Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар	28 минут
7.1.4. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	33 минут

Хилийн хяналтын үйл ажиллагааны цаг хугацааны хэмжилтийн нарийвчилсан шинжилгээг тээврийн төрөл, худалдааны горим нэг бүрээр авч үзэхдээ хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны технологийн ерөнхий дараалал, түүнд хамаарах процедур тус бүрээр гаргахыг зорьсон бөгөөд нийтлэг байдлаар нь: (i) бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа, (ii) хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа (iii) гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа гэсэн үндсэн гурван хэсэгт хуваан шинжилсэн болно (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Хилийн хяналтын процедур, тэдгээрт хамаарах үйл явцын ангилал, худалдааны горимоор

Хяналтын процедур	Авто зам болон агаараар гарах экспортын процедур (захиалга дуудлагын экспортыг оруулаад)	Авто зам, төмөр зам, агаараар оруулах импортын процедур
1. <b>Гаалийн бүрдүүлэлтийн өмнөх (ГБӨ) үйл ажиллагаа:</b> Тээврийн хэрэгсэл ГХБ-д ирэх, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах зэрэг барааг гаальд мэдүүлэхээс өмнөх процессуудаас бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Тээврийн хэрэгсэл гаалийн хяналтын бүс (ГХБ) эсхүл түр ГХБ (захиалга дуудлагын экспортын хувьд), терминалд ирэх/оруулах;</li> <li>- Гаалийн хяналтанд авах, бүртгэх;</li> <li>- Ачаа барааг пүүлэх,</li> <li>- Рентгенээр оруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тээврийн хэрэгслийг улсын хилээр эсхүл ГХБ-г оруулах;</li> <li>- Хил хамгаалах пост, шалганы цэг дээр паспортын шалгалт, бүртгэл хийх;</li> <li>- Гаалийн хяналтанд авах, CAIS сүлжээнд бүртгэх, ГХБ-г хувиарлах;</li> <li>- Ачаатай тээврийн хэрэгслийг пүүлэх (авто зам),</li> <li>- Галт тэрэг, вагонд гадна үзлэг хийх (төмөр зам);</li> </ul>

<sup>31</sup> Гүний терминалаас хилийн боомт руу авто замаар тээвэрлэгдэх тээврийн хугацаа ороогүй болно.

		<ul style="list-style-type: none"> <li>- Хятад/Оросын АВХ-чид галт тэрэг, вагоны бичиг баримтыг боловсруулах-вагоны хүснэгтийг орчуулах, бүртгэх (төмөр зам);</li> <li>- Агаарын карго терминалд ачааг оруулах (агаар);</li> <li>- ХШГУБ бичиг баримтын хуудас бүрийг дугаарлан, гаалийн хяналтанд дардас дарах;</li> <li>- Рентгенээр шалгах,</li> <li>- манифест бичих-шалгах, баталгаажуулах (төмөр зам болон шилжүүлэн ачилтын хувьд вагоны дугаар олгох)</li> </ul>	
2.	<p><b>Хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:</b> Хилийн боомт болон гүний терминал дах мэргэжлийн хяналтын бүхий л үйл ажиллагаанаас бүрдэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хилийн мэргэжлийн хяналт (ХМХ)-нд хамрагдах эсэх, мэргэжлийн хяналтын төрөл, эрсдэлийн төвшинг тогтоох;</li> <li>- бичиг баримтыг шалгах, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх;</li> <li>- биет үзлэг хийх, зөрчлийг хянан шийдвэрлэх;</li> <li>- экспортлогч ААН-ийн байранд ирж ачаа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих (захиалга дуудлагын экспортын хувьд);</li> <li>- дээж авах, лабораторит шинжлэх; зөрчил гарсан бол түүнийг шийдвэрлэх эсхүл давтан дээж авч, шинжилгээнд явуулах;</li> <li>- Экспортын гэрчилгээг баталгаажуулах, Хяналтанд хамрагдсан хуудас (ХХХ), дамжин тээвэрлэх хуудас бичиж өгөх үйл явцуудаас бүрдэнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тээврийн хэрэгсэлд халдваргүйтэл хийх (авто зам),</li> <li>- ХМХ-нд хамрагдах эсэх, мэргэжлийн хяналтын төрөл, эрсдэлийн төвшинг тогтоох;</li> <li>- Бичиг баримтыг шалгах, зөрчил илэрсэн бол хянан шийдвэрлэх;</li> <li>- Бага эрсдэлтэй бараанд ХХХ олгох;</li> <li>- Их, дунд эрсдэлтэй бараанд биет үзлэг хийх, дээж авах, лабораторит шинжлэх, зөрчил илэрсэн бол шийдвэрлэх эсхүл давтан дээж авч, шинжилгээнд явуулах;</li> <li>- Импортын гэрчилгээг баталгаажуулах, ХХХ, Дамжин тээвэрлэх хуудас, хяналтын хуудас бичиж өгөх зэрэг болно.</li> </ul>
3.	<p><b>Гаалийн бүрдүүлэлтийн<sup>32</sup> үйл ажиллагаа:</b> Барааг мэдүүлэх, бичиг баримтын шалгалт, биет шалгалт, мэдүүлэгчийн сонгосон горимд<sup>33</sup> байршуулж ГХБ-ээс гаргах гэсэн процессуудаас бүрдэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн (ГБМ) барааг мэдүүлэх<sup>34</sup>, эрсдэлийн төлөв сонгогдох<sup>35</sup>;</li> <li>- Гаалийн улсын байцаагч (ГУБ) бичиг баримт<sup>36</sup>, гаалийн мэдүүлгийг<sup>37</sup> шалгах, алдаатай бол түүнийг засуулах, зөрчилтэй бол түүнийг хянан шийдвэрлэх;</li> <li>- гаалийн татвар, хураамж төлөх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ГБМ барааг мэдүүлэх, эрсдэлийн төлөв сонгогдох;</li> <li>- ГУБ бичиг баримт, мэдүүлгийг шалгах, алдааг засуулах;</li> <li>- татвар, хураамж, төмөр зам болон терминалын төлбөрийг төлөх;</li> <li>- Рентгенээр шалгах (шилжүүлэн ачилт-авто зам замын ГХБ);</li> <li>- Ачааг тээврийн хэрэгслээс буулгах, биет шалгалтанд бэлтгэх;</li> </ul>

<sup>32</sup> “Гаалийн бүрдүүлэлт” – гаалийн хилээр оруулсан барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс эхэлж, бичиг баримт болон барааг шалгах, татварыг ногдуулж хураан авсны дараагаар барааг эзэнд нь олгох эсхүл улсын хилээр гаргадаг гаалийн байгууллагаас хэрэгжүүлдэг цогц үйл ажиллагааг хэлдэг.

<sup>33</sup> “Горим сонгох” – Гаалийн тухай хуулийн 73 дугаар зүйл. Гаалийн бүрдүүлэлтийн горим сонгох 73.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг мэдүүлэгч сонгоно.

<sup>34</sup> “Мэдүүлэх” гэдэг нь улсын хилээр нэвтрүүлсэн бараатай холбоотой мэдээллийг гаалийн байгууллагад өгөх ажиллагаа болно. Мэдүүлэгч нь экспорт, импортын барааг мэдүүлэх дурын этгээд байдаг.

<sup>35</sup> “Эрсдэлийн төлөв” -Гаалийн байгууллагаас урьдчилан тогтоосон шалгуурын үндсэн дээр улсын хилэр нэвтрүүлэх бараанд хийх гаалийн шалгалтын түвшинг улаан, улбар шар, ногоон өнгөөр илэрхийлдэг.

<sup>36</sup> “Бичиг баримт”- мэдүүлэгч барааг гаальд мэдүүлэхийн өмнө гаалийн бүрдүүлэлтийн нэг горимыг сонгох ёстой бөгөөд сонгосон горимынхоо дагуу худалдааны бичиг баримтыг гаальд гаргаж өгөх үүрэг хүлээдэг.

<sup>37</sup> “Гаалийн мэдүүлэг” – мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах мэдээлэл агуулсан бичиг баримт болно.

	<ul style="list-style-type: none"> <li>- дээж авах, гаалийн лабораторийн шинжилгээ хийх<sup>38</sup>, алдаа, зөрчил илрүүлсэн бол түүнийг засварлуулах, шийдвэрлэх;</li> <li>- биет шалгалт<sup>39</sup> болон дахин шалгалт хийх;</li> <li>- ХШГУАБ-д бүртгүүлж, захиалгын хуудсан дээр цохолт хийлгэх (захиалга дуудлагын экспортын хувьд);</li> <li>- Захиалга дуудлагын үйлчилгээний төлбөрийг барагдуулах;</li> <li>- Тээврийн хэрэгсэлд ачааг ачихад хяналт тавих, тээврийн хэрэгслийг битүүмжлэх<sup>40</sup>, пүүлэх;</li> <li>- Рентгенээр шалгах, тээврийн хэрэгслийн кабиныг шалгах (авто зам);</li> <li>- манифест бүрдүүлэх-шалгах-баталгаажуулах<sup>41</sup>;</li> <li>- “Гааль зөвшөөрөв” тэмдгэлгээ хийх;</li> <li>- карго терминалд оруулах, онгоцонд ачаалах, экипажид бичиг баримтыг хүлээлгэн өгөх (агаар);</li> <li>- ГХБ-ээс эсхүл Монгол Улсын хилээр гаргах үйл явцуудыг оруулсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаан эрсдэлийн төлөв бүхий бараанд биет шалгалт хийх, шаардлагатай бол давтан шалгах;</li> <li>- дээж авах, гаалийн хяналтын лабораторийн шинжилгээ хийх;</li> <li>- “Гааль зөвшөөрөв” тэмдгэлгээ хийх;</li> <li>- ГХБ-с гаргах үйл явцуудыг оруулсан.</li> </ul>
--	--	---

Нийтдээ 1725 асуулга судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийсэн ба нэгж асуулга судалгааг нэг ачаа бараа гэдгээр тооцсон бөгөөд гаалийн бүрдүүлэлтээр орсон 1582 импортын бараа, 143 экспортын бараанд хамаарах хилийн хяналтын үйл ажиллагааг шинжлэн, тэдгээрт зарцуулагдсан хугацааг тээврийн төрөл, худалдааны горим тус бүрээр хэмжиж гаргасан болно.

Судалгааны дүнгээс харахад гаалийн бүрдүүлэлтээр орсон экспортын барааны 70.3%, импортын барааны 80.1% нь эрсдэлийн улаан төлөвт сонгогдсон бөгөөд нийт бүрдүүлэлтийн 0.6%-д зөрчил илэрсэн бол гаалийн мэдүүлгийн 3.1%, манифестийн 1.4% нь алдаатай байсан үзүүлэлт гарчээ (Хүснэгт 6).

<sup>38</sup> “Гаалийн магадлан шинжилгээ” – Гаалийн тухай хууль, 252.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээ хийнэ.

<sup>39</sup> “Гаалийн шалгалт” -Гаалийн тухай хууль, зүйл 246. Гаалийн байгууллага, албан тушаалтан нь барааны гаалийн мэдүүлгийг хүлээн авсны дараа түүний үнэн зөвийг тогтоох зорилгоор бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийнэ.

<sup>40</sup> “Битүүмжлэл хийх” – Гаалийн тухай хууль, 261 дүгээр зүйл. Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх: 261.1.Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ (цаашид “гаалийн тэмдэглэгээ” гэх) хийхдээ лац, ломбо, үсгэн болон бусад тэмдэглэгээ тавих, марклах, тээврийн болон худалдааны бичиг баримтад хяналтын тэмдэг дарах, сорьц, дээж, загвар авах, бараа, тээврийн хэрэгслийн шинж байдлыг дэлгэрэнгүй тодорхойлон бичих, фото зураг авах, бичлэг хийх, зураг, бүдүүвч зураг гаргах зэрэг боломжтой бүхий л аргыг хэрэглэнэ.

<sup>41</sup> “Манифест” - Манифест нь бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах баримт бичиг болох бөгөөд гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч гаалийн автоматжуулсан систем дэх дэд программд нөхөн бичдэг. ГЕГ-ын даргын 2019 оны тушаал А/281 “Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам”

Хүснэгт 6. Экспорт, импортын барааны гаалийн хяналт, бүрдүүлэлтийн дүн: Илэрсэн зөрчил, лабораторийн шинжилгээ, мэдүүлэг болон манифестийн алдаа

Худалдааны горим	Эрсдэлийн төлөвөөр (барааны тоогоор)			Гаалийн мэдүүлгийн алдааны тоо	Манифестийн алдааны тоо	Лабораторийн шинжилгээний тоо	Илрүүлсэн зөрчлийн тоо
	Ногоон	Улбар шар	Улаан				
Экспорт	2	30	74	0	1	0	0
Импорт	28	250	1124	46	20	45	9
Захиалга дуудлагын экспорт	1	5	16	1	1	20	0
Шилжүүлэн ачилтын импорт <sup>42</sup>	0	1	4	0	0	0	0

Судалгаанд авч үзсэн экспортын барааны 36% нь мэргэжлийн хяналтанд хамрагдсан ба лабораторийн шинжилгээгээр орсон 1 экспортын барааны мэдээлэл бүртгэгдсэн байна (Хүснэгт 7). Хилийн мэргэжлийн хяналтаар орсон импортын 337 бараанд эрсдэлийн ангиллаар хяналт, шалгалт хийгдсэн бөгөөд шалгалтаар 2 зөрчил илрүүлэн хуулийн дагуу шийдвэрлэсэн. Судалгаанд хамрагдсан нийт импортын 6.1% буюу 94 бараанд гаальтай хамтарсан биет үзлэг хийсэн байна.

Хүснэгт 7. Экспорт, импортын барааны хилийн мэргэжлийн хяналтын дүн: Хяналтанд хамрагдсан байдал, лабораторийн шинжилгээ, илэрсэн зөрчил

Худалдааны горим	ХМХ-нд хамраагдаагүй барааны тоо	ХМХ-нд хамрагдсан барааны тоо	Эрсдэлийн төлөвөөр (барааны тоогоор)			Лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо	Хамтарсан шалгалтын тоо	Илрүүлсэн зөрчлийн тоо
			Бага	Дунд	Их			
Экспорт	0	31	0	0	0	1	4	0
Импорт	8	215 <sup>43</sup>	10	153	171	102	174	2
Захиалга дуудлагын экспорт	0	15	0	0	0	0	13	0
Шилжүүлэн ачилтын импорт	0	11	0	0	3	0	3	0

<sup>42</sup> “Шилжүүлэн ачилт” гэдэгт авто замаар орж ирсэн чингэлгийг төмөр замаар шилжүүлэн ачиж гүний терминал руу илгээсэн импортыг ойлгоно.


<sup>43</sup> Төмөр замын хилийн өртөө болон гүний терминалын мэргэжлийн хяналтаар давхар орсон барааны тоогоор

## 1. АГААРЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Импорт, экспортын нийт 268 асуулга судалгааны өгөгдөлд суурилан дүн шинжилгээ хийсэн ба импортын барааны хувьд онгоц Чингис хаан нисэх онгоцны буудал дээр газардсан үеэс бараа карго терминалаас гарах хүртэл буюу эзэндээ олгогдох, экспортын<sup>44</sup> хувьд ачаатай тээврийн хэрэгсэл карго терминал дээр ирсэн эсхүл гаалийн мэдүүлэг өгсөн үеэс эхлэн бараа онгоцонд ачигдах хүртэлх үйл ажиллагааг хамарсан болно. Экспортын асуулгаар цугларсан нийт судалгаа нь импортын судалгаанаас 3.3 дахин бага байсан нь судалгаа авч байх үед экспортоор гарах ачаа бараа бага байсантай холбоотой байж болох юм. Хүчингүй буюу дутуу бөглөгдсөн, түүнчлэн хэт хэлбэлзэлтэй утга бүхий судалгааг нийт түүврээс хассанаар импортын 206, экспортын 62 асуулга судалгааны өгөгдлийг ДГБ-ын цахим мэдээллийн баазад оруулж шинжилгээ хийлээ (Зураг 2).



Зураг 2. Агаарын тээвэрлэлтийн асуулга судалгааны тоо



Хүснэгт 8. Агаарын тээвэрлэлт: Барааг импортлох, экспортлох үйл ажиллагаанд тавих хяналтын нийт дундаж хугацаа

Үйл ажиллагааны процедур	Экспорт (карго терминалаас гарах)		Импорт (карго терминал дээр олгогдох)		Захиалга дуудлагаар гарсан экспорт	
	Барааны тоо	Дундаж хугацаа	Барааны тоо	Дундаж хугацаа	Барааны тоо	Дундаж хугацаа
Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа	47	1ц	199	1ө 2ц 11м <sup>45</sup>	0	0
Хилийн мэргэжлийн хяналт (ХМХ)	5	42м	20	5ц 22м	1	3ц
Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа	62	17ц 1м	201	9ц 44м <sup>46</sup>	1	4ө 20ц 35м

Тайлбар: Хяналтын үйл ажиллагаанд зарцуулагдаж буй цаг хугацааг хэмжих нэгж: “ө”-өдөр, “ц”-цаг, “м”-минут

<sup>44</sup> Агаарын тээврээр гарах “захиалга дуудлага”-ын экспортын хувьд УБГТ-ын бичиг баримтын бүрдүүлэлтийн алба эсвэл Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар дээр захиалга өгөх мөчөөс эхлэн ачаа бараа онгоцонд ачигдах хүртэлх процедурыг хамарна.

<sup>45</sup> Нисэх онгоц газардсан үеэс Тээвэрлэгч тээврийн бичиг баримтыг ачаа хүлээн авагчид эсхүл ХШГУБ-д өгсөн дундаж хугацааг хамруулсан.

<sup>46</sup> ГБМ CEPS-д барааны мэдээллийг оруулж CAIS-д илгээсэн үеэс ГХБ-ээс гаргасан хугацаа хамаарна.

Дүн шинжилгээнээс харахад “захиалга дуудлага”-ын экспорт буюу гүний гаальд бүрдүүлэлт хийгдэж улсын хилээр гаргасан экспортын цаг хугацаа Буянт-Ухаа хилийн боомтоос гарсан экспорт болон тухайн боомт дээр эзэндээ олгогдсон импортын барааны цаг хугацаатай харьцуулахад их гарсан байна.

Түүнчлэн хилийн боомт дээр олгогдох импортын бараанд хэрэгжүүлдэг хяналтын үйл ажиллагааны хугацаа нь карго терминалаас шууд экспортлогддог барааны үйл ажиллагаанаас их байв (Хүснэгт 8).

## 1.1. АГААРЫН ТЭЭВРЭЭР ГАРГАХ ЭКСПОРТ

ДГБ-ын цахим мэдээллийн баазад цугласан өгөгдлийн дүн шинжилгээнээс харахад экспортын барааг терминалын ГХБ-д оруулсан үеэс онгоцонд ачиж, бичиг баримтыг битүүмжилж онгоцны экипажид хүлээлгэн өгч улсын агаарын хилээр гаргах хүртэлх буюу хилийн боомтоос шууд экспортлох **нийт дундаж хугацаа 18 цаг 25 минут** байв. Экспортод амьд мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, ноос, ноолуур түлхүү гарсан бөгөөд эдгээр экспортын барааг хамгийн багадаа 5 цаг 50 минутад, хамгийн ихдээ 2 өдөр 7 минутын хугацаанд улсын хилээр гаргасан байна. Карго терминалаас барааг шууд экспортлоход импортлохоос 2 дахин бага хугацаа зарцуулагдсан.


### 1.1.1. Барааг нисэх буудлын карго терминалаас экспортлох үйл ажиллагаа

Шууд экспортод Буянт-Ухаа хилийн боомтын карго терминал дээр ачаатай тээврийн хэрэгсэл хүрч ирсэн эсхүл гаалийн мэдүүлэг өгч эхэлсэн үеэс барааг онгоцонд ачин агаарын хилээр гаргах хүртэлх үйл ажиллагааг хамруулан ойлгох ба судалгаа авах үеэр нийт 62 бараа экспортоор гарсан байна (Зураг 3).

Хүснэгт 9. Буянт-Ухаа хилийн боомт: Барааг карго терминалаас экспортлоход зарцуулагдаж буй дундаж хугацааг

Үйл ажиллагааны процедур	Агаарын хөлөгт ачихад бэлтгэх, ачих	ХМХ	Гааль
Үйл ажиллагааны нийт дундаж хугацаа	15ц 53м	42м	3ц 20м
Хүлээлгийн <sup>47</sup> дундаж хугацаа	13м 42м	18м	36м

Зураг 3. Агаараар гарах экспортын үйл ажиллагааны нийт дундаж хугацаа, үйл явц тус бүрээр




Тайлбар: Хяналтын үйл ажиллагаанд зарцуулагдаж буй цаг хугацааны хэмжилтийн нэгж: Жишээ нь, 18:25 гэдэг нь 18 цаг, 25 минут; ГБӨ-гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа

<sup>47</sup> Хүлээлгийн хугацаа гэдэгт хяналтын нэг үйл явц дууссан үеэс дараагийн үйл явц эхлэх хүртэлх хугацааг ойлгоно.

Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа:

Экспортын нийт үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хугацааны дийлэнх буюу 80 хувь нь ачаа нислэгээ хүлээж терминалд байршсан, тэндээс гаргаж онгоцонд ачих, онгоц хөөрөх хүртэлх үйл явцад хамаарч байна (Зураг 4).

Зураг 4. Агаараар гарах экспортын үйл ажиллагаа, үйл явцын эзлэх хувиар




Тайлбар: А/бараа-Ачаа бараа; ГБӨ-Гяалийн бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа

Хилийн мэргэжлийн хяналт:


Нийт экспортын барааны 8% орчимд мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн болон эрүүл ахуйн хяналтыг хэрэгжүүлэхэд дунджаар 42 минут зарцуулсан байна. Үүнээс хилийн мэргэжлийн хяналтын байцаагч (ХМХБ) бичиг баримтыг хүлээн авч шалгаж эхлэх хүртэл дунджаар 4 минут, бичиг баримтын шалгалт хийхэд 8 минут, биет үзлэг хийхэд 15 минут, биет шалгалт дуусаж экспортын гэрчилгээг баталгаажуулан “Хяналтанд хамрагдсан мэдэгдэл” (ХХМ) бичиж экспортлогчид өгөхөд дунджаар 5 минут, мөн үйл явц хоорондын хүлээлгийн хугацаанд 10 минут тус тус зарцуулсан байна. Барааг экспортлохын өмнө холбогдох хууль тогтоомжийн дагуу МЭЕГ, МХЕГ, СХЗГ-аас бараанд нэр төрлөөс нь хамаарч олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, экспортын гэрчилгээг олгодог боловч хилийн боомт дээр экспортын гэрчилгээг дахин баталгаажуулж, хяналтанд хамрагдсан хуудас (ХХХ) олгодог бөгөөд энэ бүх гэрчилгээ, мэдэгдлүүд бүгд цаасан хэлбэртэй байна.

Зураг 5. Агаараар гарах экспорт: Хилийн мэргэжлийн хяналтын биет үзлэгийн дундаж хугацаа, хяналтын төрлөөр



Нийт 5 экспортын бараанд мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн, хүнсний, эрүүл ахуйн хяналт шалгалтыг хийхэд 10-30 минут зарцуулсан байна (Зураг 5). Үүнээс 4 бараанд биет үзлэгийг нисэхийн аюулгүй байдал хамгаалалтын алба болон гаалийн байцаагчтай хамтарч рентген аппаратаар хийсэн бөгөөд хүнсний хяналтыг хамгийн багадаа 7 минут, хамгийн ихдээ 30 минутын хугацаанд хийсэн байна.


Зураг 6. Агаараар гарах экспорт: ХМХ-ын бичиг баримтын шалгалт болон биет үзлэгийн нийт дундаж хугацаа



Тайлбар: Б/б-ын шалгалт- бичиг баримтын шалгалт

ХМХ-ын үйл явц хоорондын нийт хүлээлгийн дундаж хугацаа нь 18 минут байна. Судалгааны явцад карго терминалаас шууд экспортлогдож буй бараанаас хилийн мэргэжлийн хяналтын лабораториор орсон тохиолдол бүртгэгдээгүй ба бичиг баримтын шаардлага хангаагүй болон зөрчил илэрсэн тохиолдол гараагүй байна (Зураг 7).

Зураг 7. Агаараар гарах экспорт: ХМХ-ын үйл явц хоорондын хүлээлгийн дундаж хугацаа



Тайлбар: ХХМ-Хяналтанд хамрагдсан мэдээгдэл; Б/б-бичиг баримт

Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:

Нийт 62 барааг экспортлоход гаалийн хяналтын үргэлжлэх хугацаа нь бусад үйл явцаас урт байгаа бөгөөд үүнд ГХБ-д барааг оруулсан үеэс эхлэн ачааг тээвэрлэлтэд хүлээлгэн өгч, хуваарьт нислэгийг хүлээн карго терминал дах гаалийн хяналтад байх хугацаа хамаарч байна.

Нийт гаалийн мэдүүлгийн 54% нь улаан, 43% нь улбар шар, 3% нь ногоон төлөвт сонгогдсон байна. Хяналтын улаан төлөвт сонгогдсон экспортын барааны гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлтэнд зарцуулсан хугацаа ногоон төлөвт сонгогдсон барааныхаас бага байна. Санамсаргүй сонголтоор сонгогдсон экспортын бараанд




эрсдэлийн төлөвөөс хамааралгүйгээр гаалийн бичиг баримтын болон биет шалгалтыг хийдэг байна (Зураг 8).

Зураг 8. Агаарын тээврээр гарах экспорт: Гаалийн үйл ажиллагааны нийт дундаж хугацаа<sup>48</sup>, эрсдэлийн төлвөөр



Зураг 9. Агаарын тээврээр гарах экспорт: Гаалийн үйл явц тус бүрийн дундаж хугацаа



Гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаанд дунджаар 1 цаг 52 минут, экспортын барааны бичиг баримтын шалгалтад 5 минут, хяналтын улаан төлөвтэй барааны шалгалтад 6 минут, хяналтын ногоон, улбар шар төлөвт сонгогдсон барааны хураамжийг төлөхөд 19 минут, манифест бичих, шалгахад 6 минут тус тус зарцуулагджээ (Зураг 9).


Гаалийн хяналтын нийт дундаж хугацаа 1 цаг 28 минут байв. Ногоон төлөв бүхий бараанд гаалийн шалгалтыг хамгийн урт хугацаанд буюу 1 цаг 57 минутад хийсэн байтал улаан төлөвтэй бараанд дунджаар 1 цаг 34 минутын хугацаанд шалгасан. Судалгааны явцад гаалийн лабораторийн шинжилгээнд хамрагдсан бараа бүртгэгдээгүй ба илэрсэн зөрчлийн талаарх мэдээлэл олдоогүй болно.

Гаалийн байгууллагын хяналт, шалгалт, бүрдүүлэлтийн үйл явц бүрийн хооронд гарсан хүлээлгийн дундаж болон хамгийн их хугацааг Зураг 10-т үзүүлэв.


Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн хугацаа дунджаар 32 минут, хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн дундаж хугацаа 18 минут байсан бол гаалийн хяналтын үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн нийт дундаж хугацаа 1 цаг 54 минут буюу хамгийн ихдээ 10 цаг 37 минутын хугацаанд үргэлжилсэн байна.

<sup>48</sup> Ачаа барааг карго терминалд байршуулах, нислэгт бэлдэх үйл ажиллагаа ороогүй

Зураг 10. Агаараар гарах экспорт: Гаалийн үйл явц хоорондын хүлээлгийн дундаж болон хамгийн их хугацаа



Зураг 11. Агаараар гарах экспорт: Ачааг тээвэрлэлтэд бэлтгэх үйл ажиллагааны нийт дундаж болон хамгийн их хугацаа, үйл явц тус бүрээр



Тайлбар: 43:28 - 1 өдөр, 19 цаг, 28 минут

Экспортын ачааг карго терминалд хүлээн авч байршуулан нисэх онгоцонд ачиж гаргахад хамгийн их цаг хугацаа шаардагдсан байна (Зураг 11).


### 1.1.2. Агаарын тээврээр гаргах “захиалга дуудлага”-ын экспортын үйл ажиллагаа

Судалгааны хугацаанд “захиалга дуудлага”-ын үйлчилгээгээр буюу гүний гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хамрагдан агаарын тээврээр гарсан малын дайвар бүтээгдэхүүн бүхий 1 илгээлтийн мэдээлэл бүртгэгдсэн ба нийт экспортын үйл ажиллагаанд **4 өдөр 20 цаг 35 минутын** хугацаа шаардагдсан нь карго терминалаас шууд экспортлохоос дунджаар даруй 6 дахин их хугацаа зарцуулагдсан бөгөөд гүний

гаалийн хяналтын бүсээс гарч нисэх буудлын карго терминал дээр ирэхэд 4 өдөр 13 цаг 55 минут шаардагдсан байна.

Зураг 12-оос харахад мэргэжлийн хяналтанд 3 цаг, хяналтын улаан төлөвтэй барааны гаалийн шалгалтад 22 цаг 42 минут, карго терминалын үйл ажиллагаа (рентгенээр шалгах, пүүлэх, зөөвөрлөх машинд ачих, онгоцон ачих)-нд 2 цаг 5 минутыг тус тус зарцуулсан байна. Хяналт шалгалтын гаалийн улсын ахлах байцаагч (ХШГУАБ) манифестийг зөвшөөрч ачаа барааг гүний ГХБ-ээс гаргасан үеэс карго терминалд байршуулах хүртэлх хугацаа буюу 4 өдөр 13 цаг 55 минут нь нисэх буудлын терминалд ирэх тээвэрлэлттэй холбоотой хугацаа юм (Зураг 13).

Зураг 12. Агаараар гарах “захиалга дуудлага”-ын экспортын үйл ажиллагааны нийт хугацаа, хяналтын үйл ажиллагаагаар



Тайлбар: 116:35 – 4 өдөр, 20 цаг 35 минут; МХяналт-мэргэжлийн хяналт

Зураг 13. Агаараар гарах “захиалга дуудлага”-ын экспорт: Экспортын хяналтын үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн дундаж хугацаа



Тайлбар: 109:55- 4 өдөр, 13 цаг, 55 минут; ГБМ-Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн

## 1.2. АГААРЫН ТЭЭВРЭЭР ОРУУЛАХ ИМПОРТ

Судалгааны хугацаанд нисэх онгоцоор карго терминалд бууж, гаалийн бүрдүүлэлт хийн эзэндээ олгогдсон нийт 206 барааны мэдээлэл бүртгэгдсэн. Агаараар орж ирж буй импортын бараанд машин тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг, хими, эм, эмийн бүтээгдэхүүнүүд давамгайлсан байна. Эдгээр бараа, бүтээгдэхүүнийг импортлоход дунджаар **2 өдөр 12 цаг 32 минутын** хугацаа шаардагдсан бөгөөд үүний дийлэнх

хугацаа буюу 2 өдөр 46 минут нь гаалийн бүрдүүлэлтийн өмнөх процедурт ногдож байна (Зураг 14).

Зураг 14. Агаараар орж ирж буй импорт: Ачаа бараа хилийн боомт дээр эзэндээ олгогдох нийт дундаж хугацаа, үйл ажиллагаагаар




Тайлбар: 48:46- 2 өдөр, 46 минут; 60:32- 2 өдөр, 12 цаг, 32 минут

#### Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа:

Бараа импортлох үйл ажиллагааны дийлэнх хугацааг барааг гаалийн хяналтад авах буюу бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаанд хамаарах бараа, илгээлтийг дагалдах бичиг баримтыг хяналтад авах, манифест нөхөн бичих, шалгах, алдааг засуулах, бичиг баримтыг дамжуулах зэрэгт зарцуулж байгаа бөгөөд үүнд нийт хяналтын хугацааны 76% ногдож байна (Зураг 15).

Зураг 15. Агаараар орж ирж буй импорт: Нийт хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, хувиар



#### Тээвэрлэгчийн үйл ажиллагаа:


Агаараар оруулсан 206 импортын барааны гаалийн хяналтанд авсан бичиг баримтыг тээвэрлэгч хүлээн авч, ачааны манифестийг CEPС-д шивж оруулах үйл явцаас эхлэн хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч (ХШГУБ) манифестийг шалган баталгаажуулж гаалийн улсын ахлах байцаагч (ГУАБ) зөвшөөрөх хүртэл дунджаар 5 цаг 11 минут зарцуулагдсан бөгөөд энэ үйл явц нь хамгийн багадаа 5 минут, хамгийн ихдээ 6 өдөр 3 цаг 40 минутын хугацаа шаардсан байна (Зураг 16).

Зураг 16. Агаараар орж ирж буй импорт: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа



Манифест нь бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах баримт бичиг болох бөгөөд гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч гаалийн автоматжуулсан систем дэх дэд программд нөхөн бичдэг. Тээвэрлэгч илгээлтийг дагалдах холбогдох бичиг баримтуудыг хүлээн авч, СЕРС программд ачааны манифестийг оруулж, CAIS сүлжээнд илгээхэд дунджаар 19 минут зарцуулагдсан (Зураг 16) бол гааль манифестийг шалгахад 3 цаг 44 минут, алдаатай манифестийг тээвэрлэгчээр засварлуулахаар буцаахад дунджаар 40 цаг 11 минутыг зарцуулжээ (Зураг 17).

Зураг 17. Агаараар орж ирэх импорт: Манифестийн мэдээллийг шалгахад зарцуулагдаж буй дундаж хугацаа



Тайлбар: 40:11- 1 өдөр, 16 цаг, 11 минут


Судалгааны үеэр тээвэрлэгч манифестийг алдаатай шивсэн 19 тохиолдол (нийт манифестийн 9.2%) илэрсэн ба ХШГУБ бичлэгийг нягтлан шалгаж алдааг илрүүлэхэд дунджаар 9 цаг 34 минут зарцуулсан бөгөөд зарим манифестийг шалгахад дээд тал нь 5 өдөр 23 цаг 52 минут болсон байна. Эдгээр алдаатай манифестийг засварлахад тээвэрлэгч дунджаар 1 өдөр 6 цаг 31 минутыг зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл, хоёр манифестийн алдааг засварлахад хамгийн бага хугацаа буюу 1-3 минут зарцуулсан бол 6 манифестийн алдааг засварлахад 2-3 өдөр буюу хамгийн ихдээ 4 өдөр 10 цаг 30 минут зарцуулсан байна. Судалгааны үеэр хийсэн ажиглалтаар ХШГУБ онгоц тус бүрийн ачааны манифестийн мэдээллийг тухай бүр хяналгүй, 3-4 онгоц буусны дараа бөөнд нь шалгах явдал гарч байсан тул дээрх хугацаа их гарахад нөлөөлсөн байх талтай юм.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас цахим агаарын тээвэр (e-Freight) салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлж, энэ хүрээнд Хойд Азийн бүсийн чиглэлийн үйл ажиллагааг шинэчилж, гаалийн<sup>49</sup>, тээврийн<sup>50</sup>, худалдааны, ачааны тусгай бичиг баримтуудыг<sup>51</sup> цахимжуулсан байгаа бөгөөд МИАТ компани аэропортоос-аэропорт хооронд тээвэрлэх экспортын карго ачаанд e-AWB, e-manifest-ийг хэрэглэдэг болоод байна. Судалгааны явцад карго терминалд бүртгэл, хяналт, баримт бичиг бүрдүүлэх бүхий л ажиллагааг олон шат дамжлагатайгаар, давхардуулан, цаасаар хийж байгаа нь импортын хугацаа сунжрахад нөлөөлж байна.


Хилийн мэргэжлийн хяналт:

Судалгааны явцад бүртгэгдсэн нийт 206 импортын бараанаас 20 бараа хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдсан бөгөөд үүнд нийт дунджаар 5 цаг 22 минут зарцуулагдсан байна (Зураг 14, 18).

Зураг 18. Агаараар орж ирж буй импорт: ХМХ-ын нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр



Зураг 19. Агаараар орж ирж буй импорт: ХМХ-ын нийт дундаж хугацаа, үйл ажиллагаа тус бүрээр




<sup>49</sup> Гаалийн баримт бичгүүдэд: Export Goods Decl., Export Cargo Decl. Customs Release Exp, Import Goods Decl. Import Cargo Decl., Customs Release Imp

<sup>50</sup> Энэ баримт бичгүүдэд: Flight Manifest, Air Waybill, House Manifest

<sup>51</sup> Үүнд: Commercial Invoice, Packing List, House Waybill

Их, дунд эрсдэлтэй бараанд биет үзлэг хийснээс хойш дунджаар 4 цаг 48 минутын хүлээлгийн хугацаанд “Импортын мэдэгдэл” болон “Хяналтад хамрагдсан хуудас”-ыг олгосон байна (Зураг 19).

Зураг 20. Агаараар орж ирж буй импорт: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, хяналтын төрлөөр




Эм, эмийн бүтээгдэхүүн болон химийн бодисын хяналтанд хамрагдсан барааны 60% нь их, дунд эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүнээр тодорхойлогдсон боловч лабораторийн шинжилгээний мэдээлэл бүртгэгдээгүй бөгөөд импортын бараанд хэрэгжүүлж буй хяналтын нийт хугацаа нь экспортод шаардагдсан хугацаанаас 2.7 дахин их байна.

Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:

Барааг гаальд мэдүүлэхэд дунджаар 19 цаг 24 минут, мэдүүлснээс хойш бараа эзэндээ олгогдоход дунджаар 9 цаг 44 минутын хугацаа шаардагдсан байна.

Мэдүүлэгч нь барааг гаальд мэдүүлэх гаалийн гадаад холболтын систем СЕРС программыг ашиглан барааны мэдүүлэг нөхөн бичиж, CAIS систем руу илгээхэд хамгийн багадаа 2 минут, хамгийн ихдээ 6 өдөр 58 минутын хугацаанд мэдүүлсэн байна. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн (ГБМ) дунджаар 1 цаг 12 минутын хугацаанд алдаатай мэдүүлгийг зассан. Гаалийн төв лабораторийн (ГТЛ)-ын шинжилгээнд 1 бараа, бүтээгдэхүүнийг шинжлүүлэхэд 31 минут зарцуулагдсан бөгөөд зөрчил илрээгүй байна. Горимын дагуу шаардагдах бичиг баримтуудыг 1 цаг 20 минутын хугацаанд шалгасан бөгөөд барааны нэр төрлөөс хамаарч шалгалтын хугацаа ялгаатай байсан ба амьд мал, ургамал, тэдгээрийн гаралтай 3 бараа, бүтээгдэхүүний бичиг баримтыг шалгахад дунджаар 23 цаг 28 минутын хугацаа шаардагдсан байна (Зураг 21).

Зураг 21. Агаараар орж ирж буй импорт- Ачаа бараа хил дээр олгогдох: Бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, бараа бүтээгдэхүүний төрлөөр



Тайлбар: ТТ-тоног төхөөрөмж; ТХ-тээврийн хэрэгсэл, АҮ-Аж үйлдвэрийн бараа

ГБМ-ээс илгээсэн гаалийн мэдүүлгийг нягтлан шалгах явцад нийт бүрдүүлэлтийн 8,9% нь алдаатай байсан ба алдааг засварлуулахаар буцаахад дунджаар 4 цаг 24 минутыг зарцуулжээ. Улаан төлөв бүхий бараа бүтээгдэхүүний гаалийн алдаатай мэдүүлгийг засварлахад хамгийн ихдээ 18 цаг 40 минут шаардагдсан байна (Хүснэгт 10).


Хүснэгт 10. Агаараар орж ирж буй импорт: Гаалийн алдаатай мэдүүлгийг засварлах дундаж хугацаа

Эрсдэлийн төлөв	Судалгааны тоо	Нийт дундаж хугацаа	Хамгийн бага интервал	Хамгийн их интервал
Улбар шар	5	10 минут	2 минут	20 минут
Улаан	13	1 цаг 36 минут	2 минут	18 цаг 40 минут

Гаалийн бүрдүүлэлт буюу барааны мэдээллийг CAIS сүлжээгээр хүлээн авч мэдүүлгийг шалгах, алдааг засварлуулах, гаалийн болон бусад татварыг хураах, бараанд эрсдэлийн төлөвөөс хамаарч биет шалгалт хийх, зөрчил гарсан бол түүнийг хянан шийдвэрлэх, барааг мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах, ГХБ-ээс гаргах зэрэг үйл ажиллагаанд дунджаар 7 цаг 59 минутын хугацаа шаардагдсан байна. Импортын барааг мэдүүлсэн үеэс эзэнд нь олгох хүртэлх хугацаа эрсдэлийн төлвөөр ялгаатай байх бөгөөд энэхүү хугацаа ногоон төлөвт хамгийн их, улбар шар болон улаан төлөвт зарцуулагдсан дундаж хугацаа бараг ялгаагүй байна (Зураг 22). Түүнчлэн татвар төлөхөд шаардагдсан хугацаа ногоон болон улбар шар төлөвтэй гаалийн мэдүүлэгт дунджаар 7 цаг 38 минут байхад улаан төлөвт ердөө 2 минутын хугацаа орсон байна. Нийт импортын барааны 72.6% нь улаан, 25.9% нь улбар шар, 1.5% нь ногоон төлөвт тус тус сонгогдсон байсан.



Зураг 22. Агаараар орж ирж буй импорт-ачаа бараа хил дээр олгогдох: Гаалийн хяналт, шалгалтын нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлвөөр



Судалгаанд хамрагдсан нийт барааны 72.6 хувьд биет шалгалт хийгдсэн ба үүнд дунджаар 7 цаг 56 минут зарцуулагджээ. Биет шалгалтаар зөрчил илэрсэн, дахин шалгалт хийсэн гэсэн мэдээлэл бүртгэгдээгүй байна. Судалгааны явцад карго терминал дах рентген аппарат ажиллахгүй саатсан, өргөгч төхөөрөмжийн цэнэг дуусаж гар поогоор зөөж байсан тул жинлэх, рентген аппаратаар шалгах хугацааг удаашруулахад нөлөөлсөн<sup>52</sup>.

Агаарын тээврээр орж ирсэн 1 илгээлт дэх амьд загсанд түргэвчилсэн бүрдүүлэлт хийгдсэн гэж бүртгэгдсэн байна. Судалгааны үеэрх ажиглалт болон нийт цугласан мэдээллээс харахад түргэн гэмтэх, муудах, яаралтай, өндөр үнэтэй бараанд түргэвчилсэн, урьдчилсан бүрдүүлэлт бараг хийгддэггүй байна.

<sup>52</sup> ЦХС 2019: Мэдээлэл цуглуулсан техникийн тайлан, Хуудас 36


## 2. АВТО ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Авто замаар хийгддэг импорт, экспортын үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хугацааг тодорхойлохдоо Замын-Үүд, Цагааннуур, Алтанбулаг хилийн боомтууд болон Монгол Транс гүний терминалыг төлөөлөл болгон авч үзсэн болно. Импортын барааны хувьд (i) тээврийн хэрэгсэл улсын хилээр орж ирэн бараа хилийн боомт дээр эзэндээ олгогдох, мөн (ii) ачаа бараа хилийн боомтоос гүн рүү илгээгдэх, (iii) хилийн боомтоос ирсэн ачаа бараа Монгол Транс терминал дээр олгогдох; экспортын хувьд (i) ачаа бараа хилийн боомтоос шууд экспортлогдох, (ii) гүний гааль дээр бүрдүүлэлт хийгдсэн ачаа бараа хилийн боомт дээр ирж улсын хилээр гарах (iii) Улаанбаатар хотын гаалийн газар эсвэл Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар дээр экспортын захиалга<sup>53</sup> өгөх үеэс эхлэн тээврийн хэрэгсэлд ачигдсан ачаа бараа улсын хилээр гарах хүртэлх үйл ажиллагааг хилийн боомт, гүний терминал тус бүрээр шинжлэн, эдгээр үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хугацааг тодорхойлсон болно.



Судалгааны хугацаанд авто тээврээр хийгдсэн импорт, экспортын нийт 1209 асуулга судалгаа цугларсан ба дутуу, алдаатай бөглөгдсөн, түүнчлэн хэт хэлбэлзэлтэй утга бүхий судалгааг нийт түүврээс хассанаар давхардаагүй тоогоор импортын 1012, экспортын 58 асуулга судалгааны өгөгдлийг ДГБ-ын цахим мэдээллийн баазад оруулж шинжилгээ хийлээ.

Зураг 23. Авто тээврийн импорт, экспортын асуулга судалгааны тоо



<sup>53</sup> Захиалга дуудлагын экспортын хувьд гааль, мэргэжлийн хяналтын байцаагчид экспортлогч аж ахуйн нэгжийн байр, агуулах буюу түр ГХБ-д очиж хяналтын үйл ажиллагааг явуулдаг болно.

## 2.1. АВТО ТЭЭВРЭЭР ГАРГАХ ЭКСПОРТ

Авто машинаар тээвэрлэгдэн улсын хилээр гаргасан нийт 58 ачаа барааны мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн ба экспортын үйл ажиллагаанд зарцуулагдсан дундаж хугацаа дараах байдлаар гарав. Үүнд:

1. Авто замаар хилийн боомтоос бараа экспортлосон дундаж хугацаа: **5 цаг 20 минут**
  - 1.1. Замын-Үүд хилийн боомтын Э-Транс терминалаас: **5 цаг 28 минут**
  - 1.2. Цагааннуур боомтоос: **2 цаг 32 минут**
2. Гүний терминалаас ачигдсан экспортын барааны хилийн боомт дээрх дундаж хугацаа: **6 цаг 4 минут**
3. Захиалга дуудлагаар гүнд гаалийн бүрдүүлэлт хийж авто замаар бараа экспортлосон нийт дундаж хугацаа: **2 өдөр 18 цаг 51 минут**<sup>54</sup>
  - 3.1. Захиалга дуудлагын экспортын гүний хяналт, бүрдүүлэлтийн дундаж хугацаа: **2 өдөр 12 цаг 37 минут**

Судалгааны хугацаанд Монгол Транс гүний терминал дээр экспортын бүрдүүлэлт хийгдээгүй ба гүний гаалиас хилийн боомтод ирж улсын хилээр гаргасан экспортын мэдээлэл цуглараагүй болно. Түүнчлэн “захиалга дуудлага”-ын үйлчилгээнд хамрагдсан 16 экспортын барааны мэдээлэл бүртгэгдсэн ба судалгааны хугацаанд сонгогдсон хилийн боомтоор гараагүй байна.

Гүнийн гаалийн байгууллагад бүрдүүлэлт хийгдсэн экспортын барааг улсын хилээр гаргахад зарцуулагдсан нийт дундаж хугацааг багцаалж гаргах зорилгоор гүний гаалийн “захиалга дуудлага”-ын экспортын дундаж хугацааг гүний терминалаас хил дээр ирсэн экспортын ачаа барааны хилийн боомт дах дундаж хугацаатай нэгтгэх замаар тооцоолсон болно. Энэхүү механик аргачлалаар тооцоолсон хугацаанд гүн, хилийн боомт хоорондын тээвэрлэлтийн хугацаа ороогүй тул бодит нөхцөл байдлаас харьцангуй бага хугацаа гарсан нь ойлгомжтой юм.

Авто тээврээр бараа экспортлоход гүний гаальд бүрдүүлэлт хийгдэж, хилийн боомтоор гаргасан хугацаа хамгийн их байхад хилийн боомтоос шууд экспортлосон нийт дундаж хугацаа түүнээс 5 дахин бага байна.

Хүснэгт 11. Авто замаар гарах экспорт: Экспортын дундаж хугацаа, хилийн боомтоор

Хяналтын процедур	Цагааннуур		Замын-Үүд, Э-Транс		Замын-Үүд, АЗШНЦ 117		Захиалга дуудлага-Замын-Үүдээр гарах	
	Судалгааны тоо	Дундаж хугацаа	Судалгааны тоо	Дундаж хугацаа	Судалгааны тоо	Дундаж хугацаа	Судалгааны тоо	Дундаж хугацаа
Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа	0	0	45	0:20	0	0	0	0
ХМХ-ын үйл ажиллагаа	0	0	26	0:37	0	0	14	20:26
Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа	2	2:12	42	2:43	2	1:32	16	83:05

<sup>54</sup> Гүнээс хилийн боомт хүртэлх тээвэрлэлтийн цаг ороогүй.


### 2.1.1. Хилийн боомтоос авто замаар бараа экспортлох үйл ажиллагаа

Цагааннуур, Замын-Үүдийн (Э-Транс терминал) хилийн боомтоос барааг шууд экспортлоход дунджаар **5 цаг 20 минут**, Цагааннуур боомтоос 2 бараа экспортлоход 2 цаг 32 минут тус тус зарцуулагдсан байна<sup>55</sup>.

#### Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа:

Замын-Үүд хилийн боомтын Э-Транс терминалын хувьд тээврийн хэрэгсэлд ачигдсан экспортын барааг ГХБ-д оруулах, пүүлэх үйл явцуудад 20 минут зарцуулагдсан бол Цагааннуур боомт дах бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны мэдээлэл бүртгэгдээгүй болно.

Зураг 24. Авто замын экспорт: Хилийн боомт дах нийт дундаж хугацаа, хилийн боомтоор




Тайлбар: ГБӨ- гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа; ХМХ-Хилийн мэргэжлийн хяналт

#### Хилийн мэргэжлийн хяналт:

Цагааннуур боомтоор экспортод гарсан 2 бараа бүтээгдэхүүн (бэлэн хувцас, мал, малын гаралтай түүхий эд), Замын-Үүдийн Э-Транс ГХБ-ээс экспортод гарсан 47 барааны 36% нь ХМХ-нд хамрагдахгүй бараа бүтээгдэхүүн гэж бөглөгдсөн байна (Зураг 25).

Зураг 25. Авто замын экспорт-Замын-Үүд: ХМХ-нд хамрагдсан ачаа барааны эзлэх хувь



<sup>55</sup> Алтанбулаг хилийн боомтоор экспортын бараа гараагүй буюу мэдээлэл цуглараагүй.

ХМХ-нд хамрагдсан малын дайвар бүтээгдэхүүн, боловсруулсан арьс шир болон бусад барааны бичиг баримтын шалгалтад дунджаар 5 минут, биет үзлэгт 19 минут, Хяналтанд хамрагдсан хуудас олгоход 4 минут тус тус шаардагдсан ба үйл явц хоорондын хүлээлгийн хугацаа харьцангуй бага буюу дунджаар 6 минут болсон байна (Зураг 26). ХМХ-аар бичиг баримтын шаардлага хангагдаагүй, зөрчил илэрсэн тохиолдол гараагүй бөгөөд лабораторийн шинжилгээнд хамрагдсан талаарх мэдээлэл бүртгэгдээгүй болно.


Зураг 26. Авто замын экспорт: Хилийн мэргэжлийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, үйл ажиллагаа, хилийн боомтоор



Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:


Хилийн боомтоос 46 бараа шууд экспортлоход гаалийн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд дунджаар 2 цаг 39 минут зарцуулагдсан ба Замын-Үүдийн Авто замын шалган нэвтрүүлэх цэг (АЗШНЦ) дээр хамгийн бага хугацаа буюу 1 цаг 32 минут шаардагдсан байна (Зураг 27).

Зураг 27. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, хилийн боомтоор




Экспортын ачаа барааны гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хугацаа хилийн боомт бүрт ялгаатай байв. Тухайлбал, мэдүүлэгч гаалийн мэдүүлэг бичихэд Цагаануурт 31 минут, Замын-Үүдийн Э-Транс ГХБ-д 10 минутыг тус тус зарцуулсан. Ачааны манифестийг Замын-Үүдийн Э-Транс ГХБ-д бичиж шалгахад дунджаар 5 минут оржээ (Зураг 28).

Зураг 28. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн дундаж хугацаа, үйл ажиллагаа бүрээр, хилийн боомтоор




Түүнчлэн экспортын барааны нэр төрлөөс хамаарч гаалийн шалгалтын хугацаа хилийн боомтуудад ялгаатай байгаа ба боловсруулсан арьс, шир бүхий 2 экспортын барааг шалгахад хамгийн их хугацаа буюу дунджаар 15 цаг 16 минут шаардагдсан байна (Зураг 29).

Зураг 29. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналт шалгалтын дундаж хугацаа, хилийн боомт, бүтээгдэхүүний төрлөөр




Хяналтын эрсдэлийн төлөвөөр гаалийн хяналтыг хэрэгжүүлсэн хугацаа ялгаатай байгаа ба Цагаануурт улбар шар төлөвт улаан төлөвөөс урт хугацаанд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийгдсэн байна (Зураг 30).

Зураг 30. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилт, хилийн боомтоор



Гаалийн бичиг баримтын шалгалтаар Цагааннуурт 2 гаалийн мэдүүлгийн 1 нь алдаатай байсан ба түүнийг засварлуулан баталгаажуулахад 3 минут шаардагдсан байна. Биет шалгалтаар зөрчил илэрсэн, манифест алдаатай бичигдсэн тохиолдол гараагүй бөгөөд гаалийн лабораторийн шинжилгээнд хамрагдсан талаарх мэдээлэл цуглаагүй болно. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн ажиллагааны үйл явц бүрт хүлээлгийн хугацаа ямар нэгэн байдлаар гардаг байна (Зураг 31).


Зураг 31. Авто замын экспорт-Хилийн боомт: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл явц хоорондын хүлээлгийн дундаж хугацаа, хилийн боомтоор




## 2.1.2. Гүний терминалаас ирсэн экспортын барааг хилийн боомтоор гаргах үйл ажиллагаа

Судалгааны хугацаанд Монгол Транс гүний терминал дээр бүрдүүлэлт хийсэн экспортын бараа бүртгэгдээгүй тул гүнээс хилийн боомтыг бүхэлд нь хамарсан авто замын экспортын тээвэрлэлтийн нийт дундаж хугацаа гарах боломжгүй болсон. Харин судалгаанд сонгогдоогүй бусад гүний терминалаас Замын-Үүд хилийн боомтод авто замаар тээвэрлэгдэн ирсэн 14 экспортын барааны хилийн боомт дах хяналтын үйл ажиллагааг шинжлэн холбогдох хугацааг тооцож гаргалаа.

Зураг 32. Авто замын экспорт-Гүний терминалаас ирсэн ачаа бараа: Замын-Үүд хилийн боомт дах дундаж хугацаа



Зураг 33. Авто замын экспорт-Гүний терминалаас Замын-Үүд хилийн боомт дээр ирж экспортлох дундаж хугацаа, үйл ажиллагаа тус бүрээр





Судалгааны хугацаанд гүнээс ирж Цагаануур болон Алтанбулаг боомтоор гарсан экспортын бараа бүртгэгдээгүй болно. Гүний бүрдүүлэлт хийгдсэн нийт 14 илгээлтийн барааг гаалийн хяналтын дор Замын-Үүд хилийн боомтод АЗШНЦ-103, Э-Транс ГХБ-үүдэд хилээр гаргасан байна. Хилийн боомтод бараа экспортлох нийт үйл ажиллагаа дунджаар **6 цаг 4 минут** үргэлжилсэн байна (Зураг 32).


Гүний гаальд бүрдүүлэлт хийгдэж, хилээр гаргасан экспортын бараанд зарцуулагдсан нийт дундаж хугацааг үйл явц тус бүрээр авч үзвэл, хил хамгаалах байгууллагын бүртгэлийн үйл явцад 2 минут, рентгенээр ороход 53 минут, ХМХ шалгаж дуусахад 7 цаг 9 минут, манифестийг баталгаажуулахад 8 минут, мэдүүлгийг баталгаажуулахад 9 минут, хилээр гаргахад 13 минутын хугацаанд үргэлжилсэн байна (Зураг 33).

### 2.1.3. Авто тээврээр гаргах “захиалга дуудлага”-ын экспорт: Гүний терминал дах бүрдүүлэлтийн үйл ажиллагаа

Авто тээврээр гарах захиалга дуудлагын 16 экспортын илгээлтийн барааны бүрдүүлэлт гүний болон түр ГХБ-д хийгдсэн бөгөөд үүнд хамаарах мэдээллүүд цугларсан хэдий ч эдгээр илгээлтийн бараа судалгааны хугацаанд сонгогдсон хилийн боомтоор гараагүй болно.

Гүний терминалд нийт 11 илгээлт бүхий ноос ноолуур, 2 илгээлт бүхий малын дайвар бүтээгдэхүүн, 1 илгээлт бүхий боловсруулсан арьс ширний экспортын бүрдүүлэлт хийхэд дунджаар **2 өдөр 12 цаг 37 минут** шаардагдсан ба үүнээс мэргэжлийн хяналтын шалгалтад дунджаар 20 цаг 26 минут, гаалийн хяналт бүрдүүлэлтэд дунджаар 3 өдөр 11 цаг 5 минут тус тус зарцуулагджээ (Зураг 34).

Зураг 34. Захиалга дуудлага-Авто замаар гарах экспорт: Нийт хяналт шалгалтын дундаж хугацаа



Тайлбар: 83:05- 3 өдөр, 11 цаг 5 минут; 60:37 – 2 өдөр, 12 цаг, 37 минут


#### Мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:

Экспортын бүрдүүлэлт хийгдсэн нийт барааны 87.5% нь мэргэжлийн хяналтад хамрагдсан байна. Мэргэжлийн хяналтын бичиг баримтын шалгалтаар 1 илгээлтийн барааны бичиг баримт шаардлага хангаагүй бөгөөд үүний шалгалтанд 5 мин, шаардлага


хангасан бичиг баримтыг экспортлогч хүлээлгэн өгөхөд 1 мин, улсын байцаагч хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэхэд 1 мин тус тус зарцуулжээ.

Мэргэжлийн хяналтын бичиг баримтын шалгалтын үргэлжилсэн хугацаа нь биет үзлэгээс 14 цаг 23 минутаар их байв (Зураг 35).

Зураг 35. Захиалга дуудлага-Авто замын экспорт: Мэргэжлийн хяналтын биет болон бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа



Зураг 36. Захиалга дуудлага- Авто замын экспорт: Хамтарсан болон дангаар хийсэн биет үзлэгийн дундаж хугацаа



Авто замаар гаргасан 12 экспортын бараанд гаалийн байгууллагатай хамтарсан биет шалгалт хийсэн бөгөөд энэ нь дангаар хийсэн биет үзлэгээс 28 минутаар бага байсан бөгөөд биет үзлэгээр зөрчил илрээгүй байна (Зураг 36).

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч бичиг баримтыг хүлээн авч, хяналт шалгалтад хамрагдах эсэхийг тогтоон экспортлогч аж ахуйн нэгжийн байр, агуулахад үзлэг хийхээр очиход дунджаар 2 цаг 20 минут болсон байна (Зураг 37).

Зураг 37. Захиалга дуудлага-Авто замын экспорт: МХ-ын үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн дундаж хугацаа




Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:

Гаалийн хяналтын улбар шар, ногоон төлөвтэй бараанд хийсэн гаалийн хяналт, бүрдүүлэлт, шалгалтын хугацаа улаан төлөвийнхтэй харьцуулахад 3 (ногоон төлөв)-аас 34 (улбар шар) цагаар илүү хугацаанд үргэлжилсэн байна (Зураг 38).

Санамсаргүй сонголтоор сонгогдсон экспортын бараанд эрсдэлийн 3 төлөвийн хооронд гаалийн хяналт, шалгалтын ялгаа байхгүй, бүх төлөвт бичиг баримтын болон биет шалгалтууд хийгдсэн, улаан төлөвтэй бараанд хамгийн богино хугацаанд гаалийн шалгалт хийгдсэн бөгөөд бүх бараа гаалийн лабораторийн шинжилгээнд хамрагдсан байна.


Зураг 38. Захиалга дуудлага- Авто замын экспорт: Гаалийн шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр



Тайлбар: 79:47 - 3 өдөр, 7 цаг, 47 минут; 110:18- 4 өдөр, 14 цаг, 18 минут; 76:34 - 3 өдөр, 4 цаг, 34 минут

Горимын дагуу шаардагдах бичиг баримтын шалгалт улаан төлөвт улбар шараас 12 цаг 2 минутаар их байна (Зураг 39) .


Зураг 39. Захиалга дуудлага – Авто замын экспорт: Гаалийн бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр



Гаалийн бичиг баримтын шалгалт дунджаар 9 цаг 16 минут үргэлжилсэн бөгөөд улаан төлөв бүхий барааны бичиг баримтын шалгалт ногоон, улбар шар төлвийнхөөс харьцангуй удаан хугацаанд хийгдсэн байна. Экспортын ноос, ноолуурын барааны гаалийн 1 мэдүүлэг алдаатай байснаас шалгалт 6 өдөр 2 цаг 10 мин үргэлжилсэн байна. Үүнээс ГБМ мэдүүлгийг засварлан CAIS сүлжээгээр илгээхэд 6 өдөр 1 цаг 57 минут болжээ.

Экспортлогчийн байранд очиж дээж авахад дунджаар 1 цаг, гаалийн төв лабораторид дээжийг хүргүүлж, шинжлүүлэхэд дунджаар 1 өдөр 5 цаг 48 минут шаардагдсан байна. Экспортын барааны нэр төрлөөс хамаарч лабораторийн шинжилгээний хугацаа ялгаатай байгаа ба экспортод гаргасан ноос, ноолуурт хийгдсэн шинжилгээний хугацаа хамгийн их гарсан байна (Зураг 40).

Зураг 40. Захиалга дуудлага- Авто замын экспорт: Гаалийн лабораторит дээж өгч хариу авахад зарцуулагдсан дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр



Тайлбар: 29:48 – 1 өдөр, 5 цаг, 48 минут; 36:39 – 1 өдөр, 12 цаг, 39 минут; 34:10- 1 өдөр, 10 цаг, 10 мин

Лабораторийн шинжилгээгээр гаалийн 1 мэдүүлгийг буруу мэдүүлсэн зөрчил гарч, дахин шалгалтанд 2 цаг, гаалийн мэдүүлгийг ГБМ-д буцааж алдааг засварлуулахад 40 мин, бичиг баримтын гаалийн улсын байцаагч (ББГУБ) зассан мэдүүлгийг шалгахад 1 цаг 20 мин тус тус зарцуулсан.


Нийт 16 илгээлтийн ноос ноолуур, малын дайвар бүтээгдэхүүн, боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийхэд дунджаар 3 өдөр 11 цаг 5 минут (83 цаг 5 мин) зарцуулагдсан байна (Зураг 34). Нийт бүрдүүлэлтийн 6.5% нь ногоон, 18.5% нь улбар шар, 75% нь улаан төлөвт (Зураг 38) сонгогдсоноос ногоон төлөвт улаан төлвөөс их буюу 3 өдөр 3 цаг 37 минут (75:37), улбар шард хамгийн их буюу 4 өдөр 10 цаг 23 минут (106:23), улаан төлөвт хамгийн бага буюу 2 өдөр 22 цаг 23 минутын хугацаанд гаалийн шалгалт хийсэн байна. Түүнчлэн барааг гаалийн хяналтын түр бүсээс гаргахад дээрхтэй адил улаан төлөвт хамгийн богино хугацаанд хийгдсэн байна (Зураг 41).

Зураг 41. Захиалга дуудлага-Авто замын экспорт: Барааг гүнд ГХБ-ээс гаргасан дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр



Тайлбар: 75:37 – 3 өдөр, 3 цаг, 37 минут; 106:23 – 4 өдөр, 10 цаг, 23 минут; 70:23 – 2 өдөр, 22 цаг, 23 минут

Зураг 42. Захиалга дуудлага-Авто замын экспорт: Гаалийн биет шалгалт, ачилтанд хяналт тавьсан дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрөл, эрсдэлийн төлөвөөр



Түүнчлэн боловсруулсан арьс ширэн бүтээгдэхүүнд хийсэн биет шалгалт болон ачилтад хяналт тавьсан хугацаа хамгийн их буюу 2 цаг 15 минут байгаа нь бичиг баримтын шалгалтаас 3 дахин богино хугацаа болж байна. Ногоон төлөвт сонгогдсон бараанд

хийсэн биет шалгалт, ачилтад хяналт тавьсан хугацаа нь улбар шар төлөвийнхөөс 3.1 дахин их байв (Зураг 42).

Дээрх мэдээллүүдээс харахад гүний гаальд бүрдүүлэлт хийгдэж хилийн боомтоор экспортлосон барааны гаалийн лабораторийн шинжилгээнд зарцуулагдсан хугацаа, давтамж нь хилийн боомтоос шууд импортлосноос даруй 27 цагаар буюу 13.7 дахин их байна. Мэдүүлсэн барааны мэдээлэл нь ГТЛ-ын шинжилгээний дүгнэлтээс зөрдөг тохиолдол маш цөөн, судалгааны явцад ийм тохиолдол нийтдээ 4 удаа гарчээ.

Захиалга дуудлагаар гүнд гаалийн бүрдүүлэлт хийгдэж, хилийн боомтоор гаргах экспортын барааны гүний гаалийн терминалд зарцуулагдсан хугацаа нь бусад бүрдүүлэлтээс нэлээд урт хугацаанд үргэлжилдэг байна.

## 2.2. АВТО ТЭЭВРЭЭР ОРУУЛАХ ИМПОРТ

ЦХС-ны мэдээллийн дийлэнх нь авто тээврийн асуулгуудаар цугларсан. Тээврийн хэрэгслийн энэхүү төрлөөр бараа экспортлох, импортлох үйл ажиллагаа Замын-Үүд, Баян-Өлгий, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газруудын салбар, терминалуудад болон Улаанбаатар хотын гаалийн газрын Монгол Трансын ГХБ-д явагдаж 2 төрлийн судалгааны асуулгаар мэдээлэл цуглуулсан. Импортын ачаа бараанд төмөрлөг бүтээгдэхүүн, хүнсний бараа, машин техник тоног төхөөрөмж, сэлбэг болон бусад бараа голлосон.

Авто замаар орж ирсэн нийт 1012 импортын ачаа барааны мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн ба импортын үйл ажиллагаанд зарцуулагдсан дундаж хугацаа дараах байдлаар гарав. Үүнд:

1. Хилийн боомт дээр олгогдох импортын барааны дундаж хугацаа (Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур): **16 цаг 52 минут**
2. Хилийн боомт болон гүний терминалыг бүхэлд нь хамарсан дундаж хугацаа (Замын-Үүд ба Монгол Транс; Алтанбулаг ба Монгол Транс)- бараа Монгол Транс гүний терминал дээр олгогдох: **3 өдөр 12 цаг 7 минут**
3. Авто замаар орж гүний терминал руу ачигдах ачаа барааны хилийн боомт дээрх дундаж хугацаа: **10 цаг 7 минут**
4. Монгол Транс гүний терминал дээрх хяналтын дундаж хугацаа: **1 өдөр 18 цаг 58 минут**

### 2.2.1. Авто тээврээр оруулсан импортын бараа хилийн боомт дээр олгогдох үйл ажиллагаа

Авто тээврээр орж ирсэн импортын бараа хилийн боомтод олгогдох үйл ажиллагааг дараах 3 үндсэн бүрэлдэхүүн хэсэгт хуваан дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд:

1. Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа: 1 цаг 24 минут
2. Хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа: 2 цаг 39 минут
3. Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дундаж хугацаа: 3 цаг 23 минут

Хүснэгт 12. Авто тээврээр орж ирсэн импортын бараа хил дээр олгогдох үйл ажиллагааны дундаж хугацааны задаргаа, хилийн боомт, терминалаар


Хяналтын үйл ажиллагаа	Алтанбулаг	Цагааннуур	Замын-Үүд				
			ЧШРТТ	АЗШНЦ	Э-Транс	Дардан	109
Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа	0:42	3:18	1:16	0:56	14:42	0:12	1:57
ХМХ-ын үйл ажиллагаа	1:39	1:51	3:13	0:58	0:58	0:36	0
Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа	6:22	3:02	6:15	8:23	9:46	5:50	0

Авто тээврээр импортоор орж ирсэн барааг хилийн боомтод олгоход **дунджаар 16 цаг 52 минут** шаардагдсан байна. Авто импортын дийлэнх буюу 86% нь Замын-Үүд боомтоор (47.8% нь Чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмж терминалаар) орж эзэндээ олгогджээ (Зураг 43).

Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа:


Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаанд тээврийн хэрэгсэл хилийн боомт дээр хүрэлцэн ирж, бичиг баримтыг гаалийн хяналтад авах, тээврийн хэрэгсэлд халдваргүйтэл хийх, рентгенээр шалгах зэрэг үйл ажиллагаанууд хамаарах ба эдгээрт дунджаар 1.5 цаг зарцуулсан байна<sup>56</sup>.

Зураг 43. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Хилийн боомт дээрх хяналтын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар




<sup>56</sup> Цагааннуурт рентген аппарат байхгүй бөгөөд Замын-Үүд хилийн боомтын халдаргүйтэл хилийн бүсийн гадна байдаг тул мэдээлэл цуглараагүй.

Зураг 44. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Тээврийн хэрэгслийг хяналтанд авах, халдваргүйтэл хийх дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Хилийн цэрэг тээврийн хэрэгслийг дунджаар 1 минутанд бүртгэсэн ба тээврийн хэрэгсэлд халдваргүйтэл хийлгэж, холбогдох төлбөрийг төлөхөд дунджаар 6 минут зарцуулагдсан. Хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч (ХШГУБ) бичиг баримтыг гаалийн хяналтад авч баталгаажуулахад Алтанбулаг боомтод хамгийн их хугацаа буюу 41 минут болжээ (Зураг 45).

Зураг 45. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХШГУБ бичиг баримтыг гаалийн хяналтанд авч баталгаажуулсан дундаж хугацаа



Нийт 500 импортын бараа бүхий тээврийн хэрэгслийг рентгенээр шалгахад дунджаар 2 минут, үүнээс Алтанбулаг боомтод 57 барааг шалгахад 3 минут, Замын-Үүдийн Чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмж (ЧШРТТ) терминалд 443 тээврийн хэрэгслийг шалгахад дунджаар 2 минут, хамгийн ихдээ 2 цаг 2 минутыг тус тус зарцуулсан байна.



Хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:


Хил дээр олгогдсон нийт 545 импортын барааны 226 нь хилийн мэргэжлийн хяналтаар орсон бөгөөд дунджаар 2 цаг 39 минутын хугацаанд хяналтанд хамрагдсан байна (Хүснэгт 13). Хяналтанд хамрагдсан барааны 3.5% нь бага, 31.4% нь дунд, 65% нь их эрсдэлтэй гэж тодорхойлогдсон.

Хүснэгт 13. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар

Алтанбулаг	Цагааннуур	Замын-Үүд			
		ЧШРТТ	103	Э-Транс	Дардан
1:39	1:51	3:13	0:58	0:58	0:36


Хяналтад хамрагдахгүй барааны нэр төрөл адил байгаа боловч хилийн боомт, терминал тус бүрт харилцан адилгүй байна. Хяналтанд хамрагдахгүй ачаа барааны бичиг баримтыг дунджаар 7 минутын хугацаанд импортлогчид буцаан олгожээ.

Зураг 46. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдахгүй бараа, нийт импортын ачаа бараанд эзлэх хувиар




Хилийн мэргэжлийн хяналтаар орсон барааны бичиг баримтыг дунджаар 9 минутад буюу хамгийн багадаа 1 минут, хамгийн ихдээ 4 цаг 19 минут шалгажээ (Зураг 47).

Зураг 47. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар




Бичиг баримт дутуу, шаардлага хангаагүй 2 тохиолдол (Алтанбулаг, Замын-Үүдийн ЧШРТТ) бүртгэгдсэн ба бичиг баримтыг дахин нягтлан шалгахад дунджаар 1 цаг 30 минут зарцуулагдсан. Бичиг баримтын шалгалтаар 3 зөрчил илрүүлсэн ба дунджаар 1 цаг 12 минутын хугацаанд шийдвэрлэсэн байна.

Зураг 48. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Их, дунд эрсдэлтэй ачаа барааг биет үзлэгт бэлтгэх дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар




Биет шалгалт хийхэд бэлтгэх, шалгалт хийх хүртэлх хүлээлгийн дундаж хугацаа хилийн боомт, терминалуудад ойролцоо байгаа боловч Цагааннуур боомтод хүлээлгийн хугацаа хамгийн их гарчээ (Зураг 48). Судалгааны үеэр мэргэжлийн хяналтын мэргэшсэн улсын байцаагч нарын хүрэлцээ хангалтгүй тул ачаалал ихтэй үед хүлээлт үүсдэг байдал ажиглагдсан байна. Хил дээр олгогдох нийт 217 импортын бараанд ХМХ-ын байцаагч биет үзлэг хийсэн ба биет үзлэгийн дундаж хугацаа барааны нэр төрлийн тоо хэмжээнээс хамааран хилийн боомт, хяналтын бүс тус бүрт харилцан адилгүй байна. Харин дийлэнх хилийн боомтод хүнсний бэлэн бүтээгдэхүүний үзлэг шалгалтанд зарцуулагдаж буй хугацаа нь хими, эм, эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний үзлэгийн хугацаанаас 2-18 дахин их байна. Түүнчлэн 50-100 болон түүнээс дээш тооны нэр төрлийн ачаа бараанд хийгдсэн үзлэг шалгалтын дундаж хугацаа тэдгээрээс 2 дахин бага нэр төрлийн ачаа бараанд хийсэн шалгалтын хугацаанаас 4 дахин бага цаг зарцуулагдсан байна.

Зураг 49. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор




Хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч дунджаар 1 цаг 38 минутанд биет үзлэг хийсэн бөгөөд барааны төрлөөр авч үзвэл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг дунджаар 3 цаг 5 минут, машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэгийг 4 минутад тус тус шалгажээ (Зураг 50).

Зураг 50. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр



Цагааннуур боомтод ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа Алтанбулаг боомттой харьцуулахад бараг 2 дахин их байна. Импортод дийлэнх хувийг эзэлж буй хүнсний бэлэн бүтээгдэхүүнд хийсэн бие үзлэгийн хугацаа нь Цагааннуур боомтын хувьд Алтанбулаг хилийн боомтоос 3 цаг 4 минутаар их байв.


Зураг 51. Авто замын импорт-Алтанбулаг, Цагааннуур боомт дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр




Замын-Үүд боомтын ЧШРТТ терминалд ХМХ-ын биет үзлэгийн дийлэнх хийгдсэн бөгөөд дунджаар 2 цаг 14 минут зарцуулагдсан бол Замын-Үүдийн бусад терминалуудад

энэхүү хугацаа 5-12 минут байжээ. Импортын бараанд ихэнх хувийг эзэлж буй хүнсний бэлэн бүтээгдэхүүнд хийсэн биет үзлэгийн хугацаа нь ЧШРТТ терминалын хувьд Цагааннуур боомтынхтой ойролцоо буюу 3 цаг 32 минут байв (Зураг 52, Зураг 53).

Зураг 52. Авто замаарх импорт- ЗҮ ЧШРТТ дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр




Зураг 53. Авто замаарх импорт- Замын-Үүдийн ГХБ дээр олгогдох: ХМХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, барааны төрлөөр, ГХБ-ээр



Мал, ургамал хорио цээрийн бараа бүтээгдэхүүнд Алтанбулаг боомтод 4, Замын-Үүдийн ЧШРТТ терминалд 1 удаа хамтарсан шалгалтыг тус тус хийсэн бөгөөд хамтарсан шалгалтын нийт дундаж хугацаа нь ХМХ-ын дангаар хийсэн биет үзлэгээс бага хугацаанд хийгдсэн байна. Хилийн боомтуудад ХМХ дангаараа 212 барааг шалгахад дунджаар 1 цаг 40 минутад хийгджээ (Зураг 54).


Зураг 54. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын Гаальтай хамтран хийсэн биет шалгалтын нийт дундаж цаг



ХМХ-нд хамрагдсан нийт барааны 4% нь бага, 31% нь дунд, 65% нь их эрсдэлтэй байснаас Замын-Үүдийн ЧШРТТ-ийн терминалд бага эрсдэлтэй гэсэн 7 бараа (химийн бодис-4, ургамал хорио цээр-3) хилийн мэргэжлийн хяналтаар орж, дунджаар 6 минутын хугацаанд бичиг баримтыг нягтлан хяналтанд хамрагдсан хуудас олгож биет үзлэгээс чөлөөлөгдсөн байна.

Хилийн боомтуудад бага эрсдэлтэй 7 бараанд хяналт хийсэн дундаж хугацаа 6 минут, дунд эрсдэлтэй малын гаралтай 69 бараанд мал эмнэлгийн хяналтыг 1 цаг 10 минут, ургамлын гаралтай 34 бараанд ургамлын хорио цээрийн хяналтыг дунджаар 1 цаг 19 минут, эрүүл ахуйн хяналтыг 17 бараанд дунджаар 1 цаг 16 минут, их эрсдэлтэй ургамлын гаралтай 81 бараанд ургамлын хорио цээрийн хяналтыг дунджаар 5 цагийн хугацаанд тус тус хийжээ.


Зураг 55. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, хилийн боомт, терминалаар,




Цагааннуур боомтоор орсон импортын барааны тоо хэмжээ бага хэдий ч дунд эрсдэлтэй ургамал хорио цээрийн хяналттай бараанд 3 цаг 22 минут, их эрсдэлтэй хүнсний бараанд

8 цаг 9 минутанд хяналт хийсэн нь хамгийн их хугацаа орсон үзүүлэлттэй байна (Зураг 57).


Зураг 56. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-нд зарцуулсан нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалуудаар



Зураг 57. Авто замын импорт -Хил дээр олгогдох: Дунд эрсдэлтэй ачаа барааны ХМХ-ын дундаж хугацаа, хяналтын төрлөөр





Зураг 58. Авто замын импорт - Хил дээр олгогдох: Их эрсдэлтэй ачаа барааны ХМХ-ын дундаж хугацаа, хяналтын төрлөөр



Хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдсан нийт барааны 40% буюу 92 бараа лабораторийн шинжилгээнд хамрагдсан ба дээж авч шинжилгээнд явуулахад дунджаар 10 минут, лабораторийн шинжилгээний хариу дунджаар 3 цаг 48 минутын хугацаанд гарсан байна. Замын-Үүдийн ЧШРТТ терминалд 81 бараанаас лабораторийн шинжилгээний дээжийг дунджаар 10 минутад авчээ (Зураг 59).


Лабораторийн шинжилгээнд зарцуулагдсан хугацааг бараа, бүтээгдэхүүний төрлөөр харьцуулан шинжлэхэд хилийн боомт тус бүрт харилцан адилгүй үзүүлэлттэй байна. Тухайлбал, Алтанбулаг, Цагааннуур хилийн боомтуудад хүнсний бэлэн бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээнд дунджаар 57 минутаас 1 цаг 30 минут шаардагдсан бол Замын-Үүдийн ЧШРТТ-ийн хяналтын бүсэд даруй 4 дахин их хугацаа зарцуулагдсан ба “Бусад” төрлийн барааны хувьд дээрх үзүүлэлт мөн адил хандлагатай байна.

Зураг 59. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын лабораторийн шинжилгээний дундаж хугацаа, барааны төрлөөр, хилийн боомтоор



Хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг ХМХ-ын лабораториор шинжилсэн нийт боомтын дундаж хугацаа 3 цаг 50 минут байгаа бол Замын-Үүдийн ЧШРТТ-ийн терминалд 4 цаг 13 минут, Алтанбулаг боомтод 57 минутад тус тус шинжилсэн нь харилцан адилгүй хугацаа зарцуулагдаж байгааг илтгэж байна.

Зураг 60. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХМХ-ын байцаагч бүтээгдэхүүнээс дээж авч лабораторийн шинжилгээнд явуулсан дундаж хугацаа, хяналтын төрлөөр




Нийт импортын барааны 40.7% нь лабораторийн шинжилгээнд хамрагдсан байгаа нь их эрсдэлтэй гэж тодорхойлсон импортын барааны 62.5%-тай тэнцэж байна. Цагааннуур боомтод лабораторийн шинжилгээний 1 хариу шаардлага хангаагүй, дахин шинжилгээнд явуулах, эсвэл хуулийн дагуу арга хэмжээ авахад дунджаар 16 цаг 16 минут шаардагджээ. ХМХ-ын хамралт, их эрсдэлтэй барааны тоо хэмжээ, лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ зэрэг үзүүлэлт нь ХМХ-тай холбоотой дүрэм журмын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:

Авто тээврээр ачигдан орж ирж хилийн боомтод эзэндээ олгогдсон импортын нийт 911 бараанд хилийн гаалийн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт, бүрдүүлэлтийн дундаж хугацаа 7 цаг 18 минут байгаа ба хамгийн урт хугацаанд үргэлжилсэн хяналт Замын-Үүдийн Э-Транс терминалд хийгджээ.


Зураг 61. Авто замын импорт: Хил дээр олгогдох ачаа барааны гаалийн хяналтын нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар





Нийт импортод үндсэн төмөрлөг бүтээгдэхүүн, хүнсний бэлэн бүтээгдэхүүн, бусад бараа голлох хувийг эзэлсэн ба барааны нэр төрлөөс хамаарч гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хугацаа 1 цагаас 14 цаг хүртэлх хугацаанд үргэлжилсэн байна.

Зураг 62. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Импортын бүтээгдэхүүний төрөл, хувиар




Зураг 63. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Гаалийн хяналтын нийт дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр



**Барааг гаальд мэдүүлэх:**

Ихэнх терминалуудад гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн (ГБМ) импортын барааг гаальд мэдүүлсэн байна. ГБМ бичиг баримтыг хүлээн авч, CEPS программд мэдээллийг оруулж, CAIS сүлжээгээр илгээхэд дунджаар 23 минутаас 5 цаг 37 минутын хугацаа шаардагдсан байна. Өндөр ачаалалтай Замын-Үүдийн зарим терминалуудад бараа экспортлогч, импортлогчдын гэрээ байгуулсан Гаалийн зуучлагчийн бүртгэгдсэн мэргэжилтэн байхгүйгээс дараалал хүлээх зэргээр гаальд мэдүүлэх үйл явц саатаж байв.

Зураг 64. Авто замын импорт- Хил дээр олгогдох: ГБМ мэдүүлэг бэлтгэх, алдаатай мэдүүлгийг хянан засварлуулах дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Гаалийн мэдүүлгийн алдаа, түүнийг шалгаж засварлах:

Нийт импортын гаалийн мэдүүлгийн 2.5% нь алдаатай, алдааг засварлахад дунджаар 4 цаг 48 минут зарцуулагдсан байна. Гаалийн мэдүүлгийг шалгаж, алдаатай мэдүүлгийг засварт буцаасан, алдааг зассан, засварыг хянасан хугацаа боомт, терминал бүрт ялгаатай байв. Нийт алдааны 52.2% нь Замын-Үүд дэх гаалийн газрын терминалуудад ногдож байгаа ба тус боомтын АЗШНЦ-103 терминалд гаалийн мэдүүлгийн алдааг засварлуулахад хамгийн их хугацаа орсон байна. ББГУБ гаалийн мэдүүлгийг мэдүүлэгчийн сонгосон горимын холбогдох журмын дагуу шалгаж, алдаатай мэдүүлгийг ГБМ-нд буцаахад дунджаар 4 цаг 13 минут, ГБМ алдааг засварлан илгээхэд 39 минут, ББГУБ засварыг хянахад 2 минут тус тус зарцуулагдсан.

Нийт бүрдүүлэлтийн 41.8% ногдож буй Замын-Үүдий ЧШРТТ терминалд алдаатай бичигдсэн гаалийн мэдүүлгийн 18.2% оногдож байгаагаас үзэхэд гаалийн мэдүүлгийн алдааны хэмжээ бүрдүүлэлтийн тоо хэмжээнээс тэр бүр хамаардаггүй байх талтай.


Хүснэгт 14. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Алдаатай гаалийн мэдүүлгийн тоо, мэдүүлгийг засварласан дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар

Гаалийн хяналтын процедур	Алтанбулаг	Цагааннуур	Замын -Үүд			
			ЧШРТТ	АЗШНЦ103	Э-Транс	Дардан
Гаалийн мэдүүлгийн алдааны тоо	7	4	4	1	3	4
ГБМ гаалийн мэдүүлгийг засварласан дундаж хугацаа	0:10	0:10	0:52	4:22	0:52	0:38


Гаалийн хяналтын эрсдэлийн төлөв: Импортын барааны 1.4% нь ногоон төлөв, 14.2% нь улбар шар төлөв, 84.4% нь эрсдэлийн улаан төлөвт тус тус сонгогдсон байна.

“Гаалийн хяналтын стратеги”<sup>57</sup>-д “бараа, тээврийн хэрэгсэлд хийх биет шалгалтын тоог бууруулж, улбар шар болон ногоон төлөвт сонгогдох бүрдүүлэлтийн тоог нэмэгдүүлнэ” гэж заасан байдаг ч улаан төлөв өндөр хэвээр байна (Зураг 65).

Зураг 65. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор, бүх хилийн боомт



Зураг 66. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын дундаж хугацаа, барааны төрлөөр, бүх хилийн боомт




<sup>57</sup> Гаалийн тухай хуулийн 233.2, 268.1.3 дахь заалтыг үндэслэн ГЕГ-ын даргын 2011 оны 87 дугаар тушаалаар батлагдсан журам. “Гаалийн хяналтын стратеги”-д “Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын зарчим нь үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах болон гадаад худалдааг хөнгөвчлөх үүргийг тэнцвэртэйгээр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Иймд эрсдэлийн удирдлагыг гаалийн хяналтын үндсэн философи гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Гаалийн хяналтын шинэ зарчмаар “оюунлаг” хэлбэрийг хэрэгжүүлснээр зөвхөн эрсдэлтэй байж болзошгүй бараа, тээврийн хэрэгслийг онилж шалгалтад хамруулна. Ингэснээр хууль ёсны гадаад худалдааг чөлөөтэй нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслийн эрсдэлийн удирдлагын системийн үндсэн дээр гаалийн шалгалтаас чөлөөлсөн бол гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулж, гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлснийг шалгана” гэж үндэслэл, шаардлагыг тогтоосон. Энэхүү журмыг ШНКК, ДГБ-ын Гадаад худалдааны аюулгүй байдлыг хангах Багц стандарт, ДГБ-ын “21 дүгээр зууны гааль” бодлогын баримт бичгийн хүрээнд Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг үндэслэн боловсруулсан.

Авто замаар оруулж тухайн хилийн боомтод эзэндээ олгогдсон эрсдэлийн улаан төлөвт сонгогдсон бараанд гаалийн биет шалгалт хийсэн хугацааг ачилт тус бүрт байгаа барааны тоо хэмжээ, нэр төрөлтэй харьцуулан шинжлэн үзэхэд авто замаарх хилийн боомт тус бүрт дээрх хугацааны хэлбэлзэл харилцан адилгүй байгаа нь ажиглагдлаа. Гэвч нийтэд нь авч үзвэл 51-100 нэр төрлийн бараатай ачилтад шалгалт хийсэн хугацаа нь түүнээс 2 дахин бага нэр төрлийн ачаа бараанд хийсэн шалгалтын хугацаанаас 34 хувиар бага байна (Зураг 65).

Мөн импортын барааны нэр төрлөөс хамаарч гаалийн шалгалтын хугацаа эрс ялгаатай байна. Авто тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийг дунджаар 23 минутад шалгасан бол хими, эм, эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дунджаар 4 цаг 12 минутын хугацаанд шалгажээ (Зураг 66).

Алтанбулаг болон Цагааннуур боомтод нийт бүрдүүлэлт хийсэн барааны тоо ойролцоо байгаа хэдий ч нийт дундаж хугацаа нь ялгаатай байгааг Зураг 67-оос харах боломжтой.

Зураг 67. Авто замын импорт-Алтанбулаг, Цагааннуур боомт дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын нийт дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор




Алтанбулаг боомтод улаан төлөвт сонгогдсон хими, эм, эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг хамгийн урт хугацаанд, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг хамгийн бага хугацаанд шалгасан байхад Цагааннуур боомтод машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэгийг хамгийн урт хугацаанд, амьд мал, ургамал тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг хамгийн бага хугацаанд тус тус шалгажээ (Зураг 68).


Замын-Үүд авто замын боомтын ЧШРТТ ГХБ-д улаан төлөвт сонгогдсон импортын барааг рентген төхөөрөмж ашиглан шалгасан боловч АЗШНЦ-103 ГХБ-д хийгдсэн биет шалгалтын хугацаанаас 0.4 цагаар их байна. Уг терминалд 1-20 нэр төрлийн бараа бүхий 235 ачилтыг шалгахад дунджаар 1 цаг 23 минут зарцуулсан ба энэ нь 100-аас дээш нэр төрөлтэй ачилтын барааг шалгасан хугацаанаас 2.6 дахин их байна. Ачилт дахь барааны нэр төрөл нэмэгдэхийн хэрээр гаалийн шалгалтын хугацаа буурсан урвуу хамааралтай

байна. АЗШНЦ-103 ГХБ нь рентгенгүй бөгөөд нэг ачилтад 1-20 нэр төрлийн барааны шалгалтыг дунджаар 41 минутад хийсэн бол 100-с дээш нэр төрөлтэй ачилтын барааг дунджаар 49 минутад шалгажээ. Э-Транс ГХБ-д улаан төлөвт сонгогдсон бараанд хийсэн гаалийн шалгалтын дундаж хугацаа хамгийн бага байв (Зураг 69).


Зураг 68. Авто замын импорт- Алтанбулаг, Цагаануур боомт дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын нийт дундаж хугацаа, барааны төрлөөр




Зураг 69. Авто замын импорт-Замын-Үүдийн ЧШРТТ, АЗШНЦ-103 дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын нийт дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор



Зураг 70. Авто замын импорт- ЗҮ-ЧШРТТ дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын нийт дундаж хугацаа, барааны төрлөөр




Зураг 71. Авто замын импорт- ЗҮ Дардан, Э-Транс, АЗШНЦ103 дээр олгогдох: Улаан төлөвийн биет шалгалтын нийт дундаж хугацаа, барааны төрлөөр



Замын-Үүд боомтын авто тээврийн терминалуудад гол төлөв машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг болон авто тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги зэрэг ижил нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний бүрдүүлэлт хийгдсэн бөгөөд тэдгээрт хийх шалгалтын хугацаа харилцан адилгүй буюу дунджаар 11-ээс 51 минутын хооронд хэлбэлзэж байна. Хүнсний бэлэн бүтээгдэхүүний бүрдүүлэлт гол төлөв ЧШРТТ-ийн ГХБ-д хийгдсэн бөгөөд биет шалгалтыг дунджаар 15 минутын хугацаанд хийсэн бол нэхмэлийн

материал, нэхмэл эдлэл болон хими, эм, эмийн бүтээгдэхүүнд хамгийн их буюу 3 цаг 48 минутын хугацаанд биет шалгалт хийсэн байна.

Зураг 72. Авто замаарх импорт-ЗҮ Дардан, Э-Транс дээр олгогдох: Улаан төлөвтэй барааны биет шалгалтын нийт дундаж хугацаа, мэдүүлсэн барааны нэр төрлийн тоогоор



Нийт импортын барааны 80%-ээс дээш улаан төлөвт сонгогдож байгаа бөгөөд улбар шар, ногоон төлөвт сонгогдсон бараанд хийгдэж байгаа хяналт, шалгалт, бүрдүүлэлт, татвар хураамж төлсөн хугацаа, эзэнд нь олгосон хугацааны ялгаа бага, зарим тохиолдолд (татвар төлсөн хугацаа нь ихэнхдээ хэд дахин урт) улаан төлөвөөс ч удаан хугацаанд байна. ЦХС-ны явцад бүртгэгдсэн нийт импортын бүрдүүлэлтэд илрүүлсэн зөрчил, алдааны эзлэх хэмжээ 5.3% байв (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Авто замаарх импорт-Хил дээр олгогдох: Татвар төлөлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, хилийн боомт, терминалаар


Эрсдэлийн төлөв	Алтан булаг	Цагаан нуур	Замын-Үүд				Дундаж хугацаа
			ЧШРТТ	103	Э-Транс	Дардан	
Ногоон, улбар шар төлөв	0:46	0:36	1:42	0:32	2:04	0:40	1:35
Улаан төлөв	0:05	0:04	0:04	0:02	0:04	0:03	0:04

ББГУБ бичиг баримт шалгахад зарцуулдаг хугацаа нь терминал, хяналтын улбар шар, улаан төлөвийн бараанд харилцан адилгүй байгаа ба улбар шар төлөвт 13 минут бол улаан төлөвт түүнээс 2.5 дахин их буюу 32 минутын хугацаанд горимын дагуу шаардагдах бичиг баримтыг шалгасан байна.

Мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын хүрээнд бичиг баримтын шалгалт хийхэд дунджаар 29 минут зарцуулсан бол биет шалгалт хийхэд 52 минут шаардагдсан байна. Гэхдээ энэхүү харьцаа нь терминал бүрт харилцан адилгүй байсан бөгөөд тухайлбал, Замын-Үүдийн АЗШНЦ-103 терминалд бичиг баримтын шалгалтыг 1 цаг 37 минутад хийсэн бол биет шалгалтыг түүнээс бага хугацаанд буюу 45 минутад хийж гүйцэтгэсэн байна (Зураг 73).


Хил дээр олгогдох нийт 765 барааны шалгалтаар 4 зөрчил илрүүлж (Замын-Үүдийн Дардан, ЧШРТТ), зөрчлийг хянан шийдвэрлэхэд дунджаар 1 өдөр 6 цаг 30 минут, ЧШРТТ терминалд 1 зөрчилд холбогдсон бараанд дахин шалгалт хийхэд 1 цаг 35 минутыг тус тус зарцуулжээ.

Зураг 73. Авто замын импорт- Хил дээр олгогдох: Гаалийн бичиг баримт болон биет шалгалтын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Гаалийн лабораторийн шинжилгээнд хамрагдсан байдал: Нийт импортын барааны 4.5%-ийг гаалийн лабораториор шинжилсэн ба үүнд дунджаар 2 цаг 15 минут, хамгийн ихдээ 13 цаг 20 минут шаардагдсан байна (Зураг 74). Лабораторийн шинжилгээнд шаардагдсан хугацаа харилцан адилгүй байгаагаас гадна цөөн тооны зөрчил илэрсэн байна. Тухайлбал, хилийн боомтод олгогдсон 911 бараанаас гаалийн лабораторийн шинжилгээний 42 дүгнэлтээр 4 зөрчил илэрсэн гэсэн мэдээлэл бүртгэгджээ. Алтанбулаг боомтод лабораторийн шинжилгээний мэдээлэл бүртгэгдээгүй болно.


Зураг 74. Авто замын импорт-Хил дээр олгогдох: Гаалийн лабораторийн шинжилгээний дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Эрдэс бүтээгдэхүүнээс дээж авч лабораториор шинжилж дүгнэлт гаргахад боомт бүрт харилцан адилгүй хугацаа зарцуулагджээ. Цагааннуур боомтод 16 бараанаас дээж авч лабораторид шинжлүүлэхэд дунджаар 16 минут шаардагдсан бол Замын-Үүдэд 24 бараанаас дээж авч шинжлүүлэхэд дунджаар 3 цаг 46 минут шаардагдсан байсан (Зураг 75).




Зураг 75. Авто замын импорт-Хил дээр олгогдох: ХШГУБ дээж авч лабораторийн дүгнэлт авсан дундаж хугацаа, барааны төрлөөр, хилийн боомтоор



Хил дээр эзэндээ олгогдсон нийт 771 барааны гаалийн мэдүүлэг дээр “гааль зөвшөөрөв” тэмдэглэгээ хийгдсэнээс хойш дунджаар 6 минутын хугацаанд ГХБ-ээс гарах зөвшөөрлийн хуудсыг авчээ.


Зураг 76. Авто замын импорт- Хил дээр олгогдох: ГХБ-ээс гарах зөвшөөрлийн хуудас олгосон нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



### 2.2.2. Авто тээврээр оруулсан ачаа барааг гүний терминал руу шилжүүлэх хилийн боомтын үйл ажиллагаа

Хилээс гүнд илгээх барааны хилийн боомтод хийгдсэн үйл ажиллагаа: Авто замын хилийн боомтоор орж ирсэн нийт 91 ачаа барааг гүний терминалд шилжүүлсэн ба үүний 85.7% нь Замын-Үүд, 14.3% нь Алтанбулаг хилийн боомтуудад дунджаар **10 цаг 7 минутын** хугацаанд хийгджээ (Зураг 77). Судалгааны хугацаанд Цагааннуур боомт болон Замын-Үүдийн Э-Транс терминалаар гүнд шилжүүлэгдсэн ачаа бараа бүртгэгдээгүй болно.


Зураг 77. Авто замын импорт- Гүн рүү шилжүүлэгдэх: Гүний гааль дээр олгогдох ачаа барааны хилийн боомт дах нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Хилийн мэргэжлийн хяналт:

Гүнийн гааль руу шилжүүлэгдсэн нийт ачаа барааны 15.4% нь хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдсан бол хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдахгүй гэж тодорхойлогдсон нь нийт барааны 41.8%-ийг эзэлж байна. Гүн рүү шилжүүлэгдэх ачаа бараанд хилийн мэргэжлийн хяналтын зүгээс зөвхөн бичиг баримтын шалгалт хийдэг ба үүнд хамгийн ихдээ 30 минут, багадаа 4 минут, дунджаар 20 минут зарцуулагдсан байна (Зураг 78). Бичиг баримтын шалгалтаар бичиг баримт дутуу, шаардлага хангаагүй тохиолдол судалгаанд бүртгэгдээгүй байна.


Зураг 78. Авто замын импорт - Гүн рүү шилжүүлэгдэх: Гүний гааль дээр олгогдох ачаа барааны хилийн боомт дээрх ХМХ-ын дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Гаалийн хяналт, шалгалт:

Мэдүүлэгч гүний гаальд шилжүүлэгдэх 72 барааны манифестийг үүсгэхэд дунджаар 43 минут, гаалийн улсын байцаагч (ГУБ) 61 манифестийг тулган шалгахад дунджаар 3 минут тус тус зарцуулсан байна.

Зураг 79. Авто замын импорт - Гүн рүү шилжүүлэгдэх: Гүний гааль дээр олгогдох ачаа барааны хилийн боомт дах гаалийн хяналтын дундаж хугацаа




34 тээврийн хэрэгслийг лацдан төлбөрийг тушаахад дунджаар 20 минут, ГХБ-ээс гарах 59 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгоход дунджаар 9 минут тус тус зарцуулагдсан байна.

### 2.2.3. Гүний терминал дээр барааг эзэнд нь олгох үйл ажиллагаа

Судалгааны хугацаанд Монгол Транс гүний терминал дээр Замын-Үүд хилийн боомтоос 73 тээврийн хэрэгсэл бүхий ачаа бараа ирж эзэндээ олгогдсон байна. Зарим тээвэрлэгч бичиг баримтын бүрдүүлэлтийг Улаанбаатар хотын гаалийн газар (УБГГ) дээр хийсэн тул гаалийн мэдүүлгийн хяналтын процедурт УБГГ-ын бичиг баримт бүрдүүлэлтийн алба, Монгол Транс гүний терминалыг хамруулан холбогдох цаг хугацааг тооцоолсон болно.

Зураг 80. Авто замын импорт-Монгол Транс: Гүний терминалын нийт дундаж хугацаа, хяналтын процедураар



Тайлбар: 32:23 - 1 өдөр, 8 цаг, 23 минут; 42:58 - 1 өдөр, 18 цаг, 58 минут


Автомашинаар тээвэрлэн улсын хилээр оруулсан бараа гүний гаалийн Монгол Транс терминалд гаалийн бүрдүүлэлт хийгдэж эзэндээ олгогдоход дунджаар 1 өдөр 18 цаг 58

**минут** шаардагдсан бөгөөд хяналтын цаг хугацааг үндсэн 3 бүрэлдэхүүн хэсгээр задлан авч үзсэнийг Зураг 80-д харууллаа. Монгол Транс гүний терминалд гаалийн хяналтын үйл ажиллагаанд дунджаар 1 өдөр 8 цаг 23 минут, мэргэжлийн хяналтад 1 цаг 47 минутын хугацаа зарцуулагдсан байна.

Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа:

Хилийн боомтоор орж ирсэн импортын бараа авто тээврээр тээвэрлэгдэн Монгол Транс гүний терминалд ирэхэд тээврийн хэрэгслийг бүртгэх, пүүлэх, гаалийн хяналтанд авах зэрэг үйл ажиллагаанд дунджаар 6 цаг 51 минут зарцуулагдсан байна (Зураг 81).


Зураг 81. Авто замын импорт-Гүний терминал: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа, үйл явц тус бүрээр



Мэргэжлийн хяналт:

Монгол Транс ГХБ-д хилээс ирсэн 73 ачаа бараанаас 4 нь мэргэжлийн хяналтад хамрагдсан бөгөөд үүнд дунджаар 1 цаг 47 минут шаардагдсан. Их эрсдэлтэй 3 бараанд мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн шалгалтыг 1 цаг 35 минут, дунд эрсдэлтэй 1 бараанд 2 цаг 25 минутад хяналт хийгджээ (Зураг 82).

Зураг 82. Авто замын импорт-Гүний терминал: МХ-ын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, хяналтын процедур тус бүрээр




Тайлбар: Б/б-бичиг баримт; XXX-Хяналтанд хамрагдсан хуудас

Судалгааны үеэр цугларсан мэдээллээс харахад Монгол Транс терминал дээр ирсэн импортын бараа мэргэжлийн хяналтанд бүрэн хамрагддаггүй болох нь харагдаж байна.

Гүний гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:


Гүний гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн тээвэрлэгчээс илгээлтийн бичиг баримтыг хүлээн авсан үеэс ачаа бараа ГХБ-ээс гарах хүртэлх үйл ажиллагааг авч үзсэн бөгөөд үүнд дунджаар 1 өдөр 8 цаг 23 минут шаардагджээ. Монгол Транс терминалд ирсэн нийт 73 барааны 5.5% нь ногоон, 32.8% нь улбар шар, 61.6% нь улаан төлөвт сонгогдсон бөгөөд ногоон болон улбар шар төлөв бүхий ачаа барааны гаалийн бүрдүүлэлтийн хугацаа ойролцоо буюу 1.1 өдөр байна (Зураг 83).

Зураг 83. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр




Тайлбар: 26:39- 1 өдөр, 2 цаг, 39 минут; 26:52- 1 өдөр, 2 цаг, 52 минут; 35:50- 1 өдөр, 11 цаг, 50 минут; 32:23- 1 өдөр, 8 цаг, 23 минут

Зураг 84. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, үйл ажиллагаагаар




Гаалийн бүрдүүлэлтэд хамаарах нийт үйл ажиллагаанаас бичиг баримтын хяналт, шалгалтанд дийлэнх хугацаа ордог байна. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн бичиг баримт хүлээн авсан үеэс ачаа бараа, тээврийн хэрэгслийн мэдээллийг бэлтгэн CEPS программд оруулж эхлэх хүртэл дунджаар 8 цаг 40 минут (УБГГ дээр 6 цаг 58 минут)-ын хугацаа орсон бөгөөд нийт 72 импортын барааг гаальд мэдүүлэхэд дунджаар 2 цаг 57 минут шаардагдсан байна. Монгол Транс ГХБ-д ирж буусан 5 ачаа барааг УБГГ-ын бичиг баримт бүрдүүлэлтийн албанд мэдүүлэхэд дунджаар 26 минут зарцуулсан бол Монгол Транс гүний терминал дээр мэдүүлэхэд 3 цаг 8 минут шаардагдсан байна (Зураг 85).

Зураг 85. Авто замын импорт-Гүний терминал: ГБМ мэдүүлгийн мэдээллийг системд оруулсан болон хүлээлгийн дундаж хугацаа



Бичиг баримтын шалгалтын явцад нийт 73 бараанаас 3 ачаа барааны гаалийн мэдүүлэгт алдаа илэрсэн ба ББГУБ алдааг засварлуулахаар ГБМ-нд буцаахад дунджаар 1 цаг 52 минут, ГБМ мэдүүлгийг CEPS программ дээр засварлан CAIS сүлжээгээр илгээхэд дунджаар 6 минут тус тус шаардагдсан байна.


Зураг 86. Авто замын импорт-Гүний терминал: Гааль бичиг баримтыг хүлээж авснаас хойш хянаж эхлэх хүртэлх хүлээлгийн нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр



Мэдүүлэгчээс гаалийн мэдүүлгээр ирүүлсэн мэдээлэл, бичиг баримтыг ББГУБ хүлээн авч шалгаж эхлэх хүртэлх хүлээлгийн хугацаа Монгол Транс терминал дээр дунджаар 1

цаг 35 минут, УБГГ дээр 30 минут байв. ГБМ болон ББГУБ бичиг баримтыг хүлээн авсан үеэс шалгах, бэлтгэх, засварлуулахаар буцаах зэрэг хүлээлгийн үйл явцад гаалийн бүрдүүлэлтийн дийлэнх хугацаа ногдож байгаа тул худалдаанд оролцогч талууд үйл ажиллагаагаа уялдуулан нийцүүлэх, боловсронгуй болгох шийдлийг олох чиглэлээр хамтарч ажиллах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна (Зураг 86).


Зураг 87. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, бараа бүтээгдэхүүний төрлөөр




Тайлбар: 25:54 – 1 өдөр, 1 цаг, 54 минут; 25:48 – 1 өдөр, 1 цаг 48 минут; 33:02 – 1 өдөр, 9 цаг, 2 минут; 26:31 – 1 өдөр, 2 цаг, 31 минут; 44:11 – 1 өдөр, 20 цаг, 11 минут; 37:34 – 1 өдөр, 13 цаг, 34 минут; 32:23 – 1 өдөр, 8 цаг, 23 минут

Гаалийн бүрдүүлэлтийн хугацааг мэдүүлсэн бараа бүтээгдэхүүний төрлөөр авч үзэхэд хамгийн багадаа 1.5 цагаас 4 хүртэлх өдөр үргэжилсэн байна. Тухайлбал, хими, эм, эмийн үйлдвэрийн 2 бараа бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлт хамгийн багадаа 1 өдөр 12 цаг 51 минут, хамгийн ихдээ 4 өдөр 9 цаг 3 минут үргэлжилсэн байна (Зураг 87).

Зураг 88. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн биет шалгалтын дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр



Зураг 89. Авто замын импорт-Гүний терминал: Гаалийн биет шалгалтын дундаж хугацаа, барааны нэр төрлийн тоогоор



Нийт 41 ачаа барааны гаалийн биет шалгалтыг хийж гүйцэтгэхэд дунджаар 2 цаг 6 минут зарцуулсан бөгөөд “Авто тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги” бүтээгдэхүүний төрөлд хамаарах 2 ачаа барааг үзэж шалгахад хамгийн багадаа 7 минут хамгийн ихдээ 1 өдөр, “Бусад” гэж заагдсан бүтээгдэхүүний төрөлд хамаарах 22 ачаа барааг шалгахад хамгийн багадаа 1 минут, хамгийн ихдээ 1 өдөр 21 цаг 3 минутыг тус тус зарцуулсан байна (Зураг 88). Түүнчлэн бараа бүтээгдэхүүний биет шалгалтын үргэлжлэх хугацаа мэдүүлсэн барааны нэр төрлийн тооноос тэр бүр хамаардаггүй байна. Тухайлбал, 1-20 нэр төрлийн 28 ачаа барааг шалгахад дунджаар 2 цаг 52 минут, 100-аас дээш нэр төрлийн 3 ачаа барааг шалгахад 14 минут шаардагдсан байна (Зураг 89). Ачаа барааг гүний ГХБ-ээс гаргахад дунджаар 3.4 цаг болсон ба энэ нь хилийн боомтод бүрдүүлэлт хийгдсэн ачаа барааг ГХБ-ээс гаргах хугацаанаас их байна.


#### 2.2.4. Хилийн боомтоос гүний терминалд авто тээврээр ирсэн ачаа барааг эзэнд нь олгох үйл ажиллагаа

ЦХС-нд сонгогдсон Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтоос авто тээврээр ачигдан ирж гүний гаалийн Монгол Транс терминал дээр эзэндээ олгогдох нийт 63 барааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж холбогдох цаг хугацааг тооцоолсон бөгөөд **дунджаар 3 өдөр 12 цаг 7 минутын** хугацаанд хилийн боомтоос гүн рүү ачигдсан бараа эзэндээ олгогдсон байна.

Алтанбулаг хилийн боомтоос тээвэрлэгдсэн 8 ачаа бараа 4 өдөр 21 цаг 7 минут, Замын-Үүдийн ЧШРТТ терминалаас тээвэрлэгдсэн 3 ачаа бараа дунджаар 1 өдөр 4 цаг 56 минут, Замын-Үүдийн ЧШРТТ-109 терминалаас тээвэрлэгдсэн 52 ачаа бараа дунджаар 15 цаг 34 минутыг гүний гаальд ирэх замын тээвэрт тус тус зарцуулсан байна. Замын-Үүдээс Монгол Транс терминалд хүрэхэд хамгийн багадаа 12 цаг 35 минут, хамгийн ихдээ 2 өдөр 14 цаг 12 минут болсон байна. Сонгогдсон хилийн боомтоос гүний гаалийн Монгол Транс терминал дээр тээвэрлэгдэн ирсэн 63 ачаа бараа дунджаар 1 өдөр 20 цаг 2 (44 цаг 2 минут) минутын хугацаанд тус терминал дээр эзэндээ олгогджээ (Зураг 91).




Зураг 90. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Хилийн боомтоос илгээгдэн гүний терминал дээр ачаа олгогдсон нийт дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Тайлбар: 159:07 – 6 өдөр, 15 цаг, 7 минут; 80:34 – 3 өдөр, 8 цаг, 34 минут; 72:47 – 3 өдөр, 47 минут; 84:07 – 3 өдөр, 12 цаг, 7 минут

Зураг 91. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Гүний терминалын дундаж хугацаа, хилийн боомт, Замын-Үүдийн терминалаар



Тайлбар: 38:07 – 1 өдөр, 14 цаг, 7 минут; 48:01 – 2 өдөр, 2 минут; 58:25 – 2 өдөр, 10 цаг, 25 минут; 45:58 – 1 өдөр, 21 цаг, 58 минут; 44:02 – 1 өдөр, 20 цаг, 2 минут; 111:16 – 4 өдөр, 15 цаг, 16 минут


Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа:

Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа буюу хилийн боомтоос илгээгдсэн тээврийн хэрэгсэл гүний гаалийн Монгол Транс терминалын хашаанд орж ирж бүртгүүлэн, “гаалийн хяналтанд” дардас даруулж хяналтанд орох үйл ажиллагаанд дунджаар 6 цаг 29 минут зарцуулагдсан байна (Зураг 92).

Замын-Үүдийн ЧШРТТ-109 ГХБ-ээс илгээгдсэн ачаа бараа Монгол Транс терминалын хашаанд орж ирснээс хойш дунджаар 1.5 цагаас 14 цаг 45 минутын турш сул зогссоны дараа тээврийн хэрэгслийг бүртгүүлсэн бөгөөд дунджаар 3 өдөр 1 цаг 37 минутын дараа илгээлтийг дагалдах бичиг баримтыг хяналт шалгалтын гаалийн улсын ахлах байцаагч

(ХШГУАБ)-д хүлээлгэн өгсөн байна. ХШГУАБ илгээлтийг дагалдах бичиг баримтыг хянан шалгаж хяналтанд авсан тэмдгэлгээ хийх хүртэлх хамгийн их хугацаа орсон хүлээлгийн цаг нь 18 цаг 10 минут байв.

Зураг 92. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомт, терминалаар



Мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:

Хилийн боомтоос илгээгдсэн нийт 63 ачаа барааны 4.8% буюу 3 ачаа бараа мэргэжлийн хяналтанд хамрагдсан бөгөөд их эрсдэлтэй 1 бараа ургамал хорио цээр, их эрсдэлтэй 1 бараа мал эмнэлэг, хорио цээр, дунд эрсдэлтэй 1 бараа бусад төрлийн хяналтаар ороход дунджаар 1 цаг 20 минут шаардагдсан байна. Ачаа барааны илгээлтийг дагалдах бичиг баримтыг гааль хяналтанд авсан цагаас хойш дунджаар 2 цаг 19 минутын дараа холбогдох бичиг баримтууд мэргэжлийн хяналт дээр ирдэг байна. Мэргэжлийн хяналт бичиг баримтын шалгалт хийхэд дунджаар 5 минут, ачаа барааг буулган биет үзлэгт бэлтгэхэд дунджаар 14 минут, биет үзлэг хийхэд дунджаар 16 минут, хяналтанд хамрагдсан хуудас олгоход дунджаар 6 минут тус тус шаардагдсан байна (Зураг 93).

Зураг 93. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: МХ-ын дундаж хугацаа, үйл ажиллагаагаар




Биет үзлэгийн үеэр мал эмнэлэг, хорио цээрийн 1 бараанаас дээж авч шинжилгээнд явуулсан ба 10 минутын дотор шинжилгээний дүгнэлтийг авчээ. Биет үзлэг болон лабораторийн шинжилгээгээр зөрчил илэрсэн талаарх мэдээлэл бүртгэгдээгүй байна. Бичиг баримтын шалгалтын дараа буюу ачаа барааг биет үзлэгт бэлдэхээс өмнө дунджаар 29 минутын хүлээлгийн буюу сул зогсолтын хугацаа бүртгэгдсэн байна.

Гүний гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:


Алтанбулаг хилийн боомт, Замын-Үүд боомтын ЧШРТТ, ЧШРТТ-109 ГХБ-үүдээс ирсэн ачаа бараанд хийгдсэн гаалийн бүрдүүлэлт дунджаар 1.3 өдөр үргэлжилсэн байна (Зураг 94).

Зураг 94. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Нийт хяналтын дундаж хугацаа, үйл ажиллагаагаар, хилийн боомтоор



Тайлбар: 30:35 – 1 өдөр, 6 цаг, 35 минут; 38:07 – 1 өдөр, 14 цаг, 7 минут; 26:11 – 1 өдөр, 2 цаг, 11 минут; 33:52 – 1 өдөр, 9 цаг, 52 минут; 45:58 – 1 өдөр, 21 цаг, 58 минут


Зураг 95. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр



Тайлбар: 29:13 – 1 өдөр, 5 цаг, 13 минут; 25:50 – 1 өдөр, 1 цаг, 50 минут; 28:03 – 1 өдөр, 4 цаг, 3 минут; 26:31 – 1 өдөр, 2 цаг, 31 минут; 105:03 – 4 өдөр, 9 цаг, 3 минут; 32:50 – 1 өдөр, 8 цаг, 3 минут; 38:52 – 1 өдөр, 14 цаг, 52 минут; 30:35 – 1 өдөр, 6 цаг, 35 минут; 33:52 – 1 өдөр, 9 цаг, 52 минут

Гаальд мэдүүлсэн бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл хүнсний бэлэн бүтээгдэхүүний бүрдүүлэлтэнд дунджаар 5 цаг 14 минут буюу хамгийн бага цаг зарцуулагдсан бол хими, эм, эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний бүрдүүлэлт 4.4 өдөр үргэлжилсэн байна (Зураг 95).

Зураг 96. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр, бүх ачаа бараа



Тайлбар: 1ө 13ц 1м – 1 өдөр, 13 цаг, 1 минут; 1ө 2ц 5м – 1 өдөр, 2 цаг, 5 минут

Хилийн боомтоос тээвэрлэгдэн ирсэн 63 ачаа барааны 65% нь улаан төлөв, 32% нь улбар шар төлөв, 3% нь ногоон төлөвт сонгогдсон бөгөөд эрсдэл өндөртэй гэж үзсэн улаан төлөв бүхий бараа бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хугацаа улбар шар төлөвт сонгогдсон бараа бүтээгдэхүүнийхтэй ойролцоо байна (Гаальд мэдүүлсэн бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл хүнсний бэлэн бүтээгдэхүүний бүрдүүлэлтэнд дунджаар 5 цаг 14 минут буюу хамгийн бага цаг зарцуулагдсан бол хими, эм, эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний бүрдүүлэлт 4.4 өдөр үргэлжилсэн байна (Зураг 95).

Зураг 96).

*Гаалийн мэдүүлэг бэлтгэх:*

Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн тээвэрлэгчээс дагалдах бичиг баримтыг авсанаас хойш дунджаар 7 цаг 49 минутын дараа бараа, бүтээгдэхүүний гаалийн мэдүүлгийн мэдээллийг бэлтгэж эхэлдэг бөгөөд мэдээллийг CEPS программд оруулахад дунджаар 3 цаг 2 минут зарцуулсан ба машин, механик, тоног төхөөрөмж, тэдгээрийн хэрэгсэл бүхий 12 бараа бүтээгдэхүүний мэдээллийг бэлтгэхэд дунджаар 5 цаг 4 минут, хамгийн ихдээ 1.3 өдөр зарцуулсан байна. Нийт 63 бараанаас ганцхан бараанд буюу Замын-Үүдийн ЧШРТТ-109 ГХБ-ээс ирсэн “Бусад” гэсэн ангилалд багтсан бүтээгдэхүүнээс дээж авч шинжилгээнд явуулсан бөгөөд 1.9 өдрийн дотор шинжилгээний дүгнэлт гарсан гэсэн мэдээлэл бүртгэгдсэн.

*Бичиг баримтын шалгалт:*

Бичиг баримтын гаалийн улсын байцаагч (ББГУБ) илгээлтийг дагалдах бичиг баримтыг хүлээн авснаас хойш дунджаар 1 цаг 22 минут, зарим тохиодолд 2 өдрийн дараа шалгаж эхэлсэн бөгөөд дунджаар 59 минутын хугацаанд бичиг баримтыг хянан шалгаж дууссан.

Бичиг баримтыг хянах ажиллагааг гаалийн эрсдэлийн төлөвт хамааруулан авч үзвэл ногоон болон улбар шар төлөвт сонгогдсон барааны мэдүүлгийг дунджаар 5 минутанд, улаан төлөв бүхий 39 барааны мэдүүлгийг 1 минутаас 1.3 өдөр хүртэлх хугацаанд буюу дунджаар 1.5 цагт багтаан шалгасан байна. Бичиг баримтын шалгалтаар “хуванцар болон хаймар, түүгээр хийсэн зүйлс” болон “бусад” бүтээгдэхүүний нэр төрөлд хамаарах 2 барааны мэдүүлэгт алдаа илэрч тэдгээрийг засварлуулахаар буцаахад 2.7 цаг шаардагдсан бөгөөд 18 минутын хугацаанд засварласан мэдүүлгийг хянаж дууссан (Зураг 97).


Зураг 97. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр



*Татвар, хураамж төлөлт:*

Ногоон болон улбар шар төлөв бүхий 21 барааны татварыг 1 минутаас 1 өдрийн хугацаанд буюу дунджаар 4.6 цагийн дотор төлсөн бол улаан төлөвт сонгогдсон 39 барааны татварыг дунджаар 5 минут, зарим тохиолдолд 1.3 цагийн дотор төлж барагдуулсан байна. Улаан төлөвт сонгогдсон зарим барааны терминалын төлбөр 18.5 цагийн дотор төлөгдсөн тохиолдол бүртгэгдсэн ба энэхүү импортлогчоос хамаарсан хугацаа нь гаалийн бүрдүүлэлтийн нийт хугацаанд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна.

Зураг 98. Авто хилийн боомт-Монгол Транс дээр олгогдох: Биет шалгалтын дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр




*Биет шалгалт:*

Ачаа барааг буулган биет шалгалтанд бэлтгэхэд зарим тохиолдолд 19 цаг шаардагдсан бөгөөд нийт 27 ачаа барааг буулган бэлтгэхэд дунджаар 58 минут орсон байна. Улаан төлөв бүхий 37 ачаа бараанд ХШГУБ биет шалгалт хийхэд дунджаар 2.3 цаг шаардагдсан бөгөөд “авто тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги” бүтээгдэхүүний нэр төрөлд хамаарах 2 ачаа барааг шалгахад 7 минутаас 1 өдөр буюу дунджаар 12 цаг 3 минут шаардагджээ (Зураг 98). Биет шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдол бүртгэгдээгүй болно.


Гаалийн улсын ахлах байцаагч тээврийн хэрэгслийн “гарах хуудсан” дээр ГХБ-ээс гарахыг зөвшөөрсөн тэмдгэлгээ хийснээс хойш дунджаар 3.3 цагийн дотор ачаа барааг тээврийн хэрэгсэлд ачин Монгол Транс терминалын хашаанаас гаргасан байна. ГХБ-ээс гарахыг зөвшөөрсөн цагаас хойш Алтанбулаг боомт болон Замын-Үүдийн ЧШРТТ-109 ГХБ-ээс ирсэн зарим ачаа бараа 17.6-21.5 цагийн дараа терминалаас ачаа барааг гаргажээ.

### 3. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Төмөр замаар орж ирсэн импортын ачаа бараа эзэндээ олгогдох үйл ажиллагаа, түүнд зарцуулагдаж буй хугацааг тодорхойлохдоо Замын-Үүд хилийн боомтын Нарийн царигийн шилжүүлэн ачих анги (НЦШАА) гаалийн хяналтын бүс, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар өртөө болон гүүний гаалийн Улаанбаатар төмөр замын Ачиж буулгах, техник экспедицийн механикжсан анги (АБТЭМА) терминалыг төлөөлөл болгон авч үзсэн болно. Төмөр замаар бараа импортлох үйл ажиллагаа буюу (i) Замын-Үүдийн НЦШАА болон Сүхбаатар өртөөнд улсын хилээр оруулсан ачаа барааг өртөөний гаалийн хяналтанд авч гүний АБТЭМА терминал руу шилжүүлсэн; (ii) Замын-Үүдийн НЦШАА, Сүхбаатар өртөөнөөс ирсэн ачаа бараа АБТЭМА терминал дээр эзэндээ олгогдсон; (iii) Замын-Үүдийн авто замын хилийн боомтоор чингэлгээр орж ирсэн ачаа бараа НЦШАА ГХБ дээр төмөр замаар гүний гааль руу шилжүүлэгдэн ачигдаж АБТЭМА терминал дээр эзэндээ олгогдсон гэсэн дэс дарааллын дагуу хилийн боомт, гүний терминал тус бүрийн үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хугацааг тодорхойлсон болно.



Зураг 99. Төмөр зам болон шилжүүлэн ачилтын импортын асуулга судалгааны тоо



Судалгааны хугацаанд Замын-Үүдийн НЦШАА ГХБ болон Сэлэнгэ аймгийн Сүхбаатар өртөөгөөр орж ирсэн нийт 190 ачаа бараа, түүнчлэн авто замын боомтоор чингэлгээр орж ирэн төмөр замаар гүнийн гааль руу шилжүүлэгдэн ачигдсан нийт 36 ачаа барааны мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн ба импортын үйл ажиллагаанд зарцуулагдсан дундаж хугацаа дараах байдлаар гарав. Үүнд:


1. Бараа төмөр замын хилийн боомтоор орж ирэн гүний АБТЭМА терминал дээр эзэндээ олгогдох нийт дундаж хугацаа: **4 өдөр 20 цаг 10 минут**
  - 1.1. Замын-Үүдийн НЦШАА ГХБ-ээр орж ирсэн ачаа бараа АБТЭМА гүний терминал дээр ирж эзэндээ олгогдох дундаж хугацаа: **4 өдөр 16 цаг 18 минут**

- 1.2. Сүхбаатар өртөөгөөр орж ирсэн ачаа бараа АБТЭМА гүний терминал дээр ирж эзэндээ олгогдох дундаж хугацаа: **5 өдөр 19 минут**
2. Төмөр замаар орж ирсэн импортын ачаа бараа АБТЭМА гүний терминал руу ачигдах хилийн боомт, өртөө дэх дундаж хугацаа: **1 өдөр 2 цаг 57 минут**
  - 2.1. Замын-Үүдийн НЦШАА ГХБ-ээс АБТЭМА гүний терминал руу ачигдах хилийн өртөө дэх дундаж хугацаа: **1 өдөр 13 цаг 26 минут**
  - 2.2. Сүхбаатар өртөөнөөс АБТЭМА гүний терминал руу ачигдах хилийн өртөө дэх дундаж хугацаа : **14 цаг 28 минут**
3. Төмөр замаар орж ирсэн импортын ачаа барааны гүний АБТЭМА терминал дах хяналтын дундаж хугацаа: **2 өдөр 9 цаг 40 минут**
  - 3.1. Замын-Үүдийн НЦШАА ГХБ-ээс ирсэн ачаа барааны гүний АБТЭМА терминал дах хяналтын дундаж хугацаа: **1 өдөр 20 цаг 40 минут**
  - 3.2. Сүхбаатар өртөөнөөс ирсэн ачаа барааны гүний АБТЭМА терминал дах хяналтын дундаж хугацаа: **2 өдөр 23 цаг 50 минут**
4. Авто замаар орж ирсэн чингэлэг төмөр замаар шилжүүлэн ачигдаж АБТЭМА гүний терминал дээр ачаа бараа эзэндээ олгогдсон нийт дундаж хугацаа: **3 өдөр 40 минут**
  - 4.1. Авто замаар орж ирсэн чингэлэг НЦШАА ГХБ-ээс гүний АБТЭМА терминал руу шилжүүлэгдэн ачигдах хилийн өртөө дэх дундаж хугацаа: **1 өдөр 16 цаг 40 минут**
  - 4.2. Төмөр замаар шилжүүлэгдэн ачигдсан ачаа барааны АБТЭМА терминал дах хяналтын дундаж хугацаа: **19 цаг 52 минут**

### 3.1. ТӨМӨР ЗАМААР ОРУУЛСАН ИМПОРТЫН БАРАА ГҮНИЙ АБТЭМА ТЕРМИНАЛ РУУ АЧИГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Судалгааны хугацаанд Замын-Үүдийн НЦШАА ГХБ-ээс нийт 100 ачаа бараа, Сүхбаатар өртөөнөөс нийт 90 ачаа бараа АБТЭМА гүний терминал руу илгээгдсэн бөгөөд үүнд дунджаар **1 өдөр 2 цаг 57 минут** зарцуулагджээ (Зураг 100).

Зураг 100. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Хилийн боомтын үйл ажиллагааны дундаж хугацаа




Тайлбар: 37:26 – 1 өдөр, 13 цаг, 26 минут; 26:57 – 1 өдөр, 2 цаг, 57 минут



Замын-Үүдийн НЦШАА ГХБ дэх дундаж хугацаа Сүхбаатар өртөөнөөс ойролцоогоор 23 цаг буюу бүтэн өдрөөр илүү байгаа нь Хятад, Монголын төмөр замын царигийн ялгаатай байдлаас хамаарч сэлгэн ачилт хийгддэгтэй холбоотой юм (Зураг 101).

Зураг 101. Төмөр замын импорт -Хилийн боомт, өртөө: Хилийн боомт дах үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн хяналтын байгууллага тус бүрээр



Тайлбар: 31:12 – 1 өдөр, 7 цаг, 12 минут, 37:26 – 1 өдөр, 13 цаг, 26 минут; 24:27 – 1 өдөр, 27 минут


Хилийн өртөөн дэх төмөр замын хяналтын үйл ажиллагаа:

Хилийн төмөр замын өртөөнд галт тэргийг хүлээн авч гадна үзлэг хийх, бичиг баримтыг хүлээлцэх, орчуулах, мэдээллийг АТМС-ТКС программд оруулахад дунджаар 1 цаг 55 минут шаардагсан ба энэхүү үйл ажиллагаа нь НЦШАА ГХБ дээр дунджаар 2 цаг 10 минут, Сүхбаатар өртөөнд дунджаар 1 цаг 38 минут үргэлжилжээ.

Хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:

Хилийн өртөөнөөс АБТЭМА терминал руу ачигдах нийт импортын барааны 57% нь мэргэжлийн хяналтаар орсон бөгөөд үүнд дунджаар 1.5 цаг зарцуулагдсан бол 3 ачаа барааг 1.5 өдрийн дотор шалгасан байна (Зураг 101).

Зураг 102. Төмөр замын импорт -Хилийн боомт, өртөө: Хилийн мэргэжлийн хяналтын бичиг баримтын шалгалтын дундаж хугацаа, хилийн өртөөгөөр




Гүн рүү шилжүүлэгдэх ачаа бараанд хилийн мэргэжлийн хяналтын байцаагч зөвхөн бичиг баримтын шалгалт хийдэг бөгөөд энэ нь дунджаар 5 минут үргэлжилсэн байна (Зураг 102). ХМХ-ын улсын байцаагч төмөр замын агентаас ачаа барааны бичиг баримтыг хүлээн авснаас хойш дунджаар 0.5 цаг (4 барааг 2 цагаас 1 өдрийн дараа)-ийн дараа шалгаж эхэлдэг байна. Шалгалтаар бичиг баримтын шаардлага хангаагүй 1 тохиолдол бүртгэгдсэн ба импортлогч 0.5 цагийн дотор дутуу бичиг баримтыг гүйцэт бүрдүүлэн өгчээ. Бичиг баримтын шаардлага хангасан ачаа барааны дамжуулан тээвэрлэх мэдэгдэл, хяналтын хуудсыг НЦШАА дээр дунджаар 3 минутанд, Сүхбаатар өртөөн дээр дунджаар 1 цагийн дотор олгосон байна.

Гаалийн хяналтын үйл ажиллагаа:

Төмөр замын өртөө дэх гаалийн хяналтын ажиллагаанд тээврийн болон дагалдах бичиг баримтыг гаалийн хяналтад авах, мэдүүлэгчид өгөх, манифест бичих, шалгах, засварлуулахаар буцаах, манифестийг зөвшөөрч гүний гаальд цахимаар илгээх зэрэг үйл явцууд хамаарна. Хилийн өртөө дэх гаалийн хяналтын ажиллагаанд дунджаар 10 цаг 12 минут шаардагдсан бөгөөд үүнээс Сүхбаатар өртөөд ойролцоогоор 6 цаг үргэлжилсэн бол Замын-Үүдийн НЦШАА дээр үүнээс 2.3 дахин илүү буюу 14 цаг 11 минут үргэлжилсэн нь БНХАУ-аас нарийн царигаар орж ирсэн ачаа барааг өргөн царигийн вагонд шилжүүлэн ачих, үүнтэй холбоотой бичиг баримт боловсруулалтын үйл ажиллагаанаас хамааран сунжирдагтай холбоотой юм.

ГУБ илгээлтийн дагалдах бичиг баримтыг гаалийн хяналтад авсан хугацаа харилцан адилгүй байгаа ба НЦШАА ГХБ-д нийт 97 барааны бичиг баримтанд дунджаар 5 хүрэхгүй минут зарцуулагдсан бол Сүхбаатар өртөөд бараг 2 цаг шаардагджээ (Зураг 103). Мөн ГУБ манифестийг зөвшөөрч бичиг баримтыг тээвэрлэгчид буцаан өгөхөд НЦШАА дээр дунджаар 15 минут зарцуулагдсан бол Сүхбаатар өртөө дээр бараг 2 цаг үргэлжилжээ.

Зураг 103. Төмөр замын импорт -Хилийн боомт, өртөө: Гааль бичиг баримтыг хяналтанд авсан, төмөр замын мэдүүлэгч манифест бичсэн дундаж хугацаа, хилийн боомтоор




Тайлбар: ТЗ-төмөр зам

Манифест бэлтгэх явцад Замын-Үүдийн НЦШАА-д 2 илгээлтийн бичиг баримт шаардлага хангаагүй тул бичиг баримтыг буцаасан, мөн 3 манифест алдаатай бичигдсэн тул ББГУБ алдааг засварлуулахаар буцаахад дунджаар 9 минут шаардагджээ.


Мэдүүлэгч манифест бичих, бичиг баримтыг цаасаар ГУБ-д өгөх, ГУБ тэдгээрийг тулган шалгах зэрэг үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн хугацаа Сүхбаатар өртөөд харьцангуй өндөр гарсан байна. Тухайлбал, Сүхбаатар өртөөний төмөр замын мэдүүлэгч манифестийг CEPS программ дээр бэлтгэн CAIS сүлжээгээр илгээснээс хойш дунджаар 41 минутын дараа бичиг баримтыг ГУБ-д хүлээлгэн өгсөн, ГУБ бичиг баримтыг хүлээн авснаас хойш дунджаар 18 минутын дараа манифестийг шалгаж эхэлсэн ба 17 минутанд хянаж дууссан бол Замын-Үүдийн НЦШАА дээр эдгээр үйл явц нь 5-10 минутын дотор тус бүр үргэлжилсэн байна (Зураг 104).

Зураг 104. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Манифест бичих, шалгах дундаж хугацаа, хилийн боомтоор



Тайлбар: ТЗМ-төмөр замын мэдүүлэгч; б/б-бичиг баримт

Зураг 105. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Вагон шилжүүлэн ачих, ГУБ манифестийг зөвшөөрөх үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомтоор




БНХАУ-аас галт тэрэг нарийн царигаар ирдэг ба ачаатай вагоныг Замын-Үүдийн НЦШАА ГХБ-ээс гүний терминал руу илгээхэд өргөн царигийн галт тэргэнд сэлгэн ачидаг ба нийт 96 ачаа барааг шилжүүлэн ачихад дунджаар 46 минут зарцуулагдсан бөгөөд зарим ачаа барааг шилжүүлэн ачихад 14 цаг орсон байна. Шилжүүлэн ачилттай холбоотой бичиг баримтын боловсруулалт болон нэг байгууллагаас нөгөө байгууллагад бичиг баримтыг цаасаар хүлээлгэн өгөх, тус тусын программд бүртгэл хийх, вагон дугаартай манифестийг дахин шалгах, зөвшөөрөх зэрэг ажиллагаанд дунджаар 11 цаг 36 минут зарцуулагдсан байна (Зураг 105).

Галт тэрэг хилийн өртөөнөөс хөдлөх- төмөр замын үйл ажиллагаа:

Хилийн өртөөнөөс ачаатай галт тэргийг гүний терминал руу илгээхдээ вагоны жин тонныг тооцоолон биечилсэн хуудасны жагсаалтыг гаргадаг бөгөөд төмөр замын эдгээр бэлтгэл ажиллагаа, үйл ажиллагаа хоорондын хүлээлгийн хугацаа ороод Замын-Үүдийн НЦШАА дээр дунджаар 14 цаг 39 минут үргэлжилсэн бол Сүхбаатар өртөөнд 50 минут хүрэхгүй хугацаанд хийгдсэн байна (Зураг 106). Зарим тохиолдолд НЦШАА дээр дээрх ажиллагаа нь 1.3 өдөр хүртэл Сүхбаатар өртөөнд 1.7 цаг хүртэлх хугацаагаар сунжирсан байна.

Зураг 106. Төмөр замын импорт-Хилийн боомт, өртөө: Галт тэрэг хөдлөх хүртэлх төмөр замын үйл ажиллагааны дундаж хугацаа, хилийн боомтоор




### 3.2. ТӨМӨР ЗАМААР ОРЖ ИРСЭН ИМПОРТЫН БАРАА АБТЭМА ГҮНИЙ ТЕРМИНАЛ ДЭЭР ОЛГОГДОХ

Судалгааны хугацаанд Замын-Үүд, Сүхбаатар болон бусад төмөр замын хилийн өртөөнөөс гүний гаалийн АБТЭМА терминал дээр ирсэн нийт 220 ачаа бараа гаалийн хяналтан дор эзэндээ олгогдсон бөгөөд үүнд дунджаар 2 өдөр 5 цаг 51 минут шаардагдсан байна. Харин Замын-Үүдийн НЦШАА ГХБ, Сүхбаатар өртөөнөөс худалдааны бичиг баримтад дагалдан ирсэн судалгааны асуулга хуудас бүхий нийт 82

ачаа бараа АБТЭМА терминал дээр эзэндээ олгогдсон бөгөөд эдгээр ачаа бараанд суурилан дүн шинжилгээ хийлээ.


Ачаа бараа төмөр замаар гүний гаалийн АБТЭМА терминалд ирэхэд Замын-Үүдээс дунджаар 1 өдөр 4 цаг 35 минут, Сүхбаатараас дунджаар 1 өдөр 12 цаг 1 минут шаардагдсан бөгөөд хамгийн багадаа 9.7 цаг, хамгийн ихдээ 3.3 өдөр тээвэрлэгдэн иржээ. Эдгээр 82 бараа АБТЭМА терминал дээр эзэндээ олгогдоход дунджаар **2 өдөр 9 цаг 40 минут** шаардагдсан: Замын-Үүдээс ирсэн 42 бараа дунджаар **1 өдөр 20 цаг 40 минут**, Сүхбаатар өртөөнөөс ирсэн 40 бараа дунджаар **2 өдөр 23 цаг 50 минутын** дотор эзэндээ олгогджээ (Зураг 107).

Зураг 107. Төмөр замын импорт-АБТЭМА: Ачаа бараа гүний терминал дээр олгогдох дундаж хугацаа, хилийн хяналтын байгууллагуудаар



Тайлбар: 25:59 – 1 өдөр, 1 цаг, 59 минут; 44:32 – 1 өдөр, 20 цаг 32 минут; 50:42 – 2 өдөр, 2 цаг 42 минут; 71:50 – 2 өдөр, 23 цаг, 50 минут

Зураг 108. Төмөр замын импорт-АБТЭМА: Гүний терминал дээр эзэндээ олгогдсон бараа бүтээгдэхүүн, хувиар



Замын-Үүдээс ирсэн ачаа бараа хамгийн багадаа 7 цагийн дотор, хамгийн ихдээ 5 өдөр 9 цаг 37 минутын хугацаанд, Сүхбаатар өртөөнөөс ирсэн бараа хамгийн багадаа 1 өдөр

6 цаг 34 минутад, хамгийн ихдээ 5 өдөр 8 цаг 10 минутын хугацаанд АБТЭМА терминалын ГХБ-ээс гарсан байна. Сүхбаатар өртөөнөөс ирсэн ачаа барааны гаалийн бүрдүүлэлтэнд зарцуулагдсан хугацаа Замын-Үүдийнхээс 2 дахин их байна.

АБТЭМА терминал дээр төмөр замаар орж ирсэн нийт барааны 77% нь хүнсний бэлэн бүтээгдэхүүн; аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа; авто тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги; машин механик, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл байв (Зураг 108).


Бүрдүүлэлтийн өмнөх хяналтын үйл ажиллагаа буюу төмөр зам, гаалийн хяналт:

Төмөр замын ажиллагаанд галт тэрэг АБТЭМА терминалд ирсэн, товаарын контор ачаа барааны бичиг баримтыг манифестийн мэдээлэлтэй тулган шалгаж CAIS сүлжээгээр илгээсэн, ГУБ-д бичиг баримтыг хүлээлгэн өгсөн, гааль бичиг баримтыг хяналтад авч товаарын конторт буцаан өгсөн, товаарын контор тээвэр зуучлагч эсхүл импортлогчид бичиг баримтыг хүлээлгэн өгсөн зэрэг ажиллагаанууд хамаарах бөгөөд үүнд дунджаар 14 цаг 7 минут буюу Замын-Үүдээс ирсэн барааны хувьд 11.5 цаг, Сүхбаатараас ирсэн барааны хувьд 16.8 цаг шаардагдсан байна (Зураг 107). Бүрдүүлэлтийн өмнөх хяналтын үйл ажиллагаа нь хамгийн багадаа 1 цаг 5 минут (Замын-Үүдээс ирсэн 2 бараа), хамгийн ихдээ 4.1 өдөр (Сүхбаатараас ирсэн 1 бараа) үргэлжилжээ.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:

Нийт 82 ачаа барааны 34% нь мэргэжлийн хяналтанд хамрагдсан бөгөөд үүний 96% нь дунд эрсдэлтэй, үлдсэн хувь нь буюу 1 бараа их эрсдэлтэй гэж тодорхойлогдсон ба нийт 28 бараанд хийгдсэн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа дунджаар 3.9 цаг үргэлжилсэн байна (Зураг 110). Их эрсдэлтэй бараанд зарцуулагдсан хяналтын хугацаа дунд эрсдэлтэй барааныхаас 7.5 дахин бага байна.


Зураг 109. Төмөр замын импорт-АБТЭМА: МХ-ын дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр, хилийн өртөөгөөр




МХУБ нийт 31 барааны бичиг баримтыг дунджаар 5 минутанд шалгасан байна. Мэргэжлийн хяналт шалгалтын дийлэнх хугацаа биет үзлэг, шалгалтанд ногдож байгаа ба Замын-Үүдээс ирсэн 8 бараанд биет үзлэг хийхэд дунджаар 0.5 цаг зарцуулагдсан бол

Сүхбаатар өртөөнөөс ирсэн дунд эрсдэлтэй 20 хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг шалгахад дунджаар 4 цаг зарцуулагджээ (Зураг 109, Зураг 111).

Зураг 110. Төмөр замын импорт-АБТЭМА: МХ-ын нийт дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр



Зураг 111. Төмөр замын импорт-АБТЭМА: МХ-ын биет үзлэгийн дундаж хугацаа, бүтээгдэхүүнээр



Бичиг баримтын шалгалт хийснээс хойш дунджаар 0.5 цаг, зарим тохиолдолд 1.5 цагийн дараа биет үзлэг хийж эхэлдэг байна. МХУБ нийт 29 барааг гаальтай хамтран шалгасан ба биет үзлэгээр зөрчил илэрсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. Сүхбаатар өртөөнөөс ирсэн 1 хүнсний бэлэн бүтээгдэхүүнээс дээж авч шинжилгээнд явуулсан бөгөөд шинжилгээний хариуг авахад 24 минут шаардагдсан байна.


Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:

Замын-Үүдийн НЦШАА, Сүхбаатар хилийн өртөөнөөс АБТЭМА гүний терминалд төмөр замаар ирсэн 81 ачаа бараа гаалийн хяналт, бүрдүүлэлтээр ороход<sup>58</sup> дунджаар 17

<sup>58</sup> ГБМ бараа, тээврийн хэрэгслийн мэдээллийг CEPS программд оруулж CAIS сүлжээгээр илгээсэн үеэс ГУАБ гарах хуудас дээр ГХБ-ээс гарахыг зөвшөөрсөн үе хүртэлх үйл ажиллагаа хамаарна.


цаг 35 минут шаардагдсан бөгөөд үүн дээр гарах хуудсанд ГУАБ зөвшөөрөл олгосноос хойш тээврийн хэрэгсэл АБТЭМА терминалын хашаанаас гарах хүртэлх хугацааг оролцуулбал дунджаар 1 өдөр 13 цаг 53 минут зарцуулагдсан байна (Зураг 112).

Зураг 112. Төмөр замын импорт-АБТЭМА: Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн дундаж хугацаа, үйл ажиллагаагаар (Замын-Үүд, Сүхбаатар хилийн өртөө)




Гаалийн бүрдүүлэлтэнд зарцуулагдсан цаг хугацааг бараа, бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн; машин механик, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг; авто тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги; хүнсний бэлэн бүтээгдэхүүнд бусад төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад их хугацаа шаардагдсан байна. Замын-Үүдээс орж ирсэн машин механик, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэгийн гаалийн бүрдүүлэлт, шалгалтанд 1 өдөр 15 цаг 5 минут, зарцуулагдсан бол Сүхбаатараас орж ирсэн ижил төрлийн бүтээгдэхүүнд 6 цаг 19 минут буюу 6.5 дахин бага хугацаа шаардагджээ (Зураг 113)

Зураг 113. Төмөр замын импорт-АБТЭМА: Гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр (Замын-Үүд, Сүхбаатар)








Мөн Замын-Үүдээс ирсэн хүнсний бэлэн бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлт, шалгалтанд дунджаар 12.5 цаг зарцуулагдсан бол Сүхбаатараас ирсэн ижил төрлийн бараа бүтээгдэхүүнд 2.2 дахин их хугацаа шаардагдсан байна.

Зураг 114. Төмөр замын импорт-АБТЭМА: Гаалийн эрсдэлийн хувиарлалт ба гаалийн бүрдүүлэлтийн дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр




АБТЭМА терминал дээр эзэндээ олгогдсон нийт 81 барааны 70% нь улаан төлөв, 24% нь улбар шар төлөв, 4.9% нь ногоон төлөвтэй бараа байжээ. Ногоон төлөвтэй ачаа барааны гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаа (ГБМ бараа, тээврийн хэрэгслийн мэдээллийг CEPS программ дээр бэлтгэн CAIS сүлжээгээр илгээсэн үеэс эхлэн ГУАБ гарах хуудас дээр ГХБ-ээс гарахыг зөвшөөрсөн үе хүртэл)-нд дунджаар 20 цаг 50 минут, улбар шар төлөвтэй ачаа бараа дунджаар 10 цаг 32 минут, улаан төлөвтэй ачаа бараа дунджаар 19 цаг 50 минут тус тус зарцуулжээ (Зураг 114). Өөрөөр хэлбэл, ногоон төлөвтэй ачаа барааны гаалийн хяналт, бүрдүүлэлтийн дундаж хугацаа улаан төлвийнхээс их байгаа ба ногоон төлөвтэй ачаа барааг гаалийн хяналтаар оруулахад хамгийн багадаа 1 цаг 4 минут шаардагдсан бол улаан төлөвт үүнтэй ойролцоо хугацаа

буюу 1 цаг 50 минут зарцуулагджээ. Зарим тохиолдолд ногоон төлөвтэй ачаа барааны хяналтын үйл ажиллагаа 2 өдөр 1 цаг 40 минут үргэлжилсэн байна. Бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хамгийн бага (5 цаг 5 минут) болон хамгийн их хугацаа (4 өдөр 5 цаг 43 минут) зарцуулагдсан бүтээгдэхүүний төрөлд хүнсний бэлэн бүтээгдэхүүн орж байна.

ГБМ бичиг баримтыг тээвэр зуучлагч эсхүл импортлогчоос авснаас хойш дунджаар 4 цаг 36 минутын дараа бараа, тээврийн хэрэгслийн мэдүүлгийг CEPS программд оруулсан бол ГБМ мэдүүлгийг CAIS сүлжээгээр илгээснээс хойш ББГУБ дунджаар 5 цаг 39 минутын дараа бичиг баримтыг шалгаж эхэлсэн ба хамгийн багадаа 3 минут хамгийн ихдээ 2.8 өдөр хүлээлгэнд зарцуулагдсан байна.

ГБМ бараа, тээврийн хэрэгслийн мэдүүлгийг CEPS программ дээр бэлтгэн CAIS сүлжээгээр илгээхэд дунджаар 4.5 цаг, ББГУБ бичиг баримтыг шалгахад 0.5 цаг тус тус зарцуулжээ (Зураг 112). Бичиг баримтын шалгалтаар гаалийн мэдүүлэгт алдаа илрээгүй, харин Сүхбаатар өртөөнөөс ирсэн 2 бараа (Хүнсний бэлэн бүтээгдэхүүн, “Бусад” бараа, бүтээгдэхүүн)-ны мэдүүлэг зөрчилтэй гарсан бөгөөд зөрчлийг шийдвэрлүүлэхээр бичиг баримтыг зөрчлийн ГУБ-д шилжүүлсэн байна.


Зураг 115. Төмөр замын импорт-АБТЭМА: Бичиг баримтын бүрдүүлэлтийн дундаж хугацаа, АБТЭМА терминал болон УБГГ-ын бичиг баримт бүрдүүлэлтийн алба



АБТЭМА терминал дээр эзэндээ олгогдсон 81 барааны 90% нь бичиг баримтын бүрдүүлэлт (ГБМ бараа, тээврийн мэдээллийг CEPS программд оруулж эхэлсэн үеэс ББГУБ бичиг баримтыг хянан шалгаж дууссан үе хүртэл)-ийг тус терминал дээр хийлгэсэн бол үлдсэн 10 хувь нь Улаанбаатар хотын гаалийн газар (УБГГ) дээр хийлгэжээ. АБТЭМА терминал дээрх бичиг баримтын бүрдүүлэлт дунджаар 11.4 цаг үргэлжилсэн бол УБГГ дээр 4 цаг болсон байна. Бичиг баримтын бүрдүүлэлтийг хамгийн багадаа 20 минутын дотор, хамгийн ихдээ 2.9 өдөрт хийжээ (Зураг 115).


ХШГУБ нийт 57 улаан төлөв бүхий бараанд дунджаар 0.5 цагийн дотор буюу хамгийн багадаа 5 минутанд, хамгийн ихдээ 3 цаг 10 минутанд биет шалгалт хийсэн байна (Зураг 116).

Зураг 116. Төмөр замын импорт-АБТЭМА: Биет шалгалтын дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр (ЗҮ, Сүхбаатар)



Замын-Үүдээс ирсэн 1 бараанаас дээж авч шинжилгээнд явуулсан бөгөөд лабораторийн дүгнэлтийг авахад 2 өдөр 16 минут шаардагдсан байна. Биет шалгалтаар зөрчил илрээгүй бөгөөд дахин шалгалт хийгдээгүй байна.

Зураг 117. Төмөр замын импорт-АБТЭМА: ГХБ-ээс гарах зөвшөөрөл авсан ачаа барааны терминалын хашаан дах дундаж хугацаа




Ногоон, улбар шар төлөв бүхий нийт 11 бараа холбогдох татвар, хураамжийг төлснөөс хойш дунджаар 4 цаг, хамгийн удаандаа 23.5 цагийн дараа ГХБ-ээс гарах хуудсыг АБТЭМА терминалын контороос авсан байна. ГУАБ гарах хуудас дээр ГХБ-ээс гарахыг зөвшөөрснөөс хойш дунджаар 11.5 цагийн дараа ачаатай тээврийн хэрэгсэл АБТЭМА терминалын хашаанаас гарчээ. Тухайлбал, Замын-Үүдээс ирсэн 42 ачаа бараа хамгийн багадаа 10 минутын дотор, хамгийн ихдээ 23 цагийн дараа; Сүхбаатаар өртөөнөөс ирсэн 39 ачаа бараа хамгийн багадаа 25 минут, хамгийн ихдээ 3 өдөр 21 цаг 23 минутын дараа АБТЭМА терминалын хашаанаас гарсан байна (Зураг 117).

### 3.3. АВТО ЗАМААР ОРЖ ИРСЭН ЧИНГЭЛЭГ ТӨМӨР ЗАМААР ШИЛЖҮҮЛЭГДЭН АЧИГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Замын-Үүдийн авто замын ЧШРТТ-109 терминалаар чингэлгээр орж ирсэн 36 ачаа бараа НЦШАА ГХБ-д галт тэргэнд ачигдан гүний гааль АБТЭМА ГХБ рүү шилжүүлэгдэн ачигдсан ба судалгааны хугацаанд 6 ачаа бараа АБТЭМА ГХБ дээр эзэндээ олгогдсон бөгөөд үүнд дунджаар **3 өдөр 40 минут** зарцуулагдсан байна (Зураг 118).

Зураг 118. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт- Хилийн боомт: Хилээр орж ирсэн барааг гүнийн терминал дээр олгох нийт дундаж хугацаа



Тайлбар: 30:48 – 1 өдөр, 6 цаг, 48 минут; 72:40- 3 өдөр, 40 минут


Сүхбаатар өртөөний хувьд судалгааны хугацаанд авто тээврийн хэрэгслээр орж ирсэн ачаа барааг төмөр замаар гүн рүү шилжүүлэн ачсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

Авто замаар орж ирсэн чингэлэг төмөр замаар гүний гааль руу шилжүүлэн ачигдах үйл ажиллагааны дүн шинжилгээг (i) Замын-Үүдийн ЧШРТТ-109 терминал дах хяналтын үйл ажиллагаа; (ii) Замын-Үүдийн НЦШАА ГХБ дэх шилжүүлэн ачилтын үйл ажиллагаа; (iii) гүний гаалийн АБТЭМА терминал дах хяналтын үйл ажиллагаа гэсэн хэсгүүдэд хуваан авч үзсэн болно.

#### ***(1) Замын-Үүдийн ЧШРТТ-109 терминалын хяналтын үйл ажиллагаа***

Замын-Үүдийн ЧШРТТ-109 терминалаас гүний гааль руу төмөр замаар шилжүүлэгдэн ачигдах нийт 36 ачаа бараа бүртгэгдсэн бөгөөд авто замын терминал дах хяналтын үйл ажиллагаа дунджаар **5 цаг 47 минут** үргэлжилсэн байна (Зураг 119).


Зураг 119. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: ГХБ дэх хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, хяналтын байгууллага тус бүрээр



**Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа:**

Тээврийн хэрэгсэл хүрэлцэн ирэх буюу бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаанд хил хамгаалах байгууллагын ажилтан паспортын шалгалт хийх, гааль тээврийн хэрэгслийг бүртгэн пүүлж, ГХБ-д хуваарилан мэдээллийг CAIS сүлжээнд оруулах зэрэг ажиллагаандууд хамаарч байгаа бөгөөд үүнд дунджаар 18 минут шаардагдсан байна (Зураг 120).

Зураг 120. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагааны дундаж хугацаа, үйл явц тус бүрээр




Тайлбар: ГБӨ- Гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа; ХЦ-Хилийн цэрэг; ТХ-тээврийн хэрэгсэл

**Хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:**

Нийт 36 ачаа барааны 27.7% нь хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдсан бөгөөд үүнд дунджаар 5 цаг 20 минут зарцуулагдсан. Хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдах

гүнийн терминал руу шилжүүлэгдэж буй ачаа бараанд ХМХУБ зөвхөн бичиг баримтын шалгалт хийн шаардлага хангасан тохиолдолд хяналтын хуудас, дамжуулан тээвэрлэх мэдэгдлийг олгодог байна (Зураг 121).

Зураг 121. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: ХМХяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр




Бичиг баримтын шалгалтаар 1 барааны бичиг баримт шаардлага хангаагүй бөгөөд тээвэрлэгч 19 цаг 31 минутын дотор бичиг баримтыг гүйцэд бүрдүүлэн ХМХУБ-д өгсөн байна.

Гаалийн хяналтын үйл ажиллагаа:

Замын-Үүдийн ЧШРТТ-109 терминалд бичиг баримтыг “Гаалийн хяналтад” авах, рентгенээр шалгах, ГХБ-ээс гаргах, бичиг баримтыг дамжуулах зэрэг ажиллагаанд дунджаар 30 минут зарцуулагдсан байна (Зураг 122).

Зураг 122. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-ЧШРТТ-109: Гаалийн хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр



**(2) Замын-Үүдийн НЦШАА ГХБ дэх шилжүүлэн ачилтын үйл ажиллагаа**

Замын Үүдийн ЧШРТТ-109 терминалаас ирсэн 36 ачаа барааг НЦШАА терминалаас гүний гаалийн АБТЕМА терминал руу дунджаар **1 өдөр 6 цаг 48 минутын** хугацаанд шилжүүлэн ачсан байна (Зураг 118).

Зураг 123. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-НЦШАА: Гаалийн хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр




Тайлбар: 25:21 – 1 өдөр, 1 цаг 21 минут

Шилжүүлэн ачилтанд зарцуулагдсан нийт хугацааны 77% нь төмөр замд, 23% нь гаалийн хяналт шалгалтанд тус тус ногдож байна (Зураг 123).

Гаалийн хяналтын үйл ажиллагаа:

НЦШАА дах гаалийн хяналтын ажиллагааны дийлэнх цаг хугацаа гааль бичиг баримтыг хяналтанд авсан үеэс манифест бичүүлэхээр төмөр замын мэдүүлэгчид өгөх хүртэлх хүлээлгийн үе мөн ГУБ манифестийг хянан шалгах ажиллагаанд зарцуулагджээ (Зураг 124).

Зураг 124. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-НЦШАА: Гаалийн хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр




Тайлбар: ТЗМ – Төмөр замын мэдүүлэгч; бб- бичиг баримт

Төмөр замын хяналтын үйл ажиллагаа:

Замын-Үүдийн НЦШАА ГХБ-ээс гүний гаалийн АБТЭМА терминал руу барааг шилжүүлэн ачих төмөр замын үйл ажиллагааны дийлэнх хугацаа ачаа барааг гүний терминал руу илгээгдэх галт тэргэнд ачих, үүнтэй холбоотой бичиг баримтыг боловсруулах, тус тусын программд бүртгэх, бичиг баримтыг цаасаар дамжуулах, төмөр замын оператор вагоны жин, тонны тооцоо, жагсаалтыг гаргах зэрэг ажиллагаанд зарцуулагдсан байна (Зураг 125)

Зураг 125. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-НЦШАА: Төмөр замын хяналтын үйл ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр




Тайлбар: ТЗМ- Төмөр замын мэдүүлэгч; ТЗТК-Төмөр замын тооцооны кассир; ТЗ-Төмөр зам

**(3) Гүний гаалийн АБТЭМА ГХБ дэх хяналтын үйл ажиллагаа**

Судалгааны хугацаанд Замын-Үүдийн НЦШАА хилийн өртөөнөөс ачигдан ирсэн 6 ачаа бараа гүний гаалийн АБТЭМА терминалын ГХБ-д орсон үеэс барааг мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулж эзэнд нь олгоход **дунджаар 19 цаг 52 минут** шаардагджээ (Зураг 126).

Зураг 126. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Гүний ГХБ дэх хяналтын нийт дундаж хугацаа, хяналтын байгууллага тус бүрээр






Бүрдүүлэлтийн өмнөх үйл ажиллагаа буюу төмөр зам, гаалийн хяналт:

Төмөр замын ажиллагаанд галт тэрэг АБТЭМА терминалд ирсэн, товаарын контор ачаа барааны бичиг баримтыг манифестийн мэдээлэлтэй тулган шалгаж CAIS сүлжээгээр илгээсэн, ГУБ-д бичиг баримтыг хүлээлгэн өгсөн, гааль бичиг баримтыг хяналтад авч товаарын конторт буцаан өгсөн, товаарын контор тээвэр зуучлагч эсхүл импортлогчид бичиг баримтыг хүлээлгэн өгсөн зэрэг ажиллагаанууд хамаарах бөгөөд үүнд дунджаар 3.5 цаг шаардагдсан байна (Зураг 126).

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа:

Их эрсдэлтэй гэж тодорхойлогдсон 3 хүнсний бэлэн бүтээгдэхүүн ургамал хорио цээр болон хүнсний чиглэлийн хяналтаар орсон бөгөөд үүнд дунджаар 1 цаг 5 минут шаардагдсан байна (Зураг 126). Бичиг баримтын шалгалтанд дунджаар 22 минут, гаальтай хамтарсан биет үзлэгт 0.5 цаг тус тус зарцуулагджээ. Биет үзлэг хийгдсэнээс хойш дунджаар 19 минутын дараа мэргэжлийн хяналтын улсын байцаагч хяналтанд хамрагдсан хуудсыг олгосон байна (Зураг 127).

Зураг 127. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Мэргэжлийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, хяналтын төрлөөр, ажиллагаа тус бүрээр



Тайлбар: XXX-Хяналтанд хамрагдсан хуудас

Бичиг баримтын шалгалт болоод биет үзлэгээр зөрчил илэрсэн тохиолдол бүртгэгдээгүй ба лабораторийн шинжилгээгээр орсон гэсэн мэдээлэл олдоогүй болно.

Мэргэжлийн хяналтын алба нь гааль болон хилийн хяналтын бусад байгууллагуудтай холбогдсон цахим мэдээлэл, бүртгэлийн системгүйн улмаас ГХБ-д орж ирсэн ачаа бараа, тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг цаг алдалгүй авах, өөрсдийн хяналтын талаарх мэдээллийг бусад байгууллагуудтай хуваалцах, мөн мэргэжлийн хяналтанд зайлшгүй хамрагдах шаардлагатай бараа бүтээгдэхүүн бүрийг алдалгүй хянах нөхцөл боломж хязгаарлагдмал байдаг байна.


Гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа:

Хилийн өртөөнөөс АБТЭМА гүний терминалд шилжүүлэн ачилтаар ирсэн 4 хүнсний бэлэн бүтээгдэхүүн, 2 аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа гаалийн хяналт, шалгалтаар ороход дунджаар 5 цаг 42 минут шаардагдсан байна (Зураг 126).

Шилжүүлэн ачилтаар орж ирсэн 6 бараа бүтээгдэхүүний 83% нь улаан төлөв, 17% нь буюу аж үйлдвэрийн төрөл бүрийн бүтээгдэхүүний төрөлд хамаарах 1 бараа улбар шар


төлөвт сонгогдсон бөгөөд улаан төлөв бүхий бараа бүтээгдэхүүний гаалийн хяналт, шалгалт дунджаар 6 цаг 9 минут, улбар шар төлөвт сонгогдсон бараа бүтээгдэхүүнийх 3.4 цаг тус тус үргэлжилжээ (Зураг 128).

Зураг 128. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Гаалийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, эрсдэлийн төлөвөөр




Гаалийн хяналт, шалгалтын нийт цаг хугацааг авч үзвэл, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн мэдүүлгийн мэдээллийг CEPS программ дээр бэлтгэх, CAIS сүлжээгээр мэдүүлгийг илгээснээс хойш бичиг баримтыг цаасар ББГУБ-д хүлээлгэн өгөх, улаан төлөвт сонгогдсон барааны төмөр замын төлбөрийг төлөх, ачаа барааг буулган биет шалгалтанд бэлтгэх, ачаа барааг тээврийн хэрэгсэлд ачин ГХБ-ээс гаргах зэрэг хүлээлгийн цаг хугацаа харьцангуй өндөр үзүүлэлттэй гарсан бол ББГУБ бичиг баримтыг шалгахад 9 минут, ачаа барааг шалгахад 11 минут зарцуулагдсан байна (Зураг 129).

Зураг 129. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Гаалийн хяналт, шалгалтын дундаж хугацаа, ажиллагаа тус бүрээр



Зураг 130. Төмөр замын шилжүүлэн ачилтын импорт-АБТЭМА: Ачаа барааг тээврийн хэрэгсэлд ачин ГХБ-ээс гаргасан дундаж хугацаа, бүтээгдэхүүний төрлөөр



Тайлбар: ТХ-тээврийн хэрэгсэл; АҮ-Аж үйлдвэрийн бараа

Бичиг баримт болон биет шалгалтаар алдаа, зөрчил илэрсэн, бараа бүтээгдэхүүний дээжээс лабораторийн шинжилгээнд явуулсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

ГУАБ ачаа бараа, тээврийн хэрэгслийг ГХБ-ээс гарахыг зөвшөөрсөнөөс хойш барааг тээврийн хэрэгсэлд ачин гүний гаалийн АБТЭМА терминалаас гарахад дунджаар 1 цаг шаардагдсан байна (Зураг 130).

Төмөр замаар оруулсан импортын нийт дундаж хугацаа (дунджаар 4.8 өдөр) нь авто замаар орж ирэн төмөр замаар шилжүүлэн ачигдсан импортын (дунджаар 3 өдөр) ачаа бараатай харьцуулахад 1.8 өдрөөр их байв. Энэхүү хугацааны зөрүүтэй байдал нь төмөр замаар оруулсан импортын ачаа барааны гүний терминал дах гаалийн хяналт, бүрдүүлэлтэнд зарцуулсан хугацаа болон ачаа барааг ГХБ-ээс гаргахыг зөвшөөрснөөс хойш АБТЭМА гүний терминалын хашаанд байршсан хугацаа зэргээс хамаарчээ. Тухайлбал, төмөр замаар оруулсан импортын гүний гаалийн хяналт, бүрдүүлэлт (дунджаар 1 өдөр 2 цаг)-нд зарцуулсан хугацаа нь шилжүүлэн ачилтын (дунджаар 6 цаг) импортынхоос 4.3 дахин их байгаагаас гадна ачаа барааг ГХБ-ээс гаргахыг зөвшөөрсөн цагаас хойш дунджаар хагас өдөр тухайн терминалын хашаанд сул зогссон бол шилжүүлэн ачилтын импортын ачааны хувьд дээрх сул зогсолтын цаг бүртгэгдээгүй байна.

#### 4. ИМПОРТ, ЭКСПОРТЫН ГЭРЧИЛГЭЭ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОДОГ БАЙГУУЛЛАГУУД: ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Бараа экспортлоход эсхүл импортлоход Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл, гэрчилгээ авах шаардлагатай байдаг бөгөөд энэхүү үйл ажиллагааны ил тод, шуурхай байдал нь гадаад худалдаанд чухал үүрэгтэй ба зарим тохиолдолд худалдаанд саад, тотгор болох ч тохиолдол байдаг байна.

Төрийн болон төрийн бус байгууллагуудаас гэрчилгээ авах процесс ямар хугацаанд хэрэгжиж байгааг тогтоох зорилгоор 17 асуулт бүхий асуулга хуудсаар мэдээлэл цуглуулсан ба МХЕГ, МЭЕГ, СХЗГ болон МҮХАҮТ гэсэн 4 байгууллагын импорт, экспорттой холбоотой гэрчилгээ олгох үйл ажиллагааг авч үзсэн болно. Нийт 78<sup>59</sup> асуулга судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийж холбогдох гэрчилгээ, зөвшөөрөл олгоход шаардагдаж буй дундаж хугацааг байгууллага тус бүрээр тодорхойлсон болно.

Хүснэгт 16. Судалгаанд хамрагдсан байгууллагаас олгож буй гэрчилгээ, судалгааны хугацаанд олгогдсон гэрчилгээний тоо

	Байгууллага	Гэрчилгээ, зөвшөөрлийн төрөл	Олгосон гэрчилгээний тоо
1	Мал эмнэлгийн ерөнхий газар	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	24
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Импортын мэдэгдэл	3
		Экспортын гэрчилгээ	6
		Дамжуулан тээвэрлэх мэдэгдэл	1
3	Стандарт, хэмжил зүйн газар	Тохирлын гэрчилгээ	2
		Экспортын гэрчилгээ	11
4	МҮХАҮТ	Гарал үүслийн гэрчилгээ	40
<b>НИЙТ</b>			<b>87</b>

Зураг 131. Гэрчилгээ, зөвшөөрөл авахад шаардагдах дундаж хугацаа, судалгаанд хамрагдсан байгууллага тус бүрээр



Тайлбар: 50:16 – 2 өдөр, 2 цаг, 16 минут

<sup>59</sup> Нийт бөглөгдсөн 87 асуулга хуудсаас бүрэн бус эсхүл алдаатай бөглөгдсөн судалгааг хассанаар 78 судалгаанд дүн шинжилгээ хийгдсэн.

Асуулга судалгаагаар цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн экспорт, импорттой холбоотой гэрчилгээ олгох ажиллагаанд тулгарч буй нийтлэг асуудлыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:


1. **Гэрчилгээ олгох дундаж хугацаа:** Экспорт, импортын гэрчилгээг дээр дурьдсан 4 байгууллагаас авахад дунджаар 0.5 өдөр шаардагддаг ба МЭЕГ-аас Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг авахад дунджаар 2.1 өдөр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-аас экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл болон дамжуулан тээвэрлэх мэдэгдлийг авахад дунджаар 15 цаг, Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)-аас тохирлын гэрчилгээ, экспортын гэрчилгээ, мөн гарал үүслийн гэрчилгээ авахад дунджаар 0.5 цаг зарцуулагддаг байна. Судалгааны асуулга хуудсыг дээрх байгууллагуудаар бөглүүлсэн бөгөөд зарим тохиолдолд бодит нөхцөл байдлаас харьцангуй бага цаг хугацаа гарсан байх боломжтой юм.
2. **Дагалдах бичиг баримтыг дутуу бүрдүүлж өгөх:** Судалгааны хугацаанд гэрчилгээ гаргуулахаар 4 байгууллагад нийтдээ 87 хүсэлт ирснээс 6 хүсэлтэнд гэрчилгээ олгохыг зөвшөөрөөгүй байна. Худалдаа эрхлэгчдийн зүгээс дагалдах бичиг баримтыг дутуу бүрдүүлж өгөх, бичиг баримт шаардлага хангаагүйн улмаас буцаагддаг байна. Гэрчилгээ, зөвшөөрөл авахад шаардагддаг бичиг баримтын жагсаалт, тэдгээрт тавих шаардлага, гэрчилгээ олгохтой холбоотой үйл ажиллагааны дэс дараалал, шаардагдах цаг хугацааны талаарх мэдээллийг худалдаа эрхлэгч, олон нийтэд ойлгомжтой, ил тод байдлаар хүргэснээр гэрчилгээнд зарцуулагдах хугацаа, зардлыг хэмнэхэд чухал нөлөөтэй юм.
3. **Лабораторийн шинжилгээ, зардал, хугацаа:** Нийт гэрчилгээ олголтын 31% нь лабораторийн шинжилгээний дүгнэлт шаарддаг бөгөөд бараа, бүтээгдэхүүний дээжийг шинжилгээнд өгч лабораторийн дүгнэлт гаргуулахад хамгийн багадаа 2.6 өдөр болдог байна. Экспорт, импорт хийх тоолонд бараа, бүтээгдэхүүний дээжээс шинжлүүлэх нь худалдаа эрхлэгчдийн хувьд зардал, цаг хугацаа шаардсан асуудал байдаг байна.
4. **Гэрчилгээг олгох шат дамжлага:** Гэрчилгээ олгох ажиллагаа нь МЭЕГ-т 5-ээс дээш, МХЕГ-т 3-5 дамжлага, СХЗГ дээр 2-3 дамжлагаар орсны эцэст гэрчилгээ зөвшөөрөгдөн хүсэлт гаргагчид очдог байна. Шат дамжлага болгонд хүлээлгийн хугацаа гардаг бөгөөд энэ нь худалдаа эрхлэх зардлыг нэмэгдүүлж байдаг.
5. **Хүний нөөц, хүрэлцээ:** Төрийн байгууллагуудын хувьд хүсэлт, өргөдлийг хянан судлах ажлыг үндсэн ажлын хажуугаар давхар эрхлэх байдал олонтаа байдаг тул ажлын ачаалал ихтэй үед гэрчилгээ авах өргөдөл бөөгнөрөх, сунжрах асуудал элбэг тохиолддог байна. Хүсэлт, өргөдлийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлснээр олон шат дамжлагыг бууруулах, байгаа нөөц бололцоогоо үр ашигтай ашиглах боломжтой юм.
6. **Цахим системийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага:** Гэрчилгээ авах хүсэлт гаргах, хүсэлт, өргөдлийг хүлээн авах, бүртгэх ажиллагаа цөөн байгууллага дээр цахимаар хийгддэг байна. Ачаалал өндөртэй төрийн байгууллагуудын хувьд гэрчилгээ авах хүсэлтийг цахимаар хүлээн авах, хариу мэдэгдэх мэдээллийн систем нэвтрээгүй тул худалдаа эрхлэгч гэрчилгээ авах хүсэлт, өргөдөл, холбогдох бичиг баримтыг тухайн

байгууллагын бичиг хэргийн газраар дамжуулан цаасан хэлбэрээр хүргүүлдэг. Гэрчилгээ олгохтой холбоотой бүх үйл ажиллагаа цаасаар хийгддэг тул хүсэлт гаргагч тухайн газарт хэд хэдэн удаа биечлэн очих шаардлага тулгардаг байна.

7. **Чиг үүргийн давхардал, мэдээлэл солилцоо:** Нэг байгууллагаас авсан гэрчилгээ, зөвшөөрлийг өөр байгууллагаар баталгаажуулах явдал байдаг тул байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах, ажлын чиг үүргийн давхардлыг арилгах асуудалд анхаарах шаардлагатай байна. Гэрчилгээ, зөвшөөрөл олгох ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж гэрчилгээ олгогч байгууллагуудыг нэгдсэн системд холбосноор нэг бичиг баримтыг өөр өөр байгууллагад өгч шалгуулдаг байдал, үүнтэй холбоотой чирэгдэл, зардал буурахын сацуу байгууллага хоорондын мэдээлэл солилцоо сайжирч, үйл ажиллагааны чиг үүргийн давхардал арилах сайн талтай.

Мал эмнэлгийн ерөнхий газраас Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох ажиллагаа:


Зураг 132. МЭЕГ: ОУМЭГ-ээг олгох дундаж хугацаа, үйл ажиллагаагаар




Тайлбар: бб- бичиг баримт; ХЭ- худалдаа эрхлэгч

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гэрчилгээ олгох үйл ажиллагаа


Зураг 133. МХЕГ: Экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох дундаж хугацаа, үйл ажиллагаагаар






СХЗГ-аас тохирлын гэрчилгээ, экспортын гэрчилгээ олгох ажиллагаа


Зураг 134. СХЗГ: Тохирлын гэрчилгээ, экспортын гэрчилгээ олгох дундаж хугацаа, үйл ажиллагаагаар





МҮХАҮТ-аас гарал үүслийн гэрчилгээ олгох ажиллагаа<sup>60</sup>

Зураг 135. МҮХАҮТ: Гарал үүслийн гэрчилгээ олгох дундаж хугацаа, үйл ажиллагаагаар



<sup>60</sup> МҮХАҮТ нь “Худалдаа аж үйлдвэрийн танхим”-ын тухай хууль /1995/, ГЕГ-тай байгуулсан Санамж бичгийн дагуу экспортын барааны гарал үүслийг гэрчлэн гэрчилгээ олгодог.



## 5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### 5.1. ДҮГНЭЛТ

Цаг хугацааны асуулга судалгаагаар цугларсан мэдээлэлд үндэслэн бараа импортлох, экспортлох үйл ажиллагаанд зарцуулагдаж буй дундаж хугацааг тогтоосны зэрэгцээ, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг худалдааг хөнгөвчлөх чиглэлээр Монгол улсын нэгдсэн орсон олон улсын конвенц, хэлэлцээр, үндэсний хууль тогтоомжийн хүрээнд сайжруулах, уялдуулах боломж нөхцөлийг шинжлэн тодорхойлсон болно.

Цаг хугацааны судалгаа (ЦХС)-ны дүн шинжилгээгээр бараа экспортлох, импортлоход шаардагдаж буй цаг хугацаанд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийн тоонд хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, хүний хүчин зүйлээс хамааралтай ажиллагаа буюу барааг нэвтрүүлэхтэй холбоотой гар ажиллагаагаар хийгддэг хяналтын үйл явц, төрөл бүрийн зөвшөөрөл, шаардлагууд орж байна. Түүнээс гадна хилээс гүнд барааг шилжүүлэн ачих, тээвэрлэхэд хугацаа их орж байна. Судалгааны дүн шинжилгээнээс үзэхэд дараах тарифын бус саад<sup>61</sup> тотгорууд давамгайлж байна. Үүнд:

1. Манай улсад экспорт, импортын барааг улсын хилээр оруулах, гаргахад хил дээр ажиллаж байгаа гааль, мэргэжлийн хяналтын байгууллагууд өөрсдийн чиг үүргийн хуулиудын хүрээнд хяналт, шалгалтыг тус тусдаа гүйцэтгэн явуулж байгаа нь гадаад худалдааны барааг улсын хилээр нэвтрүүлэхэд хүндрэл учруулж байна. Монгол Улс НҮБ-ын “Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц”<sup>62</sup>-д нэгдэн орсноор олон улсын бараа тээвэрлэлтийг сайжруулж, хилээр бараа өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэн, хилийн хяналтыг хэрэгжүүлдэг хяналтын төрөл бүрийн албадын зорилгод хохирол учруулахгүйгээр аль болох уялдуулж, тэдгээрийн үр өгөөжийг бууруулахгүйгээр эрх бүхий албад хяналтыг аль болох нэгэн зэрэг, богино хугацаанд гүйцэтгэх бүхий л арга хэмжээг авах үүргийг хүлээсэн боловч үндэсний хууль тогтоомжийг энэхүү конвенцид нийцүүлэх ажиллагаа хийгдээгүй байна. Иймд экспорт, импортын барааг улсын хилээр оруулах, гаргахад мөрдөгдөж байгаа үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд бодит үнэлгээ өгч, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцтой үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх, уялдуулах шаардлагатай байна;

Гааль, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хамтын ажиллагаа сул, мэдээлэл солилцдоггүй байна. Хил дээр болон гүнд экспорт, импортын бараанд хяналт шалгалт хийх зорилгоор бичиг баримтуудыг

<sup>61</sup> “Тарифын бус хязгаарлалт”-нд Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр хилээр нэвтрүүлэх, лиценз, квотоор тоон хязгаарлалт тогтоох, бусад техникийн болон мал эмнэлэг, эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ зэргийг ойлгоно.

<sup>62</sup> International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods /1982.10.21 өдрийн конвенц, 1985.10.15-ны өдөр хүчин төгөлдөр болсон, Монгол улс 2007 онд нэгдэн орж, соёрхон баталсан, 2007.11.02-ны өдрөөс манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн /Төрийн мэдээлэл Тусгай дугаар боть XII, х. 3445/

өөрсдийн хууль тогтоомжийн дагуу тус бүрдээ гаргуулан авдаг, бүртгэдэг, шинжилгээнд хамруулдаг давхардсан үйл ажиллагаа явагдсаар байна;

2. Монгол Улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуульд “хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх”<sup>63</sup>-ийг хуульчилсан байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна. Импортын барааг улсын хилээр оруулахад гаалийн байгууллага 965 нэр төрлийн бараанд<sup>64</sup>, хилийн мэргэжлийн хяналтын байгууллага их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн 1358 нэр төрлийн бараанд<sup>65</sup> тус тусын лабораторид шинжилгээ хийхийн зэрэгцээ давхардсан шалгалтыг ч хийж байна. Түүнээс гадна их эрсдэлтэй гэж үзсэн бүх барааг мэргэжлийн хяналтын лабораторид шинжилдэггүй байх магадлалтай байна. ЦХС-ны явцад мэргэжлийн хяналт 94, гааль 65 бараанд тус тус лабораторийн шинжилгээ хийжээ.

Хамтарсан шалгалтыг байгууллагууд өөрсдийн үзэмжээр хийдэг, хамтарсан шалгалтын тоо гаалийн газар, терминал бүрт харилцан адилгүй байна. Нөгөө талаас Хилийн тухай хуульд<sup>66</sup> хил болон гүнд ажиллах мэргэжлийн хяналтын болон гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны дарааллыг тогтоосон байгаа нь хамтарсан шалгалт хийх үндэслэл, боломжийг хязгаарлаж байна;

3. Импортын илгээлтийг дагалдах бичиг баримтыг бүртгэх, шалгах зэрэг үйл ажиллагаа нь олон тооны давтагдсан шат дамжлагаар дамжиж цаасан хэлбэрээр хийгдэж байгаа нь импортын үйл ажиллагааг удаашруулахад хүргэдэг байна. Хилийн боомтод болон гүний терминалд барааг экспортод гаргахаар гаалийн хяналтын бүсэд оруулах үеэс эсхүл барааг улсын хилээр оруулж, ГХБ-д оруулсан үеэс эхлэн хийгдэж байгаа бүртгэлийн болон бусад олон үйл ажиллагааг байгууллага бүр гараар, цаасаар давтан хийхэд ихээхэн цаг, цаас зарцуулагдаж, хугацаа, зардлыг өсгөж байна. Энэ хугацааг тээврийн хэрэгслийн төрөл, худалдааны горим тус бүрээр тайланд дэлгэрэнгүй авч үзсэн болно;
4. Тээвэрлэгч нь гаалийн мэдээллийн сүлжээнд холбогдсон байх,<sup>67</sup> мөн тээвэрлэгч нь тээврийн болон худалдааны бичиг баримт, мэдээллийг гаалийн байгууллагад сүлжээгээр гаргаж өгөхөөр Гаалийн тухай хуульд /2008 он/ заасан байгаа хэдий ч тээвэрлэгчид одоо ч дээрх бичиг баримтыг цаасан хэлбэрээр гаальд өгч байна. Түүнчлэн олон улсын агаарын, далайн, төмөр замын, авто тээврийн бичиг баримтууд цахим хэлбэрт (e-BL, e-SMGS, e-CIM, e-CMR, e-ATA, e-CPD зэрэг) шилжээд байна. Агаарын харилцаанд МИАТ компани улсын хилээр гаргах, оруулах ачаа илгээлтэд e-AWB e-manifest-г бүрэн хэрэглэж байгаа ч гаалийн байгууллагад дамжуулан өгөх мэдээллийн технологи программ хангамжийн асуудал шийдэгдээгүй байна;

<sup>63</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хууль /2003 он/-ийн зүйл 4.

<sup>64</sup> ГЕГ-ын даргын тушаал 2019 оны №226 “Сорьц, дээж, загвар авах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”

<sup>65</sup> Монгол Улсын Шадар сайдын тушаал 2014 оны №60 “Жагсаалт батлах тухай”

<sup>66</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль, шинэчилсэн найруулга, 2016, зүйл 17

<sup>67</sup> Гаалийн тухай хууль, 38 дугаар зүйл. Тээвэрлэгч, түүний үүрэг Гаалийн тухай хууль, зүйл 33-34

5. Хилийн боомтууд дээр чингэлэг, автомашин шалгах рентген аппаратын ашиглалтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй байна. Улсын хилээр нэвтрүүлэх экспорт, импортын бараа, тээврийн хэрэгслийг рентген аппаратаар шалгаж байгаа нь сайн хэдий ч гаалийн улсын байцаагч рентген дүрс оношлогоог бусад мэдээлэл, бичиг баримттай харьцуулан бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийх хэлбэрийг сонгох, бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх, дахин шалгалт хийж байгаа нь тодорхойгүй байна. Судалгааны явцад импортын 500 бараа, тээврийн хэрэгсэл рентгенээр шалгагдсан, Цагааннуур (рентгенгүй) боомтод импортын бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн шалгалт хийсэн дундаж хугацаа 57 минут байсан бол Замын-Үүд ЧШРТТ терминалд энэхүү хугацаа 1 цаг 18 минут байв. Түүнчлэн энэхүү рентгений дүрс оношлогооны мэдээллийг хилийн мэргэжлийн хяналтын байгууллагатай хуваалцан, хамтарч ажилладаг бол хяналтын үр дүнд эерэгээр нөлөөлж, хууль ёсны худалдааг дэмжих сайн туршлага болно;
6. Судалгааны ажиглалтаар импортын барааны гаалийн бүрдүүлэлтийг ихэвчлэн гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдээр дамжуулан хийж байсан бөгөөд терминал бүр дээр ажиллаж байсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний тоо харилцан адилгүй, цөөн байснаас мэдүүлэх үйл ажиллагаа хүлээгдэх, удаашрах, олон нэр төрлийн бараа мэдүүлэхэд ихээхэн цаг хугацаа зарцуулагддаг байдал ажиглагдсан. Түүнчлэн хилийн боомтууд дээр импортлогч нь гаалийн зуучлагчтай гэрээ байгуулаагүй (энэ тохиолдолд аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс гаальд мэдүүлэх боломжгүй) гэх үндэслэлээр барааг гаальд мэдүүлэх гаалийн зуучлагч байхгүйгээс худалдаачдад хүндрэлтэй тохиолдлууд цөөнгүй удаа гарч байсан;
7. Хилээр нэвтрүүлэх экспорт, импортын бараанд эрсдэл тооцох үйл ажиллагааг гааль, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагууд өөрсдийн дүрэм журмын дагуу тодорхой хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Хилийн мэргэжлийн хяналтанд хамрагдсан нийт импортын 90% гаруй нь их, дунд эрсдэлтэй ангилалд хамаарч байна. Судалгааны явцад улсын хилээр оруулсан, гаргасан барааны ихэнх нь хилийн мэргэжлийн хяналт болон гүнийн мэргэжлийн хяналтаар ороогүй байх магадлалтай байна.  
Судалгааны явцад нийт импортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн барааны 80% гаруй нь, харин экспортын барааны 70% орчим нь гаалийн хяналтын улаан төлөвт сонгогдсон, хяналтын төлвүүдэд гаалийн хяналтыг хэрэгжүүлсэн цаг хугацааны ялгаа бага, олон тохиолдолд улаан төлөвтэй бараанд хийсэн шалгалтын хугацаа нь ногоон, улбар шар төлөвтэй харьцуулахад богино байсан. Мөн хяналт, бүрдүүлэлтийн явцад илрүүлсэн гаалийн зөрчил нийт бүрдүүлэлтийн 1%-д хүрэхгүй байв. Экспортын бараанд санамсаргүй сонголтоор сонгогдож байгаа эрсдэлийн 3 төлөв хоорондоо огт ялгаагүй, ногоон, улбар шар, улаан төлөвтэй бүх бараанд бичиг баримтын болон биет шалгалтууд бүгд хийгдэж байна. Түүнчлэн ГХБ, боомт бүрт сонгогдож байгаа хяналтын эрсдэлийн төлөвийн хувь хэмжээ, төлөвийн дагуу хяналтыг хэрэгжүүлсэн дундаж хугацаа барааны нэр төрөл, тоо хэмжээгээрээ ялгаатай байсныг тайланд дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Хилийн мэргэжлийн хяналт нь хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах импортын барааны эрсдэлийг зөвхөн барааны нэр төрлөөр их, дунд, бага гэж ангилж тогтоосон байна.

Гаалийн байгууллага нь эрсдэлийн агуулгыг тодорхойлж, дүн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу тусгайлсан эрсдэлийн программаар экспорт, импортын барааны эрсдэлийн төлөвийг гаргаж байна. Мэргэжлийн хяналт, гаалийн байгууллагаас эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч энэ нь худалдаа эрхлэгчдээс сайн дураар хууль сахих явдлыг хөхиүлэн дэмжиж, худалдааг хөнгөвчлөхөд бодит дэмжлэг, үр нөлөөтэй байж чадахгүй байна;

8. Өнөөдрийн байдлаар манайд (эдийн засгийн итгэмжлэгдсэн оператор) итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН) хараахан зарлагдаагүй байгаа бөгөөд ГЕГ-аас итгэмжлэл авсан тээвэрлэгчид барааг гаалийн хяналтан дор гаалийн замаар тээвэрлэлт хийж байна. Итгэмжлэл авсан тээвэрлэгчдийн дийлэнх буюу 63% орчим нь нүүрсний тээвэрлэгчдэд олгогдсон байна. Итгэмжлэл авах хуулийн этгээд нэмэгдсэнээр барааг гаалийн хяналтан дор тээвэрлэх өргөн боломж нээгдэж, тээвэрлэлтийн хугацааг бууруулж, цаг, зардлыг хэмнэх боломжтой юм;
9. Бараа экспортлох, импортлоход Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газраас Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, Экспортын гэрчилгээ, Импортын мэдэгдэл, Дамжуулан тээвэрлэх мэдэгдлийг цаасан хэлбэрээр олгодог бөгөөд барааг бодитоор экспортлох, импортлох үед хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч Мэргэжлийн хяналтын дүгнэлт, Импортын гэрчилгээ, Хяналтад хамрагдсан хуудас зэргийг дахин цаасаар үйлдэж экспортлогч, импортлогчид эсхүл тээвэр зуучид олгож байна;
10. Гааль, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагууд нь өөрсдийн цахим хуудсанд нийтээр дагаж мөрддөг эрхийн актуудыг байршуулдаг хэдий ч бүрэн бус, тогтмол шинэчлэх ажиллагаа хангалттай бус байна. Бараа экспортлох эсхүл импортлоход шаардлагатай практик алхмууд, тэдгээрт шаардагдах маягт, бичиг баримтууд, лавлах цэг, холбоо барих хаяг зэргийг байршуулж, тогтмол шинэчлэх шаардлагатай байна. Дүрэм, журам, зааврыг тухай бүр газар дээр нь нийтэд хүргэх, таниулах, сурталчлах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт хийх зэргээр бодитой, хүртээлтэй арга хэмжээ авдаггүйгээс худалдаа эрхлэгчид олон жил худалдаа наймаа эрхэлсэн хэдий ч тухайн харилцаанд орох эрх, үүргээ мэдэхгүй, ам дамжсан яриагаар хил, гааль дээр харьцдаг байдал ажиглагдсан болно. Хил, гаалийн үйл ажиллагааг ойлгоход хүндрэлтэй байдгаас худалдаачид хугацаа, итгэлээ алддаг тул мэргэжлийн бодит туслалцаа, зөвлөгөө үгүйлэгдэж байна. Тиймээс байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаа, онцлог, чиглэлийг нийтэд түүний дотор төрийн бусад байгууллагуудад сурталчлах, хүргэх чиглэлд тасралтгүй, нээлттэй, бодитой, хамтран ажиллах шаардлагатай байна. Гаалийн байгууллага импортын барааны гаалийн үнэлгээтэй хамааралтай мэдээллийг нийтэд ил тод мэдээлдэггүйгээс импортлогч нарын хувьд тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг үүсгэдэг болохыг судалгааны үед импортлогчид дурьдаж байсан;

11. Улсын хилээр оруулах, гаргах барааны тээвэрлэлтийн үйл ажиллагаа 24 цагаар тасралтгүй явагддаг, ачаа ихэнх тохиолдолд гадаадын эсхүл түрээсийн тээврийн хэрэгсэлд ачигдсан байдаг тул ачааг тээврийн хэрэгслээс тухай бүр салгаж буулгаж байх нь чухал юм. Терминалд хүлээлгийн хугацаа буурахгүй байгаагийн нэг шалтгаан нь тэнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын цаг уялдахгүй байгаатай холбоотой байх боломжтой. 2012 онд хийгдсэн ЦХС-нд энэхүү хүлээлтийн цагийг бууруулах зөвлөмжийг өгсөн хэдий ч энэ чиглэлд дорвитой ажил хийгдээгүй нь энэхүү судалгаагаар батлагдаж байна;
12. Хилийн боомт дээр ялангуяа Замын-Үүдэд мал эмнэлэг, хорио цээр, эрүүл ахуйн хяналтууд бүгд хийгддэг, ажиллаж байгаа мэргэшсэн улсын байцаагч нарын тоо цөөн байдгаас терминал тус бүр дээр хүрч ажиллахад хүндрэл гарч байв;
13. Терминалуудын ажлын ачаалал харилцан адилгүй, бараанд биет үзлэг, шалгалт хийхэд шаардлагатай талбай, ачиж буулгах хэрэгсэл, ачигч нар хүрэлцээтэй ажилладаггүйгээс нэг талаас гааль, мэргэжлийн хяналтын байгууллагаас шалгалт хийхэд, нөгөө талаас бараа хүлээн авагч нь бараагаа шалгуулж авахад хүндрэл гардаг байна. Иймд ГХБ байгуулахдаа гадаад худалдаа, тээврийн хөгжил, шаардлагыг харгалзан, ачааны терминалын үндэсний стандартын шаардлагыг хангуулдаг байх нь зүйтэй байна;
14. Улсын хилээр оруулах, гаргах бараанд хяналт, шалгалт хийж ажиллаж байгаа улсын байцаагч нар, гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн мэргэжлийн мэдлэг, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, ёс зүй харилцаанд анхаарах шаардлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдсан болно.

## 5.2. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн орчинг сайжруулах, худалдааг хөнгөвчлөхөд нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай дараах зөвлөмжүүдийг гадаад худалдаанд оролцогч нийт талууд, түүний дотор экспорт, импортын бараанд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байгууллагуудад санал болгож байна. Зөвлөмж нь үндсэн хоёр багц хэсгээс бүрдэх бөгөөд эхний багц зөвлөмжийн хэсэгт худалдааг хөнгөвчлөх чиглэлээр олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн шинэтгэлийн ажлууд болон практик арга хэмжээг тусгасан бол хоёр дах багц хэсэгт гаалийн хяналт, бүрдүүлэлт, үүнтэй холбоотой хууль тогтоомж, зохицуулалт болоод институцийн чадавхид учирч буй хүндрэлийг шийдвэрлэхэд чиглэсэн ЦХС-ны дотоод ажлын хэсгээс дэвшүүлсэн зөвлөмжийг тус тус хамруулан авч үзсэн болно.

### Багц зөвлөмж-1: Худалдааг хөнгөвчлөх чиглэлээрх олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээний хүрээнд:

- Хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа<sup>68</sup>, үйл ажиллагааг уялдуулах, давхардсан шалгалтуудаас зайлсхийх, хилийн нэгдсэн удирдлагыг тогтолцоог бий болгох;
- Ижил горимд, эрсдэлийн төлөв нь адил нэг нэр төрлийн барааны хяналт, шалгалт, бүрдүүлэлтийн хугацаа нь хилийн боомт, терминал тус бүр дээр харилцан адилгүй байгаад ГЕГ, МХЕГ, МЭЕГ анхаарч үйл ажиллагааг ижилсгэх, бенчмаркинг хийх;
- Хамтарсан шалгалт хэрэгжүүлэх чиглэлээр ГЕГ, МХЕГ-ын хамтарсан тушаал, журам боловсруулан хэрэгжүүлэх;
- Бараа бүтээгдэхүүн бүрээс тогтмол дээж авдаг, шалгадаг өнөөгийн буруу практикийг халж эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гааль, мэргэжлийн хяналтын байгууллагууд цогц байдлаар хэрэгжүүлэх. Чингэхдээ эрсдэлийг хамтарсан байдлаар зөв зохистой үнэлэх, тодорхойлох, зөвхөн өндөр эрсдэлтэй барааг онилж шалгах замаар нөөцийг үр ашигтай хуваарилах нь зүйтэй;
- Биет шалгалтын давтамж, тоог бууруулах үүднээс Эдийн засгийн итгэмжлэгдсэн оператор (ЭЗИО)-ын хөтөлбөрийг боловсруулах ажлыг үргэлжлүүлэх, хэрэгжилтийг хангах; ГЕГ нь ЭЗИО-ын хөтөлбөрт хамрагдсан ААН-ийн жагсаалтыг МХЕГ-тай солилцдог, хүргүүлдэг байх;
- Мэдүүлэгчид барааны тарифын ангилал, гарал үүсэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, гаалийн үнэлгээ зэрэг чиглэлээр урьдчилсан шийдвэр гаргуулах, барааг урьдчилан мэдүүлэх боломжийг бодитоор, өргөнөөр олгох, нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийг нэмэгдүүлэх;

<sup>68</sup> Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, зүйл 8. 8.1.Гишүүн бүр худалдааг хөнгөвчлөх зорилгоор импорт, экспорт, дамжуулан өнгөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьдаг хилийн хяналтын эрх бүхий байгууллага, агентлагийн хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана. /Манай улс “С” ангиллаар нэгдсэн. Хэрэгжих хугацаа: 2023.12.31/

- Илгээлттэй холбоотой хэлцлийн мэдээлэл, бичиг баримтыг гаальд урьдчилан өгөх чиглэлд тодорхой, дэс дараалсан үйл ажиллагаануудыг гадаад худалдаанд оролцогч талуудтай хамтран хийх, шаардлагатай бол мэдээллийг урьдчилан авах нэгдсэн системтэй болоход олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудаас туслалцаа, дэмжлэг авах;
- МХЕГ-ын тодорхой процессууд, түүний дотор хилээр нэвтрүүлэх бараатай холбоотой үйл ажиллагаа, мэдээллийн санг цахимжуулах, үйл ажиллагааг бусад төрийн албадтай ижилсгэх, уялдуулах<sup>69</sup>;
- МХЕГ нь алсдаа хяналт шалгалтаа дунд болон их эрсдэлтэй бараа бүтээгдэхүүнд төвлөрүүлэх үүднээс бага эрсдэлтэй бараа бүтээгдэхүүний бичиг баримтын шалгалтыг ГЕГ-ын зүгээс хийх боломжийг судлах, энэ чиглэлээр хамтран ажиллах;
- Ачаалал өндөртэй хилийн боомт, терминал дах мэргэжлийн хяналтын байцаагчдын тоог нэмэгдүүлэх, хяналтын үйл ажиллагааг автоматжуулах, үүнд чиглэсэн мэдээлэл технологийн тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийх;
- Худалдаа эрхлэгчдийн зүгээс бараа бүтээгдэхүүний ангилалыг буруу, алдаатай тогтоох асуудлыг шийдвэрлэх үүднээс барааг урьдчилан тодорхойлуулах хүсэлтийг цахимаар хүлээн авдаг болох, үүнд тавигдах шаардлага, гаргаж өгвөл зохих мэдээлэл болон загварыг хэвлэн нийтлэх улмаар барааг урьдчилан тодорхойлох практикийг амьдралд бүрэн хэрэгжүүлэх;
- Худалдаа эрхлэгчдийн зүгээс шаардлагатай бичиг баримтыг дутуу өгөх, барааг буруу ангилах зэрэг алдаатай практикийг халах үүднээс мэргэжлийн холбоодтой хамтарсан сургалтуудыг тогтмол зохион байгуулж хууль сахилтын төвшинг дээшлүүлэх;
- Төмөр замын шилжүүлэн ачилтанд зарцуулагдаж буй хугацааг бууруулах үүднээс галт тэрэгний вагоны хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг болно.

### **Багц зөвлөмж-2: ЦХС-ны дотоод ажлын хэсгээс санал болгож буй зөвлөмжүүд:**

#### **1. Эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлд:**

- Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор<sup>70</sup> хүлээсэн үүргээ биелүүлж, үндэсний хууль тогтоомжуудыг тэдгээрт нийцүүлэх;

<sup>69</sup> Одоогийн байдлаар МХЕГ нь экспорт, импорттой холбоотой бичиг баримт, мэдээллийг цаасаар хүлээн авдаг бөгөөд холбогдох цахим системийн хөгжүүлэлтийг АХБ-ын туслалцаатайгаар хийж эхлүүлээд байна.

<sup>70</sup> Монгол улсын 1989 онд нэгдэж, УИХ-с 2007 онд соёрхон баталсан НҮБ-ийн 1982 оны “Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц”-ийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын хяналтын бүх албад мөрдөх үүрэгтэй байдаг тул улсын хилээр нэвтрүүлэх үед бараанд хийдэг гаалийн хяналт, болон бусад хяналтыг уялдуулах асуудлыг шийдвэрлэх. “Бүх улсын хил дээр гааль ажилладаг, түүний үүрэг нь нийтлэг шинжтэй байдгийг харгалзан бусад төрлийн хяналтыг гаалийн хяналттай боломжийн хэрээр уялдуулах ажлыг зохион байгуулна” гэж тус конвенцод заасны дагуу Гаалийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Химийн хортой болон аюултай бодисын тухай зэрэг олон хуулиудад өөрчлөлт оруулж, худалдааг хөнгөвчлөх бодит нөхцөлийг бүрдүүлэх; Энэ ажлыг ХХҮХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3-д заасан (СХЗГ)

- Шинэчлэн найруулж буй Гаалийн багц хуулийн төсөлд хамгийн боломжит дээд хэмжээнд худалдааг хөнгөвчлөхийг дэмжих, ил тод байдлыг хангах, урьдчилан таамаглах боломжит байдлыг сайжруулах зохицуулалтыг Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн<sup>71</sup> дагуу тусган оруулах;
- Эдийн засгийн итгэмжлэгдсэн операторын тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх үүднээс шинэчлэн найруулж буй Гаалийн хуульд холбогдох заалтыг оруулах.

## **2. Төрийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах, хамтран ажиллах чиглэлд:**

- ГЕГ, МХЕГ, МЭЕГ, СХЗГ нь тохирлын баталгаажуулалт, магадлан итгэмжлэгдсэн лабораториудын дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх, лабораторийн магадлан шинжилгээ зайлшгүй хийлгэх экспорт, импортын барааны нэр төрөл, шинжилгээ хийлгэх давтамжийг тогтвортой бууруулах<sup>72</sup>;
- Хилийн боомтуудад ашиглагдаж байгаа рентген аппарат, тоног төхөөрөмжийн үр өгөөжийг дээшлүүлэх, хяналтын бусад байгууллагуудтай мэдээллийг хуваалцах замаар хяналт шалгалтанд зарцуулагдаж буй хугацааг бууруулах;
- Худалдаа, тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, бизнесийг дэмжих зорилгоор байгууллагуудын ажиллах цагийг уялдуулах.

## **3. Эрсдэлийн удирдлагыг хамтран хэрэгжүүлэх:**

- Гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын зүгээс худалдааг хязгаарласан захиргааны шинжтэй шийдвэр гаргах тохиолдол байдаг бөгөөд энэ нь тарифын бус саад тодгорт тооцогддог. Иймд улсын хилээр нэвтрүүлэх экспортын болон импортын барааны эрсдэл, түүний төвшинг худалдааг өргөн хүрээнд хөнгөвчлөх шаардлагыг харгалзан тогтоодог байх;
- Гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хөгжүүлж, хязгаарлагдмал нөөцийг оновчтой удирдаж оюунлаг хяналтыг оновчтой хэрэгжүүлэх:
  - CAIS системд сонгогдсон хяналтын төлөвийн хэрэгжилт хангалтгүй байгаа байдалд үнэлгээ мониторинг хийх;
  - Эрсдэлийн удирдлагыг бүрэн нэвтрүүлэх, олон улсын сайн туршлагад үндэслэн улаан болон өндөр эрсдэлтэй барааны нийт бүрдүүлэлтэнд эзлэх

<sup>71</sup> ДГБ ХХХ-ийг хэрэгжүүлэх нь: Хэлэлцээрийн нэгдүгээр хэсгийг хэрэгжүүлэх заавар,

ШНКК - Ерөнхий Хавсралт бүлэг 1. “Олон улсын худалдааны үйл явцад гаалийн байгууллага чухал үүрэгтэй тул гаалийн байгууллагууд орчин үеийн ажиллах арга барилыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хамгийн боломжит дээд хэмжээнд худалдааг хөнгөвчлөхийг эрмэлзэх нь зүйтэй”

<sup>72</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуульд төрийн байгууллагуудаас хяналтын үйл ажиллагааг (магадлан итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх, давхардсан хяналтаас зайлсхийх) нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхээр заасан байдаг. Түүнчлэн ДХБ-ын Техникийн хориг саадын тухай хэлэлцээр болон олон улсын бусад байгууллагуудын гэрээ хэлэлцээрийн дагуу олон улс, бүс нутгийн итгэмжлэл, стандарт, удирдамж, зөвлөмжийн нөхцөлийг мөрдөхөөр манай улс хүлээн зөвшөөрсөн тул дагаж мөрдөх шаардлагатай байдаг.



хувь хэмжээг шат дараатайгаар бууруулах, гаалийн харилцаанд оролцогчдыг дэмжих, гаалийн хяналтын үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх;

- Бүрдүүлэлтийн дараах шалгалтын үр дүнг эрсдэлийн удирдлагатай уялдуулах;
- Гаалийн болон магадлан итгэмжлэгдсэн бусад лабораториудын шинжилгээний дүн, дүгнэлтээр эрсдэлийн мэдээллийн санг тогтмол баяжуулж, эрсдэлийг удирдах;
- ОХУ болон БНХАУ-тай байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд авч байгаа мэдээлэл, үр дүнг гаалийн эрсдэлийн зорилгоор ашигладаг болох.

#### **4. Байгууллага болон ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлд:**

- Хилийн боомт болон гүний гаалийн газруудын улс хоорондын тээвэрт болон олон улсын худалдаанд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, ажлын ачаалал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн ГХБ-ийг тогтоож, “Ачааны терминал”-ын MNS 5832:2007 стандартыг<sup>73</sup> хангуулах, барааг хяналтад авсан үеэс горимд байршуулж дуусгах хүртэлх үйл явцын цаг хугацаа болон өртөг зардлыг бууруулах<sup>74</sup>;
- Гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн эрэлт, хэрэгцээг тогтоож боомт, терминалын ачаалалд нийцсэн байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 10.6-д<sup>75</sup> “гаалийн зуучлагчаар дамжуулахгүйгээр гаалийн бүрдүүлэлт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор гадаад худалдаанд оролцогчдын чадавхийг бэхжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж, гадаад худалдаа эрхлэгчдэд өөрөө мэдүүлэх нөхцөл, боломж, орчинг бүрдүүлэх;
- Гаалийн газар, хороонд гаалийн улсын байцаагчийн ажлын байрыг богино хугацаанд сольж ажиллуулж байгаа нь байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа тул судалгаа авч үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Улсын байцаагч нар болон гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, ёс суртахууныг мөрдөн ажиллуулах, хөгжүүлэхэд онцгой анхаарах;

<sup>73</sup> Энэхүү стандарт нь улс хоорондын болон хот хооронд тээвэрлэх ачааг хүлээн авах, боловсруулах /савлах, багцлах, ангилах г.м./, хадгалах, түгээх, ачиж буулгах зэрэг үйл ажиллагааг эрхлэх, зохион байгуулахад дагаж мөрдөх нийтлэг журам тогтоох, төр захиргааны болон хувийн байгууллагаас хяналт тавих, ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулдаг. Ачааны терминалд мэргэжлийн чиглэлээр ажиллах хил, гаалийн хяналтын албаны мэргэжилтэн, байцаагч болон тээвэрлэгч, тээвэрлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын инженер, техникийн ажилтан, мэргэжилтэнд хамаарна.

<sup>74</sup> 2012 онд хийгдсэн Бизнесийг дэмжих санаачилга төслөөс хийсэн ЦХС-нд “Гаалийн байгууллага болон үйлчлүүлэгчид, гаалийн терминалуудын хувьд харилцан адилгүй ачаалалтай байна. Томоохон терминалуудын хувьд зохион байгуулалт сайтай боловч үе үе ачаалал ихэсдэг. Гаалийн терминалуудын ачааллыг жигд байлгах нь бүрдүүлэлтэд зарцуулах цаг болон өртөг зардлыг бууруулах талтай” гэж зөвлөмж өгч байжээ. Хэсэг 1 хуудас 7

<sup>75</sup> ХХХэлэлцээрийн энэхүү заалтад “С” ангиллаар нэгдсэн, хэрэгжих хугацаа 2020.12.31

- Дэлхийн Гаалийн Байгууллагын Цаг хугацааны судалгаа (ЦХС)-ны мэдээллийн бааз, энэхүү тайлан, асуулгуудад үндэслэн гааль болон мэргэжлийн хяналтын байгууллагууд үйл явц бүрээр нарийвчилсан судалгааг хийх, цаашид ЦХС хийдэг мэргэшсэн баг бүрдүүлж тогтмол хугацаанд судалгааг зохион байгуулж, зөвлөмжийн хэрэгжилтэнд мониторинг хийж үр дүн, өгөөжийг тооцдог байх, судалгааны үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тусгах;
- ЦХС-ны үр дүнд үндэслэн хийх ажлын жагсаалтыг Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн бусад зүйл, заалтуудтай уялдуулан шинэчлэгдсэн ажлын төлөвлөгөөнд нэмэлтээр оруулж ХХҮХ-ны удирдлага, зохион байгуулалтын хүрээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх.

#### **5. Мэдээллийн технологийг хөгжүүлэх, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх чиглэлд:**

- Гаалийн хяналтын зорилгоор илгээлтийг дагалдах худалдааны бичиг баримтыг бүртгэх, шалгах, баталгаажуулах үйл ажиллагааг цаасаар хийж байгааг цахимжуулах, бичиг баримт, мэдээллийг хил дээр ажиллаж байгаа хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагууд давхардуулан шаардахгүй байх төрийн байгууллагууд хоорондын мэдээллийн солилцооны нэгдсэн цахим сантай<sup>76</sup> болох замаар уг асуудлыг шийдвэрлэх;
- Ачаалал өндөртэй хилийн боомт, терминалууд дах хүлээлгийн хугацааг бууруулах, гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн тасралтгүй ажиллагааг хангах үүднээс цахилгаан, эрчим хүчний асуудалтай холбоотой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

#### **6. Мэдээллийн ил тод байдлыг хангах:**

- Худалдааны нэгдсэн мэдээллийн порталыг<sup>77</sup> бий болгох, барааг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотойгоор мөрддөг хууль, тогтоол, дүрэм, журам, шийдвэр, заавар, зөвлөмж түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр сонирхсон бүх этгээд авах аливаа боломжийг олдоцтой<sup>78</sup> байдлаар бүрдүүлэх;
- Аливаа дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулахын өмнө сонирхогч талуудад төсөлтэй танилцаж, санал өгөх, зөвлөлдөх боломжийг бүрдүүлэх, зохих хугацаа олгох, хүчин төгөлдөр болохоос өмнө аль болох эрт хугацаанд хүргэдэг байх<sup>79</sup>;
- Худалдааг зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагууд нь бараа экспортлох эсхүл импортлоход шаардлагатай практик алхмууд, тэдгээрт шаардагдах маягт, бичиг баримтууд, лавлах цэг, холбоо барих

<sup>76</sup> ХХҮХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.23-д заагдсан байгаа болно.

<sup>77</sup> ОУСК нь ГЕГ болон ХХҮХ-той хамтран Худалдааны нэгдсэн мэдээллийн порталыг бий болгох чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд тус портал нь 2021 оны эхний улиралд ашиглалтанд орох юм.

<sup>78</sup> Шинэчлэн найруулсан Киотогийн конвенц (ШНКК)-ийн Ерөнхий хавсралт бүлэг 9 гаалийн асуудлаар авах мэдээлэл олдоцтой байх нь худалдааг хөнгөвчлөх гол үзүүлэлт гэж үздэг

<sup>79</sup> ШНКК Ерөнхий хавсралт стандарт 3.1., 9.2

хаяг зэргийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулж, тогтмол шинэчлэх.

## **7. Хууль сахин мөрдөлтийг нэмэгдүүлэхэд худалдаа, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах чиглэлд:**

- Гадаад худалдаанд оролцогч талуудад гаалийн эрсдэлийн удирдлага, бизнест үзүүлэх давуу, эерэг талууд, боломжийн талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол, хүртээмжтэй, үр нөлөөтэйгөөр хийх;
- “Гааль-Бизнесийн түншлэлийн Хөтөлбөр”<sup>80</sup>-ийг худалдаанд оролцогч бүх талууд зөвшилцөн боловсруулж хэрэгжүүлэх, тогтмол шинэчилж байх<sup>81</sup>; МХЕГ мөн ижил төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- “Эдийн засгийн итгэмжлэгдсэн оператор”-ын хөтөлбөрийн нөхцөл шалгуурыг хангах бэлтгэл ажлын хүрээнд ГЕГ-аас аж ахуйн нэгжид итгэмжлэл<sup>82</sup> олгохоор эхлүүлсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, талууд харилцан үүрэг хариуцлага, зорилго зорилтдоо нийцсэн эрчимтэй хамтын ажиллагааг өрнүүлэхэд төрийн бусад байгууллага болон хувийн хэвшил, салбарын холбоод, ТББ-тай хамтран ажиллах<sup>83</sup>;
- Тээврийн хэрэгсэл, дэд бүтцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх, хил дээрх саатлыг бууруулах үүднээс гаалийн байгууллагаас тээвэрлэгчид олгож байгаа итгэмжлэлийн<sup>84</sup> хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна. Одоогийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийг эрхэлж байгаа тээвэрлэгчдэд итгэмжлэлийг түлхүү олгож байна. Тээвэрлэгчдийн хууль сахин мөрдөлт, ойлголт мэдлэгийг дээшлүүлэх явдал нь энэхүү үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байна.

---

<sup>80</sup> ШНКК, “Дэлхийн худалдааг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх аюулгүй байдлын багц стандарт”, “Гааль-бизнесийн хөтөч”, “Жижиг дунд бизнест зориулсан Бизнесийн хяналтын загвар хуудас”, Гишүүн орнуудын тэргүүн туршлага /31 орны/

<sup>81</sup> ХХХ-ийн 2.2 заалтад манай улс “А”-р нэгдэж орсон

<sup>82</sup> Уг хөтөлбөр нь гадаад худалдааг хөнгөвчлөх, худалдааны аюулгүй байдлыг хангах, гааль-бизнесийн түншлэлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн. Тус хөтөлбөрт тодорхой шалгуур (хууль сахилт, дотоод хяналтын төвшин сайн байх, санхүүгийн чадавхитай байх, гадаад худалдааны аюулгүй байдлын стандартыг чанд сахих зэрэг) хангасан гадаад худалдаанд оролцогч аливаа аж ахуйн нэгж (худалдаа эрхлэгч ААН, тээвэрлэгч, тээвэр зууч, гаалийн зууч, гаалийн баталгаат бүс эрхлэгч гэх мэт) сайн дураараа хамрагдах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тодорхой хөнгөлөлт үзүүлэхээр журамд заасан байгаа болно.

<sup>83</sup> ХХҮХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.9-д орсон

<sup>84</sup> Улс хооронд болон дотоодод дамжуулан өнгөрүүлэх чадамжийг дээшлүүлэх зорилгоор гаалийн байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан тээвэрлэгчдэд ГЕГ- аас итгэмжлэл олгож байгаа болно. Тайланг боловсруулж байх үед итгэмжлэл олгосон нийт тээвэрлэгчдийн 60% нь нүүрсний экспортод ногдож байв.

## Хавсралт 1. Хилийн хяналтын байгууллагууд, үүрэг оролцоо, хамтын ажиллагаа

1. Шинэ зуунд хил дээр ажилладаг хяналтын байгууллагууд нь өөрийн хязгаарлагдмал нөөцөөр үр дүнтэй үйл ажиллагааг хамгийн боломжит хугацаанд гүйцэтгэж, улс орны аюулгүй байдлыг хангах, төсвийн орлого бүрдүүлэх, хууль сахиулах үүрэг, хариуцлагад нь сөргөөр нөлөөлөхгүйгээр олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд хууль ёсны худалдааг хялбарчлах, хөнгөвчлөхөд чиглэгдсэн хэм хэмжээ, стандартуудыг хэрэгжүүлж, хяналт шалгалтыг явуулахад бизнес эрхлэгчид болон бусад сонирхогч талуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай болсоныг ДГБ<sup>85</sup> онцолж байна. ДГБ-с шинэ зуунд барааг тээврийн хэрэгсэлд ачсан үеэс хянаж, эрсдэлд суурилсан оновчтой хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай болсон; хил дээр ажиллах агентлагууд мэдээллийг өөр хоорондоо солилцож хуваалцахгүй байгаагаас ихээхэн давхардал гарч, худалдаачдыг чирэгдүүлэх явдлыг арилгах шаардлагатай болсон; салангид тусдаа ажиллаж, бие даасан байдлаар тус тусдаа шийдвэр гаргадаг хандлагыг өөрчлөхийг Засгийн газраас гадаад худалдаа эрхлэгчид хүсэн хүлээж байгаа нь хилийн хяналтад нөлөөлөхүйц чухал том өөрчлөлт гэж үзэж байна.
2. Олон улсын худалдааны үйл ажиллагаанд учрах аливаа саад тогторыг түүний дотор хилийн нэгдсэн хяналтыг хэрэгжүүлж, барааг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг хялбарчилж, уялдуулснаар дотоодын эдийн засаг, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмждэг болохыг олон улсын туршлага, судалгаанаас харж болно.
3. Монгол улсын нэгдэн орж, соёрхон баталсан НҮБ-ын “Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц” болон ДГБ-ын Шинэчлэн найруулсан Киотогийн конвенц (ШНКК)-д хилийн хяналтыг уялдуулах, давхардсан хяналт шалгалтаас зайлсхийх, хил дээр ажилладаг байгууллагууд мэдээллийг харилцан дамжуулж хамтарч ажиллахаар заасан байгаа хэдий ч манай улс энэхүү тогтолцоог бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай болсон. Худалдаачид бизнесийн ажил хэргийн хэрэгцээ, шаардлага, хүлээлтэд нийцсэн өөрчлөлт шинэчлэл, дүрэм журам, бодлого, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, харилцан суралцаж, байнгын оролцоотой, тогтвортой хамтын ажиллагаагаар барааг хүний

---

<sup>85</sup> КШК-ийн ерөнхий хавсралт (Стандарт 1.3) “Гаалийн байгууллага худалдаанд оролцогч талуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх болон олон улсын хэлэлцээр, түүнчлэн үндэсний хууль тогтоомжийн заалтад нийцсэн хамгийн үр дүнтэй ажлын аргыг нэвтрүүлэхэд тэдний оролцоог хөнгөвчлөх зорилгоор тэдэнтэй зөвлөлдөх албан ёсны харилцааг бий болгож хөгжүүлнэ.”

Шилжилтийн стандарт 3.32 (Итгэмжлэгдсэн этгээдэд хамаарах тусгай журам)-д “Гаалийн байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан, түүний дотор гаалийн байгууллагын шаардлагыг зохих ёсоор биелүүлж ирсэн, өөрийн худалдааны бүртгэл мэдээллийг хөтлөх аятайхан систем бүхий итгэмжлэгдсэн этгээдэд зориулж гаалийн байгууллага үйлчилгээг үзүүлнэ. Стандарт 6.8 (GA) - “Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг сайжруулах зорилгоор харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахыг эрмэлзэнэ.”

Стандарт 8.5 (GA) – “Гаалийн байгууллага нь гуравдагч талуудыг худалдааны албан ёсны зөвлөлдөх уулзалтад оролцуулах боломжоор хангана.” зэрэг

оролцоо багатайгаар, үр ашигтай, хариуцлагатай, шуурхай, хялбаршуулан нэвтрүүлэхийг шаардах болсон.

4. Хилээр нэвтрүүлэх экспортын болон импортын бараанд эрсдэл тооцох, эрсдэлийг удирдах үйл ажиллагааг гааль, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагууд тодорхой хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.
  - Гаалийн байгууллага нь ДГБ-ын “21 дүгээр зууны гааль” бодлогын баримт бичиг, “Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай” шинэчлэн найруулсан Киотогийн конвенц, “Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх багц стандарт”-ийн хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, Монгол улсын “Гаалийн хяналтын стратеги”, “Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-г баталж, гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.
  - ХМХ-с хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан барааны эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилж<sup>86</sup>, эрсдэлийн шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, эрсдэлийн магадлалыг тооцох шалгуурт үндэслэн их, дунд, бага эрсдэлийг тогтоож<sup>87</sup> улмаар их, дунд, бага эрсдэлтэй барааны жагсаалтыг<sup>88</sup> баталсан байна. Уг тогтоолоор их болон дунд эрсдэлтэй 2194 барааг хилийн мэргэжлийн хяналтад хамруулж<sup>89</sup>, эрсдэл бага гэж үнэлэгдсэн 3550 барааг хяналтад хамруулахгүй байх боломжтой гэж үзжээ.
5. Экспорт, импортын барааг улсын хилээр нэвтрүүлэхэд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж:
  - Монгол улсад экспорт, импортын барааг улсын хилээр оруулах, гаргах үйл ажиллагаанд тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд лиценз, зөвшөөрөл, квот, гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх шийдвэр зэргийг тогтоож байгаа төрийн яамд, ХХЕГ, ГЕГ, СХЗГ, МХЕГ, МЭЕГ-с гадна МҮХАҮТ, тээвэрлэгчид, тээвэр зуучлагч, гаалийн зуучлагч, экспортлогч, импортлогчид оролцож, энэхүү үйл ажиллагааг Үндсэн хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Гаалийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, салбарын тээврийн /авто, төмөр зам/ зэрэг хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журам, заавар<sup>90</sup> зэрэг хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн гүйцэтгэж байна.

<sup>86</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хууль

<sup>87</sup> Засгийн газрын тогтоол. 2014 оны №233 “Шалгуур, үзүүлэлт батлах тухай” /нийт 5744 бараа/

<sup>88</sup> Шадар сайдын тушаал 2014 оны №60 “Жагсаалт батлах тухай”

<sup>89</sup> Их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2194 барааг төлөв байдлын шалгуураар ангилан нийтэд ил тод болгон мэдээлснээр импортлогч өөрийн импортолж байгаа бараа нь аль ангилалд хамаарагдаж, ямар хяналт, шалгалтаар дамжин өнгөрөх нь тодорхой болж, бүх барааг лабораторийн шинжилгээнд хамруулахыг шаардах зэрэг субъектив нөлөөлөл арилж, импортын үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд ихээхэн хөнгөлөлт эдлэх нөхцөл бүрдэнэ гэж үзсэн хэдий ч мэдээлээгүй.

<sup>90</sup> ХМХ-ийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрддөг журмууд: ЗГ-ын тогтоол 2003 оны №173 хавсралт 1,2,3; ЗГ-н тогтоол 2014 оны №233; Шадар сайдын тушаал 2014 оны №60, МХЕГ-ын даргын тушаал 2017 оны А/95, 2019 оны А/81

- ЦХС-нд сонгогдсон гаалийн газар, салбар, терминалуудад төрийн хяналтын байгууллагууд нь өөрсдийн салбарын хууль тогтоомжийг Засгийн газрын 2003 оны тогтоолоор батлагдсан “Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дарааллын дагуу гүйцэтгэж, экспорт, импортын барааг ГХБ-д оруулж эсхүл тэндээс гаргаж, мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулж байна.
6. Гадаад худалдааны барааг улсын хилээр нэвтрүүлэхэд мөрдөгддөг дүрэм журам, бодлого, хөтөлбөр нь өөрчлөгдөж буй шинэ нөхцөлд зохицсон, харилцан үр дүнтэй, ил тод, тунгалаг байх шаардлагатай юм. Гаалийн харилцаанд оролцогчдод хууль тогтоомжийг сайн дураар сахин биелүүлэх боломжийг бүрдүүлэх, хууль тогтоомжийг нээлттэй ил тод болгож, мэдээлэл, зөвлөгөө авах нөхцөлийг бодитоор, хангалттай бүрдүүлэх нь чухал байна. Түүнчлэн худалдааны олон талт болон хоёр талт худалдааны хэлэлцээрүүд, Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засаг, гаалийн салбарын хэлэлцээрүүд нь гааль-бизнесийн түншлэлийг дэмжин өргөжүүлдгийг үндэсний хэмжээнд ашиглах боломжтой юм.
7. Мэдээллийн технологи, тоног төхөөрөмжийн ашиглалт, ил тод байдал:
- Бизнес эрхлэгчид хил дамнасан худалдааг илүү үр ашигтай болгохын тулд мэдээллийн технологийн системийг хөгжүүлэх болсон энэ үед гадаад худалдааны мэдээллийн технологийн үр өгөөжтэй системийг бий болгох, хөгжүүлэхэд нягт хамтран ажиллах нь зүйтэй болж байна<sup>91</sup>. Зөвхөн үнийн нэхэмжлэх (invoice), тээврийн бичиг баримт (bill of lading), баглаа боодлын тодорхойлолт (packing list)-ыг цахим хэлбэрт оруулахад байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллийг ДГБ-с тооцоолжээ<sup>92</sup>.
  - Экспорт, импортын барааг улсын хилээр нэвтрүүлэхэд мэдээлэл, баримт бичгийг бүртгэх, хүргүүлэх, дамжуулах, хяналтад авах ажиллагаануудыг байгууллага бүр тусдаа, цаасан хэлбэрээр голчлон хөтөлж байна.
  - Гаалийн байгууллага нь вэб-д тулгуурласан CAIS /Customs automated information system/<sup>93</sup>, CEPS /Customs External Portal System/ програмуудаар экспорт, импортын бараа, тээврийн хэрэгслийг хянах, мэдүүлэх, шалгах, горимд байршуулах ажиллагааг зохион байгуулж байна. CAIS системээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүхий л ажиллагааг хянах бүрэн боломжтой бол CEPS-д гаалийн зуучлагч, тээвэр зууч, итгэмжлэгдсэн тээвэрлэгч нар ажиллаж, экспорт, импортын барааны гаалийн мэдүүлгийг нөхөн бичиж гаальд мэдүүлэх, манифест бичих, вагон дугаар олгох, өөрчлөх, тээврийн мэдүүлэг бичдэг. Түүний хяналтын

---

ГААЛЬ-ийн өдөр тутумын үйл ажиллагаандаа мөрддөг журмууд: ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан эрх зүйн актын эмхэтгэл <http://www.customs.gov.mn/legal/mcga>

<sup>91</sup> ШНКК Ерөнхий хавсралт, Стандарт 7.3 – “Мэдээллийн технологи нэвтрүүлэх ажлыг шууд нөлөөлөлд өртөж болох холбогдох бүх талуудтай зөвлөлдөнө.”

<sup>92</sup> Худалдааны 3 дээрх бичиг баримтыг цахим хэлбэрт оруулбал 30 настай 22430 ширхэг самрын модыг хэмнэх боломжтой. Энэ нь 330.000 м2 талбай бүхий ойг хамгаалах бөгөөд улмаар 133 тонн хүчилтөрөгч гаргаж, 50 тонн нүүрсхүчлийн хийг шингээх чадвартай.

<sup>93</sup> CAIS- гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих, гаалийн байгууллагад мэдүүлэх, гаалийн бичиг баримт, гаалийн шалгалт, барааг эзэнд нь олгох, гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх цогц үйл ажиллагааг автоматжуулсан систем

бүсийн програмд ачаа орохоос эхлээд гарах хүртэлх үйл ажиллагааг бүхэлд нь хянаж ГХБ-ийн эрхлэгч болон ГУБ ажилладаг.

8. Магадлан шинжилгээ, лаборатори:

- Гаалийн төв лаборатори нь гаалийн хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээг хийх, мансууруулах, сэтгэц нөлөөт бодисыг таньж илрүүлэх зорилго бүхий гаалийн хяналт, шалгалтын явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх үүрэгтэйгээр ажиллаж байна. СХЗГ-аас олгогдсон итгэмжлэгдсэн лабораторийн эрхтэйгээр хар тамхи, мансууруулах бодис; төрөл бүрийн химийн бодис; согтууруулах ундаа; тамхи, тамхин бүтээгдэхүүн; нефтийн бүтээгдэхүүн; ноос, ноолуур, малын гаралтай түүхий эд; хайлуур жонш, эрдэс түүхий эд, хүдэр баяжмал; нэхмэл болон сүлжмэл даавуу, утас ээрмэл бараа бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийдэг. Мөн түүхий нефть болон нефтийн бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, химийн бодис, хар тамхи мансууруулах бодисыг шинжлэх 5 салбар лаборатори<sup>94</sup> хилийн боомтуудад ажиллаж байна. Сорьц, дээж, загвар авах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журмыг ГЕГ-ын даргын тушаалаар баталдаг бөгөөд 2019 оны шинэчлэгдсэн журмаар БТКУС-ын 22, 24, 25-27, 28-39, 50-60 дугаар бүлгийн 965 нэр төрлийн бараанд магадлан шинжилгээ хийхээр болжээ.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь итгэмжлэгдсэн лабораториудын шинжилгээний дүнгийн нийцлийг хянах, маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэх, хүнсний хяналтын лабораториудыг мэргэжил, арга зүй, технологийн удирдлагаар хангах үндсэн үүрэгтэй ажилладаг. Үндэсний лавлагаа лаборатори нь үйл ажиллагаандаа Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, лабораторийн үйл ажиллагааны талаархи үндэсний болон олон улсын стандарт, техникийн зохицуулалт, лабораторийн ажиллах журмыг<sup>95</sup> мөрддөг. Экспорт, импортын их, дунд, бага эрсдэлтэй барааг ХМХ-д хамруулж, Хяналтын хуудсанд заасан хорио цээрийн болон аюулгүйн үзүүлэлтийг тухайн импортын бараанд заасан зөвшөөрөгдөх хэмжээтэй тохирч буй эсэхийг тогтоох зорилгоор лабораториор шинжилдэг байна.

9. Гааль, Мэргэжлийн хяналтын байгууллагууд гадаад худалдаа эрхлэгчдэд өөрсдийн хууль тогтоомжийг сурталчилж, вэбсайтууддаа байршуулж байна.

10. Төрийн байгууллагууд хоорондоо болон ТББ-тай хамтын ажиллагааны “Санамж бичиг”-үүд байгуулан, тодорхой хэмжээнд мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна.

<sup>94</sup> Замын-Үүд дэх гаалийн газрын гаалийн салбар лаборатори, Сэлэнгэ гаалийн газрын Алтанбулаг дахь гаалийн салбар лаборатори, Баян-Өлгий гаалийн газрын Цагааннуур дахь салбар лаборатори, Дорнод дахь гаалийн газрын салбар лаборатори, Сайншанд дахь гаалийн газрын Чойр дахь салбар лаборатори

<sup>95</sup> ЗГ-ын 2013 оны 330 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

11. Гаалийн байгууллагаас Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн, 2018 оны байдлаар 127 тээвэрлэгчид итгэмжлэл<sup>96</sup> олгожээ.

## Монгол улсын гаалийн байгууллага

Монгол улсын гаалийн байгууллага нь гаалийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллага болно.

Монгол улсын гаалийн алба нь гаалийн удирдах төв байгууллага /ГЕГ/ түүний харьяа 18 гаалийн газар, хорооноос бүрддэг. Гаалийн байгууллага нь улсын хилийн авто замын 39, төмөр замын 3, агаарын замын 4, нийт 46 боомтод /үүнээс ОХУ-тай 29, БНХАУ-тай 13 боомтоор тус тус хиллэдэг/, 108 гаалийн хяналтын бүсэд гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, гаалийн хилээр нэвтүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлт хийж байна.



Монгол улсын гадаад худалдааны бараа эргэлт тогтмол өсөн нэмэгдэхийн хэрээр гаалийн байгууллагын улсын төсвийн орлогыг бүрдүүлэх үүргийг төр засгаас чухалчлан үзэж байна. Манай улс 2019 онд дэлхийн 154 улстай 13747.1 сая ам.долларын худалдаа хийснээс 78 улсад бараагаа экспортлож, 153 улсаас гарал үүсэлтэй барааг импортлосон байна.

Гаалийн байгууллага нь худалдааг хөнгөвчлөх, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүргээ хил дээр төрийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бусад байгууллагууд тухайлбал: хил хамгаалах, гадаадын иргэн харьяат, хилийн мэргэжлийн хяналт, стандарт, мал эмнэлэг, ургамал хорио цээрийн зэрэг байгууллагууд болон гадаад худалдааны бараа нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч төр, хувийн хэвшлийн бусад талуудтай нягт хамтран ажиллаж байж ханган биелүүлнэ.

100 гаруй жилийн түүхтэй Монголын гаалийн байгууллага нь ДГБ-ын бодлогын баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа тасралтгүй, тогтмол, үе шаттайгаар хэрэгжүүлснээр шинэ зуунд улс орнуудын гаалийн байгууллагын өмнө тавигдаж байгаа чухал үүрэг болох Сайн засаглал, Хөгжил дэвшил, Нийгмийг хамгаалахад бодит хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна.

<sup>96</sup> ГЕГ-с итгэмжлэл авсан 127 ААН-н 80 гаруй нь нүүрсний тээвэрт байна. <http://customs.gov.mn/2012-03-14-03-21-37/inspection/2012-03-14-03-22-33/2017-10-10-01-08-34/965-2018-04-03>



Монгол улс ДХБ-д 1997 онд элсэж, ДХБ-ын “Худалдааг хөнгөвчлөх” хэлэлцээрт Монгол улс нэгдэн орж, хэлэлцээрийн 12 зүйл, 36 үйл ажиллагааг А, В, С гэсэн гурван ангиллаар хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсний А - 23.5%, В - 36.1%, С - 40.3% байна. Хэлэлцээрийн “7.6 Бараа олгох дундаж хугацааг тогтоож, хэвлэн нийтлэх”-д “С” ангиллаар<sup>97</sup> нэгдэн орсон. Хэлэлцээрийн нийт зүйл, заалтуудын хэрэгжилтийн бараг 98% нь гаалийн байгууллагад хамааралтай гэж ДГБ тооцоолсон байдаг.

ХХХ-ийн хүрээнд импорт, экспортын бараа, түүний дотор дамжин өнгөрөх барааны хөдөлгөөн, гаалийн бүрдүүлэлт, бараа олголтыг түргэсгэх асуудал чухал болж, Монголын гаалийн байгууллагаас гаалийн бүрдүүлэлтийг цахимжуулахад онцгойлон анхаарч, дэмжин бизнес эрхлэгчидтэй хамтран ажилласнаар нийт экспортын гаалийн бүрдүүлэлтийн 40 орчим хувийг цахимаар мэдүүлж байна.

### **Мэргэжлийн хяналтын ерөнхий газар**

Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрхэм зорилго оршдог.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газар зэрэг 11 газартайгаас гадна хилийн боомтуудад мэргэжлийн хяналтын албад ажиллаж Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын тогтоолууд, Шадар сайдын тушаал, МХЕГ-ын даргын тушаалыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, улсын хилээр нэвтрүүлэх бараанд мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлдэг.

Экспорт, импорт, хил хорио цээрийн хяналтын газраас экспортлох эсхүл импортлох мал, амьтан, ургамал, үр тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд экспортын гэрчилгээ, импорт, дамжуулан тээвэрлэх мэдэгдлийг олгодог байна.

---

<sup>97</sup> хэрэгжүүлэх хугацааг 2021.12.31

## Хавсралт 2. Хилийн боомтуудын талаарх товч танилцуулга

### АГААРЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос баруун урд зүгт 14,7 км-ын зайд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр болох Буянт-Ухаад байршдаг Монголын хамгийн том нисэх онгоцны<sup>98</sup> буудал юм. Агаарын тээвэрлэгч компаниуд Москва, Сөүл, Берлин, Станбулын зэрэг 13 чиглэлд тогтмол, Дубай, Бангкок, Дели, Хо-Ши-Мин зэрэг 9 чиглэлд захиалгат нислэгүүдийг 4 D зэрэглэлийн аэродром бүхий тус буудлаас үйлддэг.



ОУНБ-д ажилладаг ГЕГ-ын харьяа Буянт-Ухаа дахь гаалийн газар нь Чингис хаан нисэх онгоцны буудлын карго терминал, нисэх буудал, Катеринг үйлчилгээний төв болон бусад гаалийн баталгаат агуулахуудад ээлжийн зохион байгуулалттайгаар 24 цагийн турш гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулан ажилладаг. Карго терминал дахь ГХБ нь экспортын болон импортын агуулах, гаалийн нээлттэй баталгаат агуулах, үнэт эдлэл, буу зэвсэг, аюултай, түргэн гэмтэх муудах барааны агуулах, хөргүүртэй агуулах зэргээс бүрддэг. ГХБ-д тээвэрлэгч, тээвэр зууч, банк, гаалийн зуучлагч байгууллагуудаас гадна гааль нь хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нартай хамтран барааг экспортлох эсхүл импортлоход хяналт, шалгалт, бүрдүүлэлт хийж ажилладаг.

Тээвэр зуучийн компаниуд нь тээвэрлэгч нараас ачаа илгээлтийн талаар мэдээллийг авч, өөрсдийн гэрээт худалдаа эрхлэгч компани, иргэдэд мэдээллийг өгөх, ачааг хүргэж нийлүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэдэг. ААН, иргэдийн экспорт, импортын барааг гаальд мэдүүлэх үүргийг гаалийн зуучлагч компани нь гэрээний үндсэн дээр өөрийн ГБМ-р дамжуулан гүйцэтгэдэг.

### АВТО ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Монгол Улсын хэмжээнд хилийн боомтын асуудлаар хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээр, Засгийн газрын тогтоолын дагуу нийт 46 боомт ажиллаж байна.<sup>99</sup> Үүнээс олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалттай, байнгын ажиллагаатай

<sup>98</sup> Манай улс олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны зориулалттай агаарын замын Буянт-Ухаа, Өлгий, Чойбалсан, Ховд гэсэн 4 боомттой

<sup>99</sup> ОХУ-тай хиллэдэг хэсэгт 29; БНХАУ-тай хиллэдэг хэсэгт 13; Агаарын замын боомт 4 бөгөөд үүнээс олон улсын ажиллагаатай 14, хоёр талын байнгын ажиллагаатай 11, хоёр талын түр буюу улирлын ажиллагаатай 14, дамжин өнгөрөх 7 боомт байхаар заагдсанаас авто замын 39, төмөр замын 3, агаарын замын 4 боомттой

Замын-Үүд-Эрээний авто зам, Алтанбулаг-Хиагт, Цагааннуур-Ташанта боомтуудаар нэвтрүүлсэн экспортын болон импортын бараанд хамаарах дараах 3 асуулгаар мэдээллийг цуглуулсан.

Манай улс Орос болон Хятад улсуудтай авто тээвэрлэлтийг Азийн авто замын сүлжээний АН 3 буюу Эрээн - Замын-үүд Алтанбулаг-Хиагт; АН 4 Ташанта - Улаанбайшинт маршрутаар гүйцэтгэж байна.



Монгол улсын өмнөд хилийн Замын-Үүд авто замын боомт<sup>100</sup> нь нийслэл Улаанбаатар хотоос 780 км зайд оршдог БНХАУ-тай хиллэдэг авто замын томоохон боомт болно. Монгол улсын хойд хаалга болсон Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт байдаг Алтанбулаг боомт нь Улаанбаатараас 345 км-ын зайтай зайтай бол Улаанбайшинт боомт нь Монгол улсын баруун хэсэгт орших Баян-Өлгий аймгийн Цагаануур суманд оршдог.



Эдгээр боомтуудад ажиллах Замын-Үүд дэх гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Алтанбулаг салбар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Цагаануур салбарууд нь хөрш ОХУ, БНХАУ-ын Засгийн газартай байгуулсан Хэлэлцээрт заасан цагийн хуваарийн дагуу ажиллаж, тэнд ажиллах хил, ХМХ, гаалийн ажилтанууд Монгол улсын Хилийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль зэрэг хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр боомтуудад мөн тээвэрлэгчид, тээвэр зууч, банк, гаалийн зуучлагч байгууллагын ГБМ нар холбогдох дүрэм журмын дагуу ажиллаж байна.

<sup>100</sup> 1926 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Байцаан өнгөрүүлэх салбар” нэртэйгээр байгуулагдсан. БНХАУ-тай хилийн боомтын асуудлаар байгуулсан хэлэлцээрийн дагуу 1992 оны 04 сарын 01-ний өдрөөс олон улсын авто замын боомт болсон.

## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Манай улс далайд гарцгүй тул улс хоорондын төмөр замын тээвэрлэлт чухал ач холбогдолтой байдаг. Улс хоорондын төмөр замын ачааны тээвэрлэлтийг хөрш орнуудын болон бусад төмөр замын сүлжээг ашиглан Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр /ОАХХ/, Төмөр замын тээврийн тухай хууль, “Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм”<sup>101</sup>-ийн хүрээнд зохион байгуулж байна. Энэхүү ОАХХ-ийн дагуу олон улсын ачааны харилцаанд нээлттэй Замын-Үүд-Эрээн, Сүхбаатар-Наушки, Эрэнцав-Соловьевск өртөөдөөр байнгын ачаа тээвэрлэлт хийгддэг.





---


<sup>101</sup> ЗТХС-ын сайдын 2018 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан

### Хавсралт 3. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны технологийн дэс дарааллын зураглал


#### 1. Авто тээврээр оруулсан импортын ачаа бараа Замын-Үүдийн ЧШРТТ дээр олгогдох









## 2. Авто тээврээр оруулсан импортын ачаа бараа Замын-Үүдийн Э-Транс дээр олгогдох













### 3. Авто тээврээр оруулсан импортын ачаа бараа Алтанбулаг дээр олгогдох










#### 4. Авто тээврээр оруулсан импортын ачаа бараа Цагааннуур дээр олгогдох















## 5. Авто тээврээр оруулсан ачаа бараа гүний терминал руу илгээгдэх







## 6. Хилийн боомтоос авто замаар бараа экспортлох (Замын-Үүд)













## 7. Авто тээврээр гарах “захиалга дуудлага”-ын экспорт

















